**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХШҮ-НИЙ ТАЙЛАН**
**2022 ОНЫ ЖИЛИЙН ЭЦЭС**

2023 оны 01 дүгээр сарын 10 Номгон

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | 2023 оны зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Нэгдсэн дүгнэлт | Үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1. НЭГ. “КОВИД-19” ХАЛДВАРТ ЦАР ТАХЛААС ҮҮДЭЛТЭЙ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХҮНДРЭЛИЙГ ДАВАН ТУУЛАХ БОДЛОГО | | | | | | | |
| 1 | 1.1.1. Аймгийн нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг “Ковид-19” вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 1. Коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 100 | Цар тахлын үеийн салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангах зорилгоор Баянхонгор аймгийн Гамшгаас хамгаалах “Команд штаб”-ын сургуулиар танхимын сургалтаар удирдах бүрэлдэхүүн 50 албан тушаалтан, цахим хэлбэрээр гамшгаас хамгаалах 14 албаны 140 албан тушаалтан, 20 сумын мэргэжлийн ангийн 260 албан тушаалтан нийт 450 албан тушаалтанг хамруулсан бөгөөд бэлэн байдлын үзлэгийг аймгийн удирдах бүрэлдэхүүн 50, гамшгаас хамгаалах 14 албаны 140 томилгоот бүрэлдэхүүн, 40 гаруй нэгж, техник хэрэгсэл, 185 багаж зэвсэглэмж, хүн нэг бүрийн бэлтгэл бэлэн байдлыг шалгаж, Онцгой байдлын Ерөнхий газраас тус аймгийн Гамшгаас хамгаалах “Команд штабын сургуулийн бэлтгэл ажилд 98 хувь буюу “А” яаралтай цуглар дохиогоор ажилласан байдалд 98.6 буюу “А”, Штабын дадлагын нөхцөл байдалд 96.6 хувь буюу “А”, нийт сургуулийн үйл явц бэлтгэл бэлэн байдалд 96.4 хувь буюу “Дүүрэн хангалттай” гэж дүгнэгдсэн. Мөн цар тахлын ногоон түвшинд шилжсэнтэй холбогдуулан аймгийн Засаг даргын 2022 оны А/143 дугаар захирамжаар тус аймгийн хэмжээнд бүх төрлийн аюулт үзэгдэл, техникийн холбогдолтой осол, хүн, мал, амьтны гоц халдварт өвчинтэй тэмцэх, хариу арга хэмжээг удирдлага, зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулалтаар хангах, салбар дундын харилцан ажиллагааг шуурхай зохицуулах зорилгоор “Төв штаб”-ын бүтцийг шуурхай бүлгийн бүтэц бүрэлдэхүүнд шилжүүлж, албадын бэлтгэл бэлэн байдлыг хангуулсан. | |
| 2 | | 2. Аймгийн Засаг даргын нэрэмжит бэлтгэл, бэлэн байдлын үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | | 95 | Аймгийн Засаг даргын 2021 оны А/690, 2022 оны А/249 дүгээр захирамжаар Богд, Хүрээмарал, Эрдэнэцогт, Заг сумдад аймгийн Засаг даргын нэрэмжит гамшгаас хамгаалах тухай хууль тогтоомжийн бэлэн байдлын үзлэгийг зохион байгуулж, дээрх сумдын гамшгаас хамгаалах мэргэжлийн анги, сайн дурын хэсэг, аж ахуй нэгж, байгууллагуудын бэлтгэл, бэлэн байдлыг хангуулсан болно. | |
| 3 | 1.1.2. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, халдваргүйжүүлэх бодис, тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй нэмэгдүүлж, нөөцийг бүрдүүлнэ. | 1. Шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн нөөц бүрдүүлэх | 2021 - 2024 | | 95 | Эрүүл мэндийн яам, Азийн хөгжлийн банк, ЭМСХХ-5 хамтарсан төслийн хүрээнд 2021 онд Нэгдсэн эмнэлэгт ариутгал халдваргүйтгэлийн тасгийн их засвар, 13 нэр төрлийн тоног төхөөрөмжийн шинэчлэлт нийт 770.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдсэн. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ, худалдан авах тухай хуулийн дагуу эм, эмнэлгийн хэрэгслийн худалдан авах ажиллагааг зохион байгуулан салбарын хэмжээнд нийт 2 тэрбум 175 сая төгрөгийн татан авалт хийж эм зүйн тусламж үйлчилгээг хүргэн ажиллаж байна. 2022 оны байдлаар эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц 3-6 сарын нөөцийг бүрдүүлсэн. Зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 85.0 хувьтай. Амин чухал эмийн хангамж 93.0 хувьтай байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 790 сая төгрөгийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хамгаалах хэрэгсэл, урвалж оношлуур нийлүүлэгдсэн. Нэгдсэн эмнэлэгт 2022 онд хандив тусламж, олон улсын байгууллага, улсын төсөв, орон нутгийн төсвөөс нийт 2.3 тэрбум төгрөгийн тоног төхөөрөмж, түүнийг дагалдах хэрэгслүүд нийлүүлэгдэж эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмж сайжирсан. | |
| 4 | 1.1.3. Иргэдэд коронавирусийн | 1. Коронавирусийн халдвараас | 2021 - | | 90 | Тус аймагт коронавируст халдвар 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн байдлаар өнгөрсөн 24 цагт 4 (хүүхэд-0, насанд хүрэгчид-4) | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | халдвараас урьдчилан сэргийлэх  ажлыг эрчимжүүлэн зохион байгуулна. | урьдчилан сэргийлэх олон талт арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2024 | | | тохиолдол нэмэгдэж, нийт 17491 (хүүхэд-4508, насанд хүрэгчид-12782) тохиолдол батлагдснаас 17372 иргэн эдгэрч, 47 иргэн нас барсан бөгөөд тусгаарлах эмнэлэгт нийт 67 иргэн хэвтэн эмчлүүлж байгаагаас эмнэлзүйн шинж тэмдгээр 39 иргэн хөнгөн, 4 иргэн хүндэвтэр, 2 иргэн хүнд, 2 иргэн нэн хүнд байна.<br>Дархлаажуулалтын ажлыг зохион байгуулах, эрчимжүүлэх талаар аймгийн Засаг даргын 4 удаагийн захирамжийг гаргуулан, хэрэгжилтийг хангаж ажилласан бөгөөд Улсын Онцгой комиссоос өгсөн үүрэг, чиглэлийн дагуу тус аймгийн хэмжээнд 3 дугаар тунгийн хамрагдалыг нэмэгдүүлэх зорилгоор аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар сарын 22-ны өдрийн “Коронавирусын халдвараас урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэх аян зарлах тухай” А/655 дугаар захирамжийн хүрээнд “Дархлаажуулалтандаа хамрагдаж, эрүүл мэндээ хамгаалцгаая” уриатай 2 сарын аяныг эхлүүлэн, тус аяны хүрээнд 15 ажлыг төлөвлөн, 3 үе шаттай хэрэгжүүлэн ажиллаж байна. Аяны хүрээнд урлаг, спорт, үзвэр үйлчилгээний байгууллагуудад дархлаажуулалтын талаар зөвлөмжийг хүргүүлж, иргэд, олон нийтийн төвлөрдөг 5 цэгт дархлаажуулалтын ач холбогдол, дархлаажуулалтын цэгүүдийн хэвлэмэл хуудсыг байршуулж, төрийн байгууллагын 300 орчим албан хаагчдад “Дархлаажуулалтын ач холбогдол, түүний үр дүн” сэдэвт танхимын сургалтыг зохион байгуулсан. Мөн аймгийн Онцгой комиссоос сумдын Онцгой комисст дархлаажуулалтын ажлыг эрчимжүүлж, аяныг үр дүнтэй зохион байгуулах талаар болон вакцины 3 дугаар тунгийн хамрагдалтыг эрчимжүүлэх “Бид вакцины бүрэн тундаа хамрагдсан хамт олон” челленж болзолт уралдааныг аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй төрийн болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгжүүдийн дунд зохион байгуулж байгаа бөгөөд 37 төрийн байгууллагын 319 ажилтан, албан хаагч нар дархлаажуулалтын 3-р тунд бүрэн хамрагдсан байна. | |
| 5 | 1.1.4. “Ковид-19” вирусийн | 1. “Ковид-19” вирусийн | 2021 - | | "Бага" | "Ковид-19” вирусийн халдварын эрсдэлийн үнэлгээг 2021 онд аймгийн Онцгой байдлын газар, Эрүүл мэндийн газар, бусад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | халдварын салбар дундын эрсдэлийн үнэлгээг хийж, үр дүнг тооцох | 2024 | | | мэргэжлийн байгууллагуудтай хамтран салбар дундын оролцоотойгоор 2 удаа хийж, “Өндөр эрсдэлтэй” гэж үнэлэгдсэн. Эрсдэлийн үнэлгээнд тулгуурлан хүний нөөц, эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хувцас хэрэгслийн бэлэн байдлыг хангаж, иргэдэд халдвараас сэргийлэх мэдээллийг олон нийтийн мэдээллийн сувгуудаар тарааж, зөвлөгөө өгөх 70442464, 70440006 дугаарuудыг тогтмол ажиллуулан шаардлагатай арга хэмжээг шуурхай төлөвлөн, бэлэн байдлыг хангаж ажилласнаар эрсдэлийн түвшнийг 60 хувиар бууруулсан. 2022 оны байдлаар Ковид-19 цар тахлын халдварын тархалт буурч, ногоон түвшинд байгаатай холбоотой эрсдэлийн үнэлгээ хийх шаардлагагүй байна. | |
| 6 | | 2. Аймгийн Онцгой комиссын Шуурхай штабыг байгуулж гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудыг нэгдсэн удирдлагын тогтолцоонд шилжүүлэх | 2021 - 2024 | | 90 | Коронавируст халдвар болон мал амьтны гоц халдварт “Шүлхий” өвчний аюулаас урьдчилан сэргийлэх, хамгаалах үйл ажиллагаа, өвөлжилт, хаваржилтын нөхцөл байдал зэрэг цаг үеийн тулгамдсан асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газрын тогтоол, Онцгой комиссын хуралдаанаас гарсан хурлын тэмдэглэл, тогтоол, тушаал, албан даалгавар, үүрэг, Онцгой байдлын ерөнхий газрын даргын тушаал, албан даалгавар, үүрэг чиглэлүүдийг удирдлага болгон аймгийн Онцгой комиссын хуралдааныг нийт 95 удаа хуралдуулан холбогдох шийдвэрийг гарган хурлын тэмдэглэл 95, аймгийн Засаг даргын захирамж 88, Онцгой комиссын даргын тушаал 16, нийт 199 эрх зүйн баримт бичгийг боловсруулан гаргаж, гамшгаас хамгаалах болон халдварт өвчинтэй тэмцэх үйл ажиллагааг шуурхай зохион байгуулан ажиллаж байна. Мөн үүссэн нөхцөл байдалтай холбогдуулан аймгийн Онцгой комиссын “Шуурхай штаб”-ын бүтцийг 2 удаа шинэчилж, холбогдох дүрэм, журмын дагуу шуурхай бүлгийн бүтэц, бүрэлдэхүүнд шилжүүлэн ажилласан. | |
| 2. ХОЁР. ХҮНИЙ ХӨГЖИЛ | | | | | | | |
| 7 | 2.1.1. Нотолгоонд суурилсан | 1. Анхан шатны 24 нэгжийн эрүүл | 2021 - | | 90 | Анхан шатны нэгжүүдээс 2021 онд тоног төхөөрөмжийн судалгаа авч, нэгтгэн дунд хугацааны хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оношлогоо эмчилгээний уламжлалт болон орчин үеийн анагаах ухааны дэвшилтэт техник технологийг нэвтрүүлж, иргэдэд орон нутагтаа нарийн мэргэжлийн оношлогоо, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлнэ. | мэндийн төвийн лабораторийн тоног төхөөрөмжийг шинэчлэх | 2024 | | | тусгаж хэрэгжилтийг хангахаар ажилласан. Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2021 оны 6/23 дугаар тогтоолоор батлагдсан Эрүүл мэндийн тоног төхөөрөмжийг сайжруулах арга хэмжээний хүрээнд Улсын төсвийн 208.0 сая төгрөгийн санхүүжилтээр анхан шатны 12 сум, өрхийн эрүүл мэндийн төвийг гематологийн болон биохимийн бүрэн автомат анализатороор /цусны дэлгэрэнгүй, элэгний үйл ажиллагааны шинжилгээ/ хангасан. Ингэснээр анхан шатны нэгжүүдийн лабораторийн тусламж үйлчилгээнд шаардлагатай тоног төхөөрөмжийн шинэчлэлт 68 хувьтай хийгдэж, үр дүнд нь хөдөөгийн иргэдийн оношилгоо шинжилгээний хүлээгдэл чирэгдэл буурсан байна. | |
| 8 | | 2. Уламжлалт-сэргээн засах төвийг шинээр зохион байгуулан, шаардлагатай багаж хэрэгслээр хангаж, тусламж үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 3000 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн сэргээн засах, уламжлалт эмчилгээний тасагт 2021 онд уул уурхайн “Эрдэнэмонгол” ХХК-аас 10.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалт хийгдэж, 9 нэр төрлийн багаж хэрэгслээр хангаж, тусламж үйлчилгээндээ ашиглаж байна. Уламжлалт эмчилгээний тасгийг түшиглэн ахмад настны сэргээн засах эмчилгээний 4 ортой палатыг ажиллуулж эхэлсэн. Уламжлалтын тасгийн хэвтэн эмчлүүлэгчдийн 80 нь ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг ба 140 гаруй ахмад настан, дотрын тасагт 673 ахмад настан хэвтэн эмчлүүлж, 90 хувь нь биеийн эрүүл мэнд сайжирсан үзүүлэлттэй байна. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд уламжлалт, сэргээн засах эмчилгээг төрөлжүүлэн хөгжүүлж, анхан шатны нэгжүүдэд кабинет байгуулан иргэдэд тусламж үйлчилгээг үзүүлж байна. 2022 онд уламжлалт сэргээн засах эмчилгээнд 4145 иргэн, хэвтэн эмчлүүлэх тасгаар 503 иргэн бариа засал, зүү төөнүүр, бумба, цахилгаан зүү зэрэг 18 нэр төрлийн тусламж үйлчилгээнд хамрагдсан. Уламжлалт сэргээн засах эмчилгээний багаж, тоног төхөөрөмжийн хангалт 85 хувьтай, эмч сувилагч мэргэжилтний хүрэлцээ хангамж 70 хувьтай байна. Цахилгаан зүү, улитра зивук, цахилгаан бумба, цахилгаан төөнүүр, имфра улаан туяа, массажны сандал зэрэг шинэ эмчилгээний төрлүүдийг нэмэгдүүлсэн. Цаашид Нэгдсэн эмнэлэгт хөдөлгөөн засалч, хөдөлмөр засалч, хэл засалч мэргэжлээр хүний нөөцийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бэлтгэхээр ажиллаж байна. | |
| 9 | | 3. Зүрх судасны эмгэгийн тасаг зохион байгуулан, зүрхний шигдээсийн үеийн эмчилгээг хийж хэвшүүлэх | 2021 - 2024 | | 16.1 | Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2021 онд Засаг даргын нөөцөөс зүрхний холтер ЭКГ аппарат нийлүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт зүрх судасны тасгийг 2021 онд нээж, зүрх судасны оношилгоо, эмчилгээ үйлчилгээг иргэдэд үзүүлж, үйл ажиллагаа нь хэвийг явагдаж байна. 2022 оны байдлаар зүрхний шигдээсээр эмнэлэгт нас баралтын 1 тохиолдол бүртгэгдэж, зүрхний шигдээсээр оношлогдож, 3-р шатлалын эмнэлэгт хүргэгдсэн 3 иргэн байна. Зүрхний шигдээсний шалтгаант нас баралтын түвшин 2022 онд (0-74 насны 10 000 хүн амд) 0-74 насны 88028 хүнээс зүрхний шигдээсний шалтгаанаар 20 хүн нас барж, 0-74 насны 10 000 хүн амд 2.27 болж өнгөрсөн оноос буурсан байна. Нийт нас баралт 2022 оны жилийн эцсийн байдлаар 446 тохиолдол бүртгэгдсэнээс 167 хүн буюу 34.5 хувь нь зүрх судасны өвчнөөр нас барж, 10 000 хүн амд 19.6 байгаа нь өнгөрсөн оны түвшинд байна. Зүрхний шигдээсний үеийн эмчилгээ буюу бүлэн хайлуулах эмчилгээг нэвтрүүлэх чиглэлээр НЭ-ийн зүрхний их эмч С.Наранбаатар санаачлан төсвийн тооцоо, үйл ажиллагааны өртгийг тооцоолсон ч нэг өвчтөнд үүсэх төсөвт өртөг өндөр, үр дүнгийн судалгааны дүгнэлт хангалтгүй учраас шийдвэрлэгдээгүй байна. | |
| 10 | | 4. Уушигны дурангийн оношилгооны чиглэлээр хүний нөөцийг бэлтгэн, тусламж үйлчилгээнд нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 3.9 | Нэгдсэн эмнэлгийн Уушгины нарийн мэргэжлийн эмч 2021 онд бэлтгэгдсэн. Эрүүл мэндийн яамнаас Амьсгалын аппарат 4 ширхгийг нийлүүлсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэг нь Эрүүл мэндийн яамны 136.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар уушгины эмгэгийн оношилгоо эмчилгээнд ашиглагдах дурангийн аппараттай болсон. Уушги судлалаар дээшлүүлэх курст Нэгдсэн эмнэлгийн 1 эмчийг мэргэшүүлсэн. Уушги судлалаар суралцсан эмчийг 2023 оны хичээлийн жилд уушгины дурангийн эмчээр бэлтгэхээр төлөвлөөд байна. Цаашид уушгины дурангийн оношилгоог тусламж үйлчилгээнд нэвтрүүлэхээр ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 11 | | 5. Вирус судлалын лабораторийг шинээр нээх | 2022 - 2024 | | 15 | Халдварт өвчин судлалын үндэсний төвд 2021 онд их эмч 2, лаборант 3, вирус судлалын чиглэлээр 5 мэргэжилтэн бэлтгэгдсэн. Вирус судлалын лабораторид 26313 иргэнд шинжилгээ хийсэн. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт молекул биологийн лабораторийг 2020 оны 06 дугаар сараас эхлэн ашиглалтад оруулж, үйл ажиллагаа нь хэвийн явагдаж байна. Лабораторийн эмч болон сувилагчийг сургаж чадавхжуулан, ажиллах орчин нөхцөл, шаардлагатай тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. 2022 оны байдлаар томуугийн вирусийн болон PCR шинжилгээнд 2200 хүн орж, орон нутагтаа оношилгоонд хамрагдаад байна. | |
| 12 | | 6. Элэгний В вирустай эхчүүдээс төрсөн нярай бүрт Гепабиг эмчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 150 | Аймгийн хэмжээнд 2021 онд элэгний В вирусийн халдвартай эхээс төрсөн 51 нярайд иммуноглобулин эмчилгээ хийсэн. Жирэмсний хяналтад байгаа эхчүүд В, С илрүүлэг шинжилгээнд 710 буюу 100 хувьтай хамрагдаж, В вирусийн 50, С вирусийн 14 тохиолдол илрүүлж, элэгний В вирустэй 50 эх, 41 нярайг иммуноглобулинд хамруулсан. 2022 онд С вирустэй 14 эх, ВД вирустэй 4 эх төрж, 29 эх вирусийн идэвхжил тоолуулсан. Жирэмсэнд Эрүүл мэндийн сайдын 318 дугаар тушаалын дагуу хяналт хийж, эрт илрүүлэгт хамруулж байгаа нь өвчлөлийг эрт илрүүлэх, эхээс урагт төрөлхийн тэмбүү болон элэгний В, С вирус дамжихаас урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой байна. Элэгний В вирустэй эхчүүдээс төрсөн нярайд 12 цагийн дотор В вирусийн эсрэг вакциныг хийхээс гадна, Эрүүл мэндийн сайдын А/614 дүгээр тушаалын дагуу иммуноглобулиныг нярайд хийж, тусламж үйлчилгээ үзүүлсэн. Нэгдсэн эмнэлгийн төрөх тасагт 2022 оны байдлаар 64 нярайд 12 цагийн дотор, 1 нярайд 24 цагийн дотор В вирусийн эсрэг вакцин хийж, эмчилгээ үйлчилгээний стандартыг мөрдөн ажилласан. | |
| 13 | 2.1.2. Эрэгтэйчүүдэд чиглэсэн эрүүл мэндийн тусламж үйлчилгээний | 1. Цэргийн насны 18-25 насны эрчүүдийг үзлэг шинжилгээнд хамруулж, | 2021 - 2024 | | 200 | 2021 онд цэргийн насны 2000-3000 залуучуудыг эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулж, илэрсэн өвчлөлийг харьяа сум, өрхийн Эрүүл мэндийн төв эмчлэн эрүүлжүүлж ажилласан. 2021 оны цэрэг татлагаар аймгийн 20 сумдаар нарийн мэргэжлийн эмч нар явж үзлэг хийж, 19-25 насны 1023 залуучуудыг хамруулсан. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чанарыг сайжруулж, тэдний эрүүл мэнддээ тавих анхаарлыг нэмэгдүүлж, ажиллах боловсон хүчнийг бэлтгэн, төрөлжсөн үйлчилгээ үзүүлэх орчинг бүрдүүлж, “Эрүүл чийрэг эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | өвчлөлийг илрүүлж, эрүүлжүүлэх | | | | Үүнээс: дотрын өвчин-144, шүдний өвчин-79, мэдрэл, сэтгэц-208, нүдний өвчин-87, чих хамар хоолой-246, мэс засал, гэмтэл-251, арьс харшил-254 өвчин бүртгэгдсэн байна. Архаг хууч өвчтэй иргэнийг сум, өрхийн эрүүл мэндийн хяналтад шилжүүлж, шинээр бүртгэгдсэн өвчлөлүүдийг 2,3-р шатлалд онош тодруулж, эмчлэн эрүүлжүүлсэн. Цэрэг татлагын үзлэгийг 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрөөс 10 дугаар сарын 12-ны өдрийн хооронд зохион байгуулж, аймгийн Нэгдсэн эмнэлгийн 8 хүний бүрэлдэхүүнтэй баг ажилласан. Цэрэг татлагын үзлэгт нийт 974 цэргийн насны залуучууд хамрагдсанаас 649 буюу 66.6 хувь нь өвчний учир тэнцээгүй байна. Нийт хамрагдсан иргэдээс давхардсан тоогоор 901 өвчлөл бүртгэгдсэн. Өвчлөл тус бүрээр харуулбал: дотрын өвчлөл - 178, шүдний өвчлөл - 46, мэдрэл сэтгэц - 135, нүдний өвчлөл - 103, чих хамар хоолойн өвчлөл - 193, мэс засал, гэмтэл - 216, арьс харшлын өвчлөл - 30 тус тус бүртгэгдсэн. Үзлэгт хамрагдсан 974 цэргийн насны залуучуудаас 325 буюу 33.3 хувь нь тэнцсэн. 2022 оны 1 дүгээр ээлжийн цэрэг татлагаас эрүүл мэндийн шалтгаанаар тэнцээгүй 7 иргэнийг эмчлэн эрүүлжүүлснээр 2 дугаар ээлжийн цэргийн татлагад тэнцсэн байна. | |
| 14 | | 2. Эрэгтэйчүүдийн зөвлөгөө өгөх кабинетыг байгуулж, үйл ажиллагааг жигдрүүлэх | 2022 - 2024 | | 400 | Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/449 дүгээр тушаалын дагуу эрэгтэйчүүдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх кабинетыг аймгийн Нэгдсэн эмнэлгийн амбулаторид байгуулж, 20 хүнд урологийн нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг үзүүлж, орны хүлээгдлийг бууруулсан. Эрэгтэйчүүдийн эмчийг 2022 онд урологийн мэргэжлээр сургасан, 2022-2023 оны хичээлийн жилд мэс заслын мэргэжлийн 1 эмчийг андрологийн чиглэлээр сургаж бэлтгэж байна. 2023 оноос эрэгтэйчүүдийн төрөлжсөн тусламж үйлчилгээний кабинетыг өргөжүүлэн ажиллана. Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэг үзлэгт нийт 20871 хүн хамрагдсанаас 9678 нь эрэгтэйчүүд буюу 46.3 хувийг багц үзлэг шинжилгээнд бүрэн хамруулж, шаардлагатай эрүүл мэндийн зөвлөгөө, эмчилгээнд хамрагдсан байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15 | | 3. "Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 90 | Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийг дэмжих арга хэмжээний төлөвлөгөөг 2022-2026 онд хэрэгжүүлэхээр 4 жилээр боловсруулан, аймгийн Засаг даргын 2022 оны А/703 дугаар захирамжаар батлуулан, хэрэгжилт 70 хувьтай байна. Арга хэмжээний төлөвлөгөөний хүрээнд эрүүл мэндийн сургалт зохион байгуулж, төрийн байгууллагууд болон Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн 282 эрэгтэй багш ажилчид хамрагдсан. Оролцогчдын сургалтын өмнөх мэдлэг 20 хувь, дараах мэдлэг 70 хувь болж, хорт зуршлаас татгалзах, хавдраас сэргийлэх, зөв хооллох талаар мэдлэгээ нэмэгдүүлсэн. Аймгийн хүн амын дундаж наслалт 71.28 байна. Үүнээс эрэгтэйчүүдийн дундаж наслалт 68.17, эмэгтэйчүүдийнх 73.21 байгаа нь эрэгтэйчүүд эмэгтэйчүүдийнхээс 5.04-өөр бага байна. | |
| 16 | 2.1.3. “Хавдрын эсрэг”, “Элэг бүтэн Монгол”, “Харшлаас сэргийлэх”, “Халдварт өвчинтэй тэмцэх, сэргийлэх” арга хэмжээнүүдийг хэрэгжүүлнэ. | 1. Бэлгийн замаар дамжих халдварыг бууруулах | 2021 - 2024 | | 70 | “Эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулах тухай” Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/18 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд бэлгийн замаар дамжих халдварын чиглэлээр үзлэг, шинжилгээг зохион байгуулсан. БЗДХ-ын үзлэг, шинжилгээнд хамрагдсан 5528 тохиолдлоос 653 өвчлөлийг шинээр илрүүлж, хавьтлын хамт 883 иргэнийг эмчилгээнд 100 хувь хамруулан зөвлөгөө өгч ажилласан. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/30 дугаар тушаалын дагуу эрсдэлт бүлгийн хүн амаас эрсдэл өндөртэй иргэдийн судалгааг гарган, нийтдээ анхан шатны нэгжүүдээс 5600 иргэн БЗДХ-ын үзлэгт хамруулахаас 98.7 хувийг хамруулсан. 2022 онд тэмбүүгийн өвчлөл 178 буюу 10 000 хүн амд 20.0 тохиолдол байгаа нь өмнөх оноос 5.6-ээр өндөр, заг хүйтний өвчлөл 245 буюу 10 000 хүн амд 27.5 тохиолдол байгаа нь өмнөх оноос 7.1-оор нэмэгдсэн байна. Эдгээр 2 өвчлөл урьд оны мөн үеэс өссөн нь урьдчилан сэргийлэх үзлэг, эрт илрүүлэгтэй шууд хамааралтай. Трихоминиазын өвчлөл 371 буюу 10 000 хүн амд 41.7 тохиолдол байгаа нь өмнөх оноос 14.2-оор буурсан. Өмнөх онд нийт халдварт өвчин 18558 байсан бол энэ онд 8198 байгаа бөгөөд өмнөх онд корона вирусийн халдвар дийлэнх хувийг эзэлж байсан. 2021 оны мөн үед БЗДХ-ын тохиолдлын тоо 845 байсан бол 2022 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | онд 794 болж, 51 тохиолдлоор буурсан. Сүүлийн 2 жилд төрөлхийн тэмбүү өвчин бүртгэгдээгүй. Нийт халдварт өвчин 8198 тохиолдлын 794 буюу 9.6 хувийг БЗДХ эзэлж, өмнөх онуудаас буурсан эерэг үзүүлэлтэй байна. | |
| 17 | | 2. Сүрьеэ өвчнийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 3.5 | Глобаль сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр 11.042.000 төгрөгний санхүүжилттэй “Сүрьеэгийн батлагдсан тохиолдлын хавьтлыг үзлэг, шинжилгээнд хамруулах” арга хэмжээг сумдад зохион байгуулсан. Үзлэг, шинжилгээ, оношилгоонд нийт 1411 иргэд хамрагдаж, үүнээс цэрний шинжилгээнд 89 иргэн хамруулсан. Үзлэгийн үр дүнд шинээр 10 сүрьеэгийн тохиолдлыг илрүүлсэн. Далд халдварын эмчилгээнд 8 иргэнийг 100 хувь хамруулсан. "Эрүүл мэндийн цогц үзлэг зохион байгуулах тухай” Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/18 дугаар тушаалын дагуу аймгийн хэмжээнд зорилтот бүлгийн хамрагдвал зохих 3836 иргэнийг шинжилгээнд хамруулахаас 69 хувийг хамруулсан. Үүнээс цээжний рентген шинжилгээнд 2511 хүн харсан. Шаардлагатай 215 иргэнээс 430 цэрний сорьц авсан. Үзлэгийн хүрээнд gene-p /+/ 5 уушгины сүрьеэ, эмнэлзүйгээр 8 уушгины бус сүрьеэ, нийтдээ 13 сүрьеэ оношлогдож эмчилгээнд хамрагдсан. Аймгийн хэмжээнд 2022 оны байдлаар нийт халдварт өвчний 8198 тохиолдлын 0.4 хувь буюу сүрьеэгийн 37 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4 тохиолдлоор өссөн байна. Тохиолдлын тоо нэмэгдсэн нь төвөөс алслагдсан сум, багт урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг үзлэг очиж хийсэнтэй холбоотой байна. Аймгийн хэмжээнд сүрьеэгийн эмчилгээг тасалсан тохиолдолгүй байгаа нь урд оноос давуу талтай байна. Өмнөх онд сүрьеэгийн нас баралтын 1 тохиолдол байсан бол энэ онд 2 тохиолдлоор нэмэгдэж, 3 нас баралт бүртгэгдсэн. | |
| 18 | | 3. Хүн амыг урьдчилан сэргийлэх үзлэг оношлогоонд | 2022 - 2023 | | 100 | Баянхонгор аймгийн нийт хүн ам 89975 байгаагаас хүн амын нас хүйс, эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлд тулгуурлан урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоог чиглэл бүрээр зохион байгуулж байна. “Эрүүл жаргалтай Баянхонгорчууд”, “Малчдын эрүүл мэндийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамруулах | | | | дэмжих”, “Сүрьеэгүй ирээдүйн төлөө хамтдаа” үзлэг, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 139 дүгээр тушаалаар батлагдсан Бүх нийтийн эрт илрүүлэг үзлэг, Зонхилон тохиолдох халдварт бус өвчний эрт илрүүлэг, Ахмадын эрүүл мэндийг дэмжих сарын аян, Өрхийн хөгжлийг дэмжих цогц арга хэмжээ, "Эрүүл Монгол хүн" үндэсний хөдөлгөөний үзлэг оношилгоо зэрэг 8 төрлийн урьдчилан сэргийлэх үзлэг зохион байгуулагдаж, 70379 иргэн буюу хүн амын 78.2 хувийг хамруулсан. Үүнээс дүгнэхэд Нэгдсэн эмнэлгийн дэмжих төвөөр хийгдэж байгаа бүх нийтийн эрт илрүүлэгийн хамрагдалт 24 хувьтай бусад урьдчилан сэргийлэх үзлэгийн хамрагдалт 54.2 хувьтай байна. Дээрх үзлэгүүдээс 11057 өвчлөл илрүүлж, анхан шатны болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээгээр 60 хувийг эмчлэн эрүүлжүүлсэн. Үзлэгээр дараагийн шатлалд эмчлүүлэх шаардлагатай иргэдийг хяналтад авч, эмчлэн эрүүлжүүлэх ажлыг зохион байгуулж, онош тодруулах нэн яаралтай үйлчлүүлэгчийг гуравдугаар шатлалын эмнэлэгт шилжүүлэн, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан ажиллаж байна. | |
| 19 | | 4. Иргэдийг ковидын дараах нөхөн сэргээх эмчилгээнд хамруулах | 2022 - 2023 | | 2000 | Коронавирусийн халдвараар 2021 онд 17593 өвчлөл бүртгэгдэж, эмчлэгдсэн. Хүн амыг ковидын дараах эрүүл мэндийн үзүүлэлтийг тандах 8 төрлийн үзлэг оношилгоонд хамруулж, 70379 иргэн буюу хүн амын 78.2 хувийг хамруулсан. Уламжлалт болон сэргээн засах эмчилгээнд 2663 иргэнийг хамруулж, цахилгаан зүү, бумба, төөнүүр, ультра звук, имфра улаан туяа, массаж бариа заслын тусламж үйлчилгээ үзүүлэн бүх шатлалын эмнэлгүүд иргэдэд хүргэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулан ажиллаж байна. Сум, өрхийн эрүүл мэндийн төвүүд болон сувилахуйн Эван төвөөр ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хөнгөвчлөх тусламж үйлчилгээ шаардлагатай, хэвтрийн эмгэгтэй 2285 хүнд гэрээр сувилахуйн тусламж үйлчилгээ үзүүлсэн. Гэрээр тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамжийн судалгааны эерэг хувь 87 байгаа нь өмнөх жилтэй харьцуулахад 0.2 хувиар өссөн байна. Аймгийн хэмжээнд үзлэг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | оношилгооны явцад 11057 өвчлөл илрүүлж, анхан шатны болон хоёрдогч шатлалын эрүүл мэндийн байгууллагуудын тусламж үйлчилгээгээр 6720 буюу 60 хувийг хэвтүүлэн буюу өдрийн эмчилгээнд хамруулж, эрүүлжүүлсэн. | |
| 20 | 2.1.4. “Эх, хүүхэд, нөхөн үржихүйн эрүүл мэнд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Ревматологийн эмчийг бэлтгэх, бодлогоор дэмжих, тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах | 2022 - 2024 | | 200 | Ковид-19 цар тахлын халдвартай холбоотойгоор ревматологийн эмч бэлтгэгдээгүй. 2023-2024 оны хичээлийн жилд эмчийг сургахаар төлөвлөж байна. Нэгдсэн эмнэлэгт дотор, дотоод шүүрлийн нарийн мэргэжлийн эмч дутмаг байгаагаас төрөлжсөн мэргэжлийн эмч бэлтгэх ажил удааширч байна. Сүүлийн жилүүдэд хүн амын дунд үе мөчний өвчин эмгэг нэмэгдэх хандлагатай байгаа тул төрөлжсөн мэргэжлийн эмчийг бэлтгэх зайлшгүй шаардлагатай байна. | |
| 21 | | 2. Нярайн зүрхний гажигийг эрт илрүүлэх, скрининг болон сонсголын гажиг илрүүлэх тусламж үйлчилгээг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 1500 | Төрсөн нярай бүрт түнхний гажиг илрүүлэх үзлэгийг 2014 оноос хийж эхэлсэн. 2021 оноос нярайн сонсгол, нүдний улайрлын скрининг хийх бэлтгэл ажлыг хангаж ажилласан. Аймгийн Нэгдсэн эмнэлэгт 2022 оноос нярайн нүд, сонсгол, түнхний гажиг эмгэгийг илрүүлэх шинжилгээг эхлүүлж бэлтгэгдсэн нярайн их эмч нар нүд, түнх, сонсгол зэрэг 3 чиглэлээр 1318 нярайд тус бүр үзлэг шинжилгээг хийсэн. Үзлэг, шинжилгээгээр 140 нярай хяналтад орж, давтан үзлэг шинжилгээ төлөвлөөд байна. Нярайн зүрхний гажгийг илрүүлэх тусламж үйлчилгээнд хөдөлгөөн мэдрэгч, датчик, пульсоксиметр бусад багаж тоног төхөөрөмж дутагдалтай байна. | |
| 22 | 2.1.5. Анхан шатлалд үзүүлэх эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн | 1. Иргэдийн хүлээгдэл чирэгдэлийг багасгаж, эрүүл мэндийн үйлчилгээг түргэн шуурхай хүргэх | 2021 - 2024 | | 0 | Нэгдсэн эмнэлгийн амбулаторийн үзлэгийн цаг захиалга цахимжиж, иргэд үзлэгийн цагаа E-Mongolia системийн эрүүл мэнд цэснээс цахимаар авах үйлчилгээг нэвтрүүлсэн. Аймгийн нэгдсэн эмнэлгийн цаг захиалгын үйлчилгээг Мэдээллийн нэгдсэн системд холбон 1800-0119 дугаараас иргэд утсаар цагаа захиалан авах боломжтой болсон. Өмнөх онтой харьцуулахад иргэдийн утсаар болон цахимаар цаг авсан тохиолдол нийт цаг захиалгын 30 хувийг эзэлж байна. Засгийн газрын 11-11 төвд иргэдийн хүлээгдэл чирэгдэлтэй холбоотой гомдол санал 2021 онд 8, 2022 онд 6 ирж, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | чирэгдлийг багасгана. | | | | | хуулийн хугацаанд шийдвэрлэн, иргэдийн гомдлыг барагдуулсан. 2022 оны 5 дугаар сараас E-Mongolia цахим системд иргэн өөрийн эрхээр нэвтрэн Нэгдсэн эмнэлгийн лабораторид өгсөн шинжилгээний хариуг эрүүл мэндийн цэснээс татаж авах боломж бүрдсэн. Иргэдээс хүлээгдэл чирэгдэл үүссэн талаарх гомдлын хүрээнд бүх шатны эрүүл мэндийн байгууллагын чанарын алба, багийг ажиллуулж тухай бүр асуудлыг шийдэж хариуг өгч хэвшсэн. 2022 оныг "Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар аюулгүй байдлыг сайжруулах" жил болгон зарласантай холбогдуулан үндэсний хэмжээний сургагч багш нартай хамтран эрүүл мэндийн байгууллагуудын чанарын багийн 120 мэргэжилтэнг чадавхжуулах сургалтад хамруулсан. Мөн эрүүл мэндийн 25 нэгж байгууллага бүр дуугүй хөтөч байршуулан, хөтөч сувилагчийг томилон ажиллуулж, иргэдийг чиглүүлэх, зөвлөн туслах үйл ажиллагааг тогтмолжуулж, хяналт тавин ажиллаж байна. | |
| 23 | | 2. Багийн эмч нарыг унаажуулах | 2022 | | | Багийн эмч нарын мотоциклийн талаар 2021 онд судалгаа хийж, төсөвт суулгах саналыг хүргүүлсэн. 2022 онд Улсын төсвийн 137.6 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 14 сумдын 33 багийн эмчийг мотоциклоор хангасан. Багийн эмч нарыг унаажуулах уг тендерт "Бүдүма" ХХК шалгарч, техникийн шаардлагын дагуу бүрэн нийлүүлсэн. Мотоцикл эвдэрсэн, бүрэн зогссон зэрэг Эрүүл мэндийн газрын хэрэгцээний судалгаан дээр үндэслэн багийн эмч нарыг унаажуулсан. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээг сайжруулах арга хэмжээний хүрээнд багийн эмч нарыг унаажуулснаар алслагдсан нутаг дэвсгэрт амьдарч байгаа хөдөөгийн иргэдэд эмнэлгийн яаралтай тусламж үзүүлэх, жирэмсэн эх, 0-5 насны хүүхэд, хэвтрийн эмгэгтэй, өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хяналт, гэрийн эргэлт хийх зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлсэн. | |
| 24 | 2.1.6. Гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн | 1. Өвчтөний түүхийг цахимжуулж, E- | 2021 - 2024 | | 90 | Аймгийн нэгдсэн эмнэлэгт 2021 онд E-Health программ хангамжийн серверийн тоног төхөөрөмжийн суурилуулалт 100 хувь хийгдэж дууссан. Программ хангамжийн 7 модуль, 272 функцийг Нэгдсэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оновчтой арга хэлбэрийг нэвтрүүлж, эрүүл мэндийн даатгалын тусламж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | Health программыг бүрэн нэвтрүүлэх | | | | эмнэлгийн 100 гаруй эмч, ажилтнууд өдөр тутмын үйл ажиллагаандаа ашиглаж нэвтрүүлсэн. Тоног төхөөрөмжийн хангалтын сайжруулах ажлын хүрээнд 57 ширхэг суурин компьютер, принтер, хурууны хээ уншигч, бар кодны машинуудыг худалдан авч, хэвийн үйл ажиллагаагаар хангагдсан. 2022 оны байдлаар 12 модуль, 460 гаруй функцийг ашиглаж байна. Нэгдсэн эмнэлгийн нийт 180 эмч ажилтан өдөр тутмын үйл ажиллагаандааа ашиглаж байсан. Цахим бүртгэл, Амбулаторийн үзлэг, Лабораторийн шинжилгээ, Түргэн тусламж, Яаралтай тусламж, Дүрс оношилгоо, Цус цусан бүтээгдэхүүн захиалга, зарлага, Стационарын тусламж үйлчилгээ, Хэвтүүлэх захиалга, Цахим өвчний түүх, Эм эмнэлгийн туслах материал захиалга зарлага, Иргэний эрүүл мэндийн цахим дэвтэр зэрэг нийт 12 төрлийн үйлчилгээг цахимжуулан ажиллаж байна. Тухайн иргэн цаасан карт авч явах шаардлагагүй болж, эмчид үзүүлсэн тэмдэглэл, оношилгоо шинжилгээний хариу гэх мэт өвчний бүх түүх цахим хэлбэрээр хадгалагдаж байна. Аймгийн эрүүл мэндийн E-Health программ ашигладаг бүх шатлалын эмнэлгүүдэд тухайн иргэн үзүүлэхэд өвчний цахим түүхийг нэгдсэн баазаас харах боломжийг 100 хувь бүрдүүлсэн. | |
| 25 | | 2. Олон улсын эмнэлзүйн удирдамж Upto date программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 80 | Эмчилгээ, оношилгооны чанар, хүртээмж, үйлчлүүлэгчийн аюулгүй байдлыг сайжруулах, эмч эмнэлгийн мэргэжилтний анагаах ухааны мэдлэгийг нэмэгдүүлж, тасралтгүй суралцах боломж олгох зорилгоор UpToDate Олон улсын эмнэлзүйн цахим платформыг Эрүүл мэндийн салбарт 2021 оноос нэвтрүүлсэн. Эрүүл мэндийн газрын мэргэжилтнүүд, Нэгдсэн эмнэлгийн чанарын албаны дарга, менежерүүд программын сургагч багшаар бэлтгэгдсэн. Нийт эмч нарын 60.0 хувь нь платформыг суулгаж, үзлэг оношлогоо, тусламж үйлчилгээндээ ашиглаж хэвшсэн байна. | |
| 26 | 2.1.7. Эрүүл мэндийн ажилтны ур чадварыг | 1. Хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр | 2021 - 2024 | | 900 | Эрүүл мэндийн салбарын 126 нэгж байгууллагад нийт 1300 гаруй эмнэлгийн мэргэжилтэн бусад ажиллагсад ажиллаж байна. Үнээс их эмч 194 буюу 16 хувь, сувилагч, тусгай мэргэжилтэн 536 буюу | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулж, ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлж, нийгмийн хамгааллыг дэмжинэ. | сургалтад хамруулах | | | | 44,5 хувийг эзэлж байна. Эмч сувилагчийн харьцаа 1:1.4 байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар шүдний эмч, тархвар судлаач, нийгмийн эрүүл мэндийн мэргэжилтэн, дотор, дотоод шүүрэл, үе мөч судлал (ревматологи) ахмадын эмч, багийн эмч дутагдалтай байна. Хөгжлийн төлөвлөгөө хэрэгжүүлэх арга хэмжээний зардлаас 10.0 сая төгрөг зарцуулан, эрүүл мэндийн удирдлага, хүний нөөцийн магистр, сувилахуй зэрэг 4 чиглэлээр 12 мэргэжилтнийг сургаж байна. 2022 онд давхардсан тоогоор эрүүл мэндийн байгууллагуудын 1700 гаруй эмч, сувилагч, тусгай мэргэжилтэн 98 чиглэлээр ажлын байрны сургалтад хамрагдаж чадавхижсан. 2022 оны төгсөлтийн дараах төрөлжсөн мэргэжлийн сургалтад улсын төсвийн санхүүжилтээр бөөрний мэс засал судлал, эх барих эмэгтэйчүүдийн эхо, дурангийн онош зүй, жирэмсний хяналт, сэргээн засахын сувилахуй, хавдрын сувилахуй, хүүхдийн сувилахуй, эрчимт эмчилгээний сувилахуй зэрэг чиглэлээр анхан болон хоёрдогч шатлалын эмнэлгийн 18 эмч, сувилагч нар суралцаж, эрүүл мэндийн салбарын нэн шаардлагатай мэргэжлээр хүний нөөц бэлтгэгдэж байна. | |
| 27 | | 2. Иргэд үйлчлүүлэгчдээс сэтгэл ханамжийн судалгаа авч, ёс зүйгээрээ бусдыгаа манлайлсан ажилтнуудыг урамшуулах, алдаршуулах | 2021 - 2024 | | 92 | Эрүүл мэндийн байгууллагаар үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн эерэг хувь 2020-2021 онд 73,0-91,0 хувьтай. Эмнэлгийн мэргэжилтнүүдтэй холбоотой алдаа зөрчил бүртгэгдээгүй. Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/578 дугаар тушаалын дагуу 2022 онд үйлчлүүлэгчийн сэтгэл ханамжийн судалгааг эрүүл мэндийн 24 нэгж байгууллагууд улирал тутам авч, нийт 6920 хүн хамрагдсанаас хэрэглэгчийн үнэлсэн дүнгээр сэтгэл ханамжийн эерэг хувь 91.2 хувьтай үнэлэгдсэн. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанарыг сайжруулах, ёс зүйтэй хамт олон аяныг өрнүүлэн үр дүнг тооцсон. Эрүүл мэндийн газрын даргын 2022 оны А/109 тушаалаар "Бид ёс зүйгээр манлайлна" уриалгат аяныг сарын хугацаанд зохион байгуулж, эмч, эмнэлгийн мэргэжилтний харилцаа хандлагын сөрөг үзүүлэлтийн судалгааг QR код ашиглан цахимаар явуулсан. 2022 онд эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн алдаа зөрчил бүртгэгдээгүй. Эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | харилцаа хандлагыг сайжруулах соён гэгээрүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хүрээнд 2022 оны 05 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд ЭМЯ-ны дэргэдэх эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран эмч, эмнэлгийн мэргэжилтний ёс зүй, харилцаа хандлагыг сайжруулах зорилгоор "Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй" сэдэвт сургалтыг зохион байгуулж, сургалтад эрүүл мэндийн салбарын 195 эмч, эмнэлгийн мэргэжилтэн хамрагдаж чадавхажсан. | |
| 28 | | 3. Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэн ажиллах | 2021 - 2024 | | 90 | Засгийн газрын 2022 оны “Үйлчилгээний албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн цалингийн доод хэмжээг тогтоох тухай” 107 дугаар тогтоолын хэрэгжилтийг хангаж, гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан Нэгдсэн эмнэлэг, Өрхийн ЭМТ-ийн эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын үндсэн цалинг ажилласан жил, ажлын ачаалал, үр дүнг харгалзан 15-45 хувь хүртэл нэмэгдүүлэн олгосон. Салбарын хэмжээнд Эрүүл мэндийн тухай хуулийн 29.5 дахь заалтаар 201 эмнэлгийн мэргэжилтэнд 783.5 мянган төгрөг, 29.2 дахь заалтаар 14 эмнэлгийн мэргэжилтэнд 247.8 сая төгрөгийн тэтгэмжийг олгосон. Харьяа эрүүл мэндийн 23 байгууллага ажилчдын ажлын хувцас авахад 30.6 сая төгрөг зарцуулсан. 2022 онд төгсөлтийн дараах үндсэн мэргэжлийн сургалтад 6, төрөлжсөн мэргэжлийн сургалтад 7, мэргэжил дээшлүүлэх сургаалтанд 5 эмч, эмнэлгийн мэргэжилтэн улсын төсвийн санхүүжилтээр тус тус суралцаж байна. Эрүүл мэндийн салбарын албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангахад давхардсан тоогоор 1145 албан хаагчдад тэтгэмж, шагнал урамшуулал, дэмжлэг үзүүлсэн байна. Хөтөлбөрийн хэрэгжилтийн дундаж 90.6 хувьтай байна. Өмнөх онтой харьцуулвал гүйцэтгэлийн санхүүжилттэй уялдуулан эмч, эмнэлгийн мэргэжилтэн, ажилчдын цалин Нэгдсэн эмнэлэг 20-40, өрхийн эрүүл мэндийн төвийн 40 хувиар тус тус нэмэгдсэн. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд ажилтан, албан хаагчдад олгох урамшууллын зардал өмнөх оноос 10-12 хувиар нэмэгдсэн байна. 2021, 2022 онуудад Эрүүл мэндийн тухай хуулийн 29.2, 29.5 дахь заалтаар нийт 486 ажилтанд 2,9 тэрбум төгрөгийн | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тэтгэмжийг бүрэн олгож, өр авлага гаргаагүй ажилласан байна. | |
| 29 | 2.1.8. Бүх шатны эмнэлэг, эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламж, дэд бүтцийг сайжруулан, стандарт, чанарын шаардлага хангасан тэгш, хүртээмжтэй, чанартай үйлчилгээг хүргэнэ. | 1. Амбулаторийн барилгыг шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 90 | Аймгийн Нэгдсэн эмнэлгийн 9 тэрбум төгрөгийн өртөгтэй Амбулаторийн барилга 2020 онд Худалдан авах ажиллагааны нээлттэй сонгон шалгаруулалтын журмаар түлхүүр гардуулах гэрээний нөхцөлтэйгээр тендер зарлагдаж, ажил гүйцэтгэгчээр Рокпейнт групп шалгарч, гэрээ хийгдсэн. Амбулаторын 3 давхар барилгын зураг төсвийг “Диҗовэйшн ХХК” гүйцэтгэсэн. Амбулаторийн шинэ барилгын ажлыг "Рокпэйнт групп" ХХК гүйцэтгэж, 2022 оны байдлаар барилгын суурь болон каркас угсралт бүрэн хийгдэж дууссан. Өрлөгийн ажлыг эхлүүлсэн, 50.0 хувийн гүйцэтгэлтэй байна. Уг барилга ашиглалтад орсноор аймгийн 89.000 гаруй хүн амд хоёрдогч шатлалын өндөр нарийн мэргэжлийн тусламж үйлчилгээг чанар, стандартын шаардлагад нийцсэн ая тухтай орчин нөхцөлд үзүүлэх боломж бүрдэх юм. | |
| 30 | 2.1.9. Эм, эмнэлэгийн хэрэгслийн чанар, аюулгүй байдалд хяналт тавьж, сумдын эмийн эргэлтийн сангуудын үйл ажиллагааг сайжруулж, үнийн нэгдсэн бодлогыг бий болгоно. | 1. Антибиотикийг жороор олгосон байдалд хяналт үнэлгээг хийж, хариуцлагатай тогтолцоог бий болгох | 2021 - 2024 | | 7000 | Антибиотикийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, эмэнд нянгийн тэсвэржилт үүсэхээс сэргийлэх аяны хүрээнд 2021 онд төлөвлөгөө гарган ажиллаж, тасаг нэгжүүдийн нийт 325 хэвтэн эмчлүүлэгч болон үйлчлүүлэгчдэд сургалт явуулж, антибиотикийн хэрэглээний талаар мэдлэг олгосон. Антибиотикийн хэрэглээний судалгааг улирал бүр хийж байна. Эмнэлэгт “Жорын стандарт MNS:5376:2014” стандартыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, амбулаторын жор бичилтэнд хяналт тавьж, эмч нарыг стандартын жорын маягтаар хангаж, хяналт тавин ажилласан. Эмийн эмчилгээг зохицуулах хорооны 2019 оны А/414 тоот тушаалын дагуу ‘’Антибиотикийн дэд хороо”-ны ажлыг төлөвлөн антибиотикийн зохистой хэрэглээний судалгааг гаргасан. Аймгийн төвд үйл ажиллагаа явуулж байгаа 1-р зэрэглэлийн 10, 2-р зэрэглэлийн 13 эмийн сангийн дунд “Ухаалаг хэрэглээ-соёлтой үйлчилгээ” аяны хугацаанд гарын авлага, зөвлөмжүүдийг хүргэснээр ижил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээ, найрлагатай эмийн худалдан авалт буурсан. Аймгийн хэмжээнд хувийн хэвшлийн 23 эмийн сангаас сар бүр жорын судалгаа авч, дүгнэлт гаргахад 10 байгууллага 23899 ширхэг жор хүлээн авч үүнээс эмчийн тамгагүй жор 15.0 хувь, өвчтөний нас хүйс бичээгүй 4.3 хувь, оношны код бичээгүй 4.1 хувь, антибиотик эмийг жоргүй олгосон 2.1 хувийг ээлж байгаа зөрчил дутагдал байна. Цаашид дээрх зөрчил дутагдлыг арилгах ажлыг эрчимжүүлэн сургалт сурталчилгааг шат дараатай зохион байгуулан ажиллаж байна. Аймгийн Нэгдсэн эмнэлгийн нян судлалын лабораторийн антибиограммын судалгаанаас 2021 онд нийт 19197 шинжилгээг 6-8 төрлийн тэжээлт орчин ашиглан хийж үүнээс тасагт – 1447 сорьц, амбулатори – 17570 сорьц, антибиотик мэдрэг чанар нийт 1173 сорьцод тавьж, дүгнэлт судалгаа хийн ажилласан. “Антибиотикийн зохистой хэрэглээ”, “Бичил биетний эсрэг эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх, бичил биетний тэсвэржилт үүсэхээс сэргийлэх” сэдэвт нэг сарын аяныг салбарын хэмжээнд өрнүүлж, төлөвлөгөөний хэрэгжилт 95.0 хувьтай байна. | |
| 31 | | 2. Зайлшгүй шаардлагатай эмийн үнийн нэгдсэн бодлого хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 89<br>15 | Сумдын эрүүл мэндийн төвийн эм, эмнэлгийн хэрэгслийн тендер нь 2021 онд БХРЭМГ- 2021/Б-01 дугаартай нээлттэй 302.212.400 сая төгрөгийн босго үнэтэй 25 багцын 272 нэр төрлийн эм, 40 нэр төрлийн эмнэлгийн хэрэгсэл, 27 нэр төрлийн урвалж оношлуур хангаж нийлүүлэх тендер зарлагдсан. Цахим тендер, ерөнхий гэрээгээр нийт 38 удаагийн 290,0 сая төгрөгийн татан авалт хийж, 275,4 төгрөгийн зарлага гаргаж, 57.2 сая төгрөгийн эмийн үлдэгдэлтэй гарсан. ”Ковид-19” цар тахлын өвчлөлтэй холбоотой тендерийн гүйцэтгэлийн хувь үнийн дүнгээр хэтрэлттэй, нэр төрлөөр 90.0 хувьтай гарсан. Сумдын эмийн санг 2022 оноос аж ахуйн тооцоот үйл ажиллагаанд шилжүүлэн, Эрүүл мэндийн газар, сумын ИТХ, Эрүүл мэндийн төв, Эмийн сангийн хооронд хамтран ажиллах дөрвөлсөн гэрээ байгуулан, гэрээний хэрэгжилтэд Эрүүл мэндийн газраас хяналт тавин ажиллаж байна. Аймгийн хэмжээнд зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 85.0 хувьтай байна. Эмийн сангуудын өрсөлдөх чадварыг бий болгох, эм зүйн тусламж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, эмийн үнийн бодлогыг зохицуулах үүднээс 2021-2022 онд 3 сумын эмийн санд тусгай зөвшөөрөл олгоод байна. Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа Наянбулаг ганга, Арвижих-Эрдэнэ тун, Лхам, Баруун-Шанд, Монгол Эм импекс зэрэг 8 эмийн санд удирдамжийн дагуу үнэлгээ хийж MNS 5260:2015 стандартын хэрэгжилт, антибиотик эмийг жороор олгож байгаа эсэх, ил тод байдал, эмийн үнийн тариф зэрэг үйл ажиллагааг хянаж, зөвлөн туслах үйлчилгээг хүргэн ажилласан. Сумдын 20 эмийн сангийн эмийн үнийн зөрүүнд судалгаа хийж, дүгнэлт гаргахад тухайн эмийг үйлдвэрлэсэн улс болгоны эмийн үнэ харилцан адилгүй байдаг тул алслагдсан суманд 20-30 хувийн нэмэгдэлтэй, ойрын суманд 10-20 хувийн нэмэгдэлтэйгээр эм зүйн тусламж үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Сумдын эмийн сангуудтай байгуулсан 2022 оны гэрээний хэрэгжилт 90 хувьтай байна. Аймгийн хэмжээнд нийт 45 эмийн сан үйл ажиллагаа явуулж, 2022 онд эрүүл мэндийн даатгалын сангаас 1.7 тэрбум төгрөгийн санхүүжилт авсан байна. | |
| 32 | 2.2.1. Спорт цогцолбор бүхий усан бассейныг ашиглалтад оруулж, үйл ажиллагааг тогтмолжуулна. | 1. Спорт цогцолбор, усан бассейны барилгын ажлыг ашиглалтад хүлээн авах | 2021 - 2022 | | | Усан бассейн бүхийн спорт цогцолборын барилгыг улсын төсвийн 11.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж 2022 оны 12 сард хүлээж авсан Олон улсын уралдааны стандартын таван замтай усан бассейн, спортын дөрвөн заал, оффисын 16 өрөө тасалгаатай, спортын олон төрлөөр хичээллэх, бэлтгэл хийх боломж бүхий томоохон бүтээн байгуулалт бий болсноор нийтийн биеийн тамир хөгжих, хүүхэд залуучуудын чөлөөт цагаа зөв боловсон өнгөрүүлэх таатай орчин бүрдсэн. | |
| 33 | | 2. Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, үйл ажиллагааг | 2022 - 2024 | | 50 500 | Усан бассейн бүхий спорт цогцолборт шаардлагатай хэрэглэл материал, техник тоног төхөөрөмжийн судалгааг Биеийн тамир, спортын Улсын хороонд, Усан бассейны хэрэглэл материалын судалгаа, хүсэлтийг Монголын Усан спортын холбоонд хүргүүлсэн. Монголын Бадминтоны холбоонд хүсэлт гаргаснаар цогцолборт шаардлагатай Бадминтоны дэвсдэг шал, бөмбөг, цохиур зэргийг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтмолжуулах | | | | нийт 15.0 сая төгрөгийн өртөг бүхий хэрэглэл материалыг шийдвэрлүүлсэн. | |
| 34 | 2.2.2. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. “Эрүүл, идэвхитэй амьдрал” арга хэмжээг боловсруулж, хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 100 | Аймгийн Засаг даргын нэрэмжит “Дасгал хөдөлгөөн хийцгээе” аянд 860 хүн, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын даргын нэрэмжит “Цахим гимнастрада” арга хэмжээг 4 төрлөөр зохион байгуулж 57 багийн 552 иргэд хамрагдсан нийтийн биеийн тамирын арга хэмжээнүүдийг зохион байгуулж улсын хэмжээнд Дэд байрт шалгарсан. - Аймгийн хэмжээнд "Эрүүл иргэн - Эртэч Баянхонгорчууд" аяныг зохион байгуулж, 36 спорт заал, 2 чийрэгжүүлэх танхим, 16 соёлын төвийн үйл ажиллагаанд төрийн болон төрийн бус 73 байгууллага, 13 сумын 36547 хүн, Багийн иргэдийн дунд “Нэг баг-Нэг өрх” спортын 3-н төрөлт тэмцээн зохион байгуулж 540 тамирчин, -“Ахмадын биеийн тамирыг дэмжих сар” аяныг тохиолдуулан Баянхонгор сумын 9 багийн дунд явган аялал, софт волейбол, дасгал хөдөлгөөн, гранд гольф, олс таталт зэрэг спортын арга хэмжээг зохион байгуулж давхардсан тоогоор 680 гаруй ахмад хамрагдсан үйл ажиллагааг зохион байгуулсан - Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачлан хэрэгжүүлж буй “Эрүүл Монгол хүн” үндэсний хөдөлгөөн, “Эрүүл мэндийнхээ төлөө цаг гаргая” биеийн тамирын арга хэмжээнд Өглөөний дасгал, Дугуй унах, Зөв хооллолт, Алхалт, Цахим гүйлт зэрэг арга хэмжээг зохион байгуулж 43 байгууллагын 1100 хүн хамрагдаад байна. | |
| 35 | | 2. Спорт заалуудын ашиглалтыг сайжруулах | 2021 - 2024 | | 20000 | Баянхонгор аймгийн хэмжээнд 47 спорт заал тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Биеийн тамир спортын газрын харьяа 7 спорт зааланд 7 хоногийн 2 өдрийг иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх, 5 өдөрт албан байгууллагуудад, хүүхэд залуучуудад өдрийн цагаар спортоор хичээллэх, чөлөөт цагаа зөв боловсон өнгөрөөх зохицуулалт хийсэн. Мөн 19 суманд Биеийн тамирын арга зүйчтэй болж хүний нөөцийг бүрдүүлж, иргэдийг спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлж улсын хэмжээнд сайн туршлага болоод байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 36 | | 3. Заал, талбайн засвар үйлчилгээ хийж, шинээр ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 2<br>1<br>0 | Усан бассейн бүхийн спорт цогцолборын барилгыг улсын төсвийн 11.9 тэрбум төгрөгийн санхүүжилтээр гүйцэтгэж 2022 оны 12 сард хүлээж авсан. Баянхонгор суманд 7-р багийн спорт заалыг шинээр барих, Дөвөнтийн заалны засварын ажлууд хийгдсэн. Шинэжинст сумын спорт заалны барилгын ажлын гүйцэтгэл 80 хувийн гүйцэтгэлтэй, Цэнгэлдэх хүрээлэнд хөнгөн атлетикийн талбайн засвар хийгдэж хөнгөн атлетикийн уралдаан тэмцээн зохион байгуулах боломж бүрдсэн. Баянхонгор сумын 3,4,5,6,7,9 багийн зааланд 17,0 сая төгрөгөөр дотор засвар хийж орчныг сайжруулсан. | |
| 37 | 2.3.1. “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. Сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 100 | Аймгийн ИТХ-ын 2022 оны 8/10 тогтоолоор "Ковидын дараах сурагчдын сурлагын хоцрогдлыг нөхөх, арилгах арга хэмжээний төлөвлөгөө" -г батлан хэрэгжүүлж, БШУЯ, БЕГ, БҮТ-өөс "Сургуульд суурилсан үнэлгээгээ"-ээр сурагчдын гүйцэтгэлийн аймгийн дундаж 2021 онд 41.6 хувьтай үнэлэгдэж, 2022 онд 14 хувиар өсөж 55,6 хувь болсон. Баянхонгор аймгийн төрийн өмчийн 26 сургууль бүгд шилэн кабелиар холбогдож БШУЯ-аас түгээж байгаа интернэт сүлжээнд холбогдсон. Интернэтийн хурдыг ихэсгэж 4мб болгосноор багш нар боловсролын нэгдсэн цахим сүлжээнд ажиллах, цахим контент боловсруулах зэргээр албан ажлаа хийх боломж бүрдлээ. Багийн 3 сургуульд агаараас хүлээн авдаг төхөөрөмж суурилуулсан. Үүний үр дүнд аймгийн бүх сургууль интернет сүлжээнд холбогдсон байна. БШУГ болон “Номундалай” сургууль дээр цахим контентын 19 сая төгрөгийн лаборатори сурлагын хоцрогдлыг нөхөх арилгахад ашиглах багш нарын цахим контент хийж бүтээх, боломжийг бүрдүүлсэн. Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих тоног төхөөрөмж бэлтгэх зардлыг улсын төсвөөр шийдэж Өлзийт, Бөмбөгөр, Бууцагаан, Жаргалант, Баянхонгор сумын ЕБС -иуд Номгон, Эрдэнэмандал Эрдэм, Согоо Сейко, Гэгээн Сумади зэрэг 9 сургуульд 641 сая төгрөгийн иж бүрэн "Дижитал кабинет ашиглалтад оруулж сургалтад ашиглаж байна. Мөн Боловсролын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд улсын төсвийн 1 тэрбум 478, сая төгрөгийн зөөврийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | компьютер, бичил лаборатори 5-ийг ЕБС, цэцэрлэгт нийлүүлж багш нарын 50 хувийг компьютержуулж , бага ангийн 120, дунд ангийн 40 контент бүгд 160 контент боловсруулж сургалтад ашиглан сурлагын хоцрогдлыг нөхөх арилгах ажлыг зохион байгуулсан. | |
| 38 | | 2. "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 100 300 | Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2021 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн "Хөтөлбөр төлөвлөгөө баталж хэрэгжилтийг хангах тухай" А/07 дугаар тушаалаар баталсан “Чадварлаг багш” арга хэмжээг хэрэгжүүлэх хөтөлбөр төлөвлөгөөг үндэслэн аймгийн Засаг даргын 2022 оны "Чадварлаг багш" арга хэмжээний төлөвлөгөө батлах тухай" А/596 дугаар захирамж арга хэмжээний төлөвлөгөөг баталж, цахим контент бэлтгэх, боловсрол судлалын чиглэлээр 10, “Хичээл сургалтын үр дүнг үнэлэх шалгуурыг хэрэглэх нь”, бага анги, монгол хэл, физик, математик, технологи, байгалийн ухаан, нийгмийн ухааны судлагдахууны багш нар, сургалтын менежер, захирлуудад зориулсан сургалтыг үе шаттайгаар зохион байгуулсан. Ерөнхий боловсролын 900, цэцэрлэгийн 240 орчим багш хамрагдсан байна. Багшийн мэргэжлийн тасралтгүй хөгжлийг хангах улс, аймаг, сургууль цэцэрлэг дээр мэргэжлээ дээшлүүлэх сургалтууд зохион байгуулагдаж Ерөнхий боловсролын сургуульд 223,1сая, цэцэрлэгт 45,2 сая төгрөгийн санхүүжилт хийгдэж зарцуулагдсан. Боловсролын үнэлгээний төвөөс багшийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж 317 багшид буюу нийт багш нарын 34,5 хувьд 10-25 хувийн нэмэгдэл олгогдсон. Элсэлтийн ерөнхий шалгалтад бэлтгэх багш, сурагчдыг урамшуулах зорилгоор аймаг, сумын Засаг дарга, ИТХ-ын даргын нэрэмжит сорилыг 4 удаа зохион байгуулж 16,5 сая төгрөг, ЭЕШ-ын дүнгээр аймаг улсад 4 дүгээр байр эзэлж аймгийн ИТХТ-ийн 2021 оны 49 дүгээр тогтоолоор баталсан журмын болзлыг хангасан 8 сурагч, 10 багшид 17,5 сая төгрөг, сая урамшуулал олгосон нь өмнөх оныхоос 50 хувиар их урамшуулал олгож багш нарын цалин хөлсийг нэмэгдүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 39 | 2.3.2. Хүүхэд бүрийг боловсролд тэгш хамруулах боломжийг бүрдүүлнэ. | 1. Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг чадваржуулах сургалтад хамруулах | 2021 - 2024 | | 40 | Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хамран сургах, орчин нөхцөлийг бүрдүүлэх арга зүй олгох түгээн дэлгэрүүлэх сургалтыг 2 удаа зохион байгуулж нийт 24 сургуулийн 25 нийгмийн ажилтан оролцлоо. Ерөнхий боловсролын сургуулийн орчны аюулгүй байдлын стандарт MNS:6782-г хэрэгжүүлэх хүрээнд НҮБ-ын Хүүхдийн Сан, БНСУ-ын Олон Улсын Хамтын Ажиллагааны Байгууллага /KOICA/-ийн санхүүжилтээр хэрэгжиж байгаа “Ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл, Насан туршийн боловсролын төвтэй хамтран хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүй олгох сургагч багш бэлтгэх сургалтыг зохион байгууллаа. ЖАЙКА, СТАРТ төслийн зүгээс зохион байгуулсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлог хэрэгцээнд нь тохируулан ганцаарчилсан сургалтын хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх арга зүй”-н онлайн сургалтад Номгон, Эрдэм, Эрдэнэмандал, Бөмбөгөр, Өлзийт сумын сургуулийн 70 гаруй бага ангийн багшийг хамруулсан. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг үйл ажиллагаанд тэгш хамруулахад анхаарах асуудал цахим сургалтыг сургуулийн нийгмийн ажилтан 30, дотуур байрын багш 20 албан хаагчийг хамруулан цахим хэлбэрээр зохион байгуулсан. Салбарын яамтай хамтран 6-р сарын 15-17-ны өдрүүдэд 5 сургуулийн хүүхэд хөгжлийн төвийг хариуцан ажилладаг сургуулийн нийгмийн ажилтан, багш нарт сургалтыг зохион байгуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн үйл ажиллагаанд тэгш хамруулахад анхаарах асуудал цахим сургалтыг сургуулийн нийгмийн ажилтан 30, дотуур байрын багш 20 албан хаагчийг хамруулан цахим хэлбэрээр зохион байгууллаа. | |
| 40 | | 2. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирох хэрэглэгдэхүүн, орчинг сайжруулах | 2021 - 2024 | | 2 | Баянхонгор сумын Номгон ахлах сургууль, Өлзийт, Бөмбөгөр сумын сургууль хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн онцлогт тохирсон кабинеттай болоход Нэгдсэн үндэсний байгууллагын Хүүхдийн сан, санхүүгийн болон тоног төхөөрөмжийн туламж үзүүлж жишиг сургалтын орчин бий болж хүүхдийн сурч боловсрох нөхцөл боломж бүрдсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 41 | 2.3.3. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, сургалтын орчныг хүүхэд бүрт ээлтэй болгож, багш нарын ур чадварыг нэмэгдүүлнэ. | 1. "Бага насны хүүхдийн цогц хөгжил"-ийг дэмжих стратеги төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 75 | Бага насны хүүхдийн цогц хөгжил-2022"- төлөвлөгөө боловсруулан Нийгмийн бодлогын хэлтсийн даргаар батлуулан хэрэгжүүлсэн, төлөвлөгөөний хэрэгжилт 85 хувьтай хэрэгжсэн, Салбар дундын хамтын ажиллагааг сайжруулахын тулд аймаг, сумын сургагч багшаар 25 хүн бэлтгэгдэж 4 удаагийн сургалтаар 336 эцэг эхэд, бага насны хүүхдийн эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээл, асаргаа сувилгаа, хамгааллын талаар мэдлэг, чадварын ойлголттой болгох сургалтыг зохион байгуулсан. Бөмбөгөр, Эрдэнэцогт сумын цэцэрлэгийг түшиглэн алслагдсан малчдын хүүхэд, тэдний эцэг эх, асран хамгаалагчдад зориулсан “Эцэг эх”-ийн клубийг НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүгийн дэмжлэгтэйгээр байгуулан (тус бүр 14.3 сая төгрөг) 365 өрх, гэр бүлд үйлчилгээ үзүүллээ. Баянхонгор–Бага насны хүүхдийн цогц хөгжил сургуулийн өмнөх насны хүүхэдтэй эцэг эхэд зориулсан пэйжийг нээж, 2500 эцэг эхэд 5 чиглэлээр 98 сургалтын материал, 14 постер, 36 сурталчилгааны материалыг байршуулан сурталчилгаа хийсэн. Бага насны хүүхдийн цогц хөгжил гарын авлага, сургалтын модулийг цэцэрлэг тус бүрд хүргүүлж ажилласан. | |
| 42 | | 2. Бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчны сайжруулах | 2021 - 2024 | | 2 | Сургуулийн өмнөх боловсролын төрийн өмчийн 35 цэцэрлэгийн 21 цэцэрлэг буюу 60 хувь нь хоол үйлдвэрлэлийн стандарт шаардлага хангасан гал тогоотой. Цэцэрлэгийн тогооч нарын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх сургалт зохион байгуулж бага насны хүүхдийн хоол үйлдвэрлэлийн орчныг сайжруулаад байна. | |
| 43 | | 3. 5 настай хүүхэд бүрийг СӨБ-ын үйлчилгээнд хамруулах | 2021 - 2024 | | 100 | Аймгийн Засаг дарга, сумдын Засаг даргатай байгуулсан хамтран ажиллах гэрээнд 5 настай хүүхдийг сургуульд заавал хамруулах зорилт дэвшүүлж, мөн 5 настай хүүхдийг бүрэн хамруулах арга аргачлалыг боловсруулж ажилласны үр дүнд аймгийн хэмжээнд 1824 хүүхэд хамрагдаж 1801 хүүхдэд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээ үзүүлж нийт хүүхдийн 98 хувийг сургуулийн өмнөх үйлчилгээнд хамруулсан. Мөн багшийг бэлтгэн, бэлтгэл бүлгийн 52 багшийг хүүхдийн хөгжлийн судалгааны арга зүйд суралцуулж үр дүнгийн үнэлгээ тандалт судалгаа хийх аргад | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | суралцуулж чадваржуулсан. | |
| 44 | | 4. Хүүхэд харах төвийн үйлчилгээг тогтворжуулж, ясли байгуулах асуудлыг судлах | 2021 - 2024 | | 9 | Хүүхэд харах төвийн үйл ажиллагаа албан ёсоор нээгдээгүй байгаатай холбогдуулан 2022-2023 оны хичээлийн жилд аймгийн төвийн 11 цэцэрлэгт 1нас 6 сартайгаас -2 нас хүртэлх хүүхэд хүлээн авах орчин нөхцөлийг бүрдүүлж 165 хүүхдийг цэцэрлэгт хүлээн авч ажиллаж байна. Түүнчлэн 2-3 настай хүүхдийг гэр бүлийн орчинд нь хөгжлийг дэмжих аргад эцэг эхийг суралцуулах сургагч багшаар 25 хүнийг бэлтгэн эцэг эх хүүхдээ өөрөө асран хамгаалах цогц үйлчилгээ үзүүлэх боломж, ойлголт өгөх сургалтад хамруулсан. 2022 оны байдлаар улсын хэмжээнд ясли байгуулах эрх зүйн орчин бүрдээгүй байна. | |
| 45 | 2.3.4. Сургууль, цэцэрлэгийн барилгын стандарт, норм нормативийг мөрдүүлж, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ. | 1. Сургууль, цэцэрлэг, дотуур байрны орчин нөхцлийг сайжруулах | 2021 - 2024 | | 3 | Баянхонгор сумын шинэ суурьшлын бүсэд 640 хүүхдийн суудалтай сургууль, цэцэрлэгийн цогцолборын барилга, Баянхонгор сумын "Номгон" ахлах сургуулийн 440 хүүхдийн өргөтгөлийн барилга , Баянхонгор сумын 5 дугаар сургуулийн 960 хүүхдийн суудалтай хичээлийн барилгыг тус тус ашиглалтад оруулж, Гурванбулаг сумын 160 хүүхдийн суудалтай хичээлийн байрны барилгын ажил 80 хувь, Шаргалжуут тосгоны 240 хүүхдийн суудалтай хичээлийн байрны ажил 50 хувьтай баригдаж 2022 онд 1 сургууль цэцэрлэгийн цогцолбор, Ерөнхий боловсролын 1 сургууль ашиглалтад орж үйл ажиллагаа явуулж байна. Япон улсын Ратори төслөөр Баянхонгор сумын "Эрдэм" ЕБС сургуульд 19,0 сая төгрөгийн"Байгалийн шинжлэх ухааны лаборатори" дугуйлан, БШУЯ-ны Эрдэнэт үйлдвэрийн санхүүжилтээр 2 дотуур байр, 3 цэцэрлэг, 3 сургууль, НҮБ-ын хүүхдийн сан, Олон улсын хамтын ажиллагааны Койко байгууллага, Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр 2 цэцэрлэг, 1 дотуур байр, 1 хичээлийн байр нийт 5 сургууль, 5 цэцэрлэг, 3 дотуур байрны барилга стандартын ариун цэврийн байгууламжтай болж орчин нөхцөл сайжирлаа. Орон нутгийн төсвийн хөрөнгөөр Богд, Бууцагаан, Жаргалант Баян-овоо сумын сургуулийн хичээлийн болон дотуур байр, хоол үйлдвэрлэлийн заалны их засвар, Баянхонгор сумын 4 дүгээр | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | цэцэрлэгийн барилгын их засварын ажлыг нийт 620 сая төгрөгөөр, Японы "Өвсний үндэс төслийн санхүүжилтээр Эрдэнэцогт сумын сургуулийн дотуур байрны барилга их засвар хийж ашиглалтад 100 хувь оруулснаар сурагчдын сурч боловсрох таатай орчин, багш нарын ажиллах нөхцөл сайжирсан. | |
| 46 | | 2. Нүхэн жорлонг шинэчилж ариун цэврийн байгууламжийн тоог нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 8 | | БШУЯ-ны захиалгаар "Эрдэнэт" үйлдвэрийн санхүүжилтээр тус аймагт стандартын ариун цэврийн байгууламж хийх ажлыг Бөмбөгөр, Заг сумын сургууль, дотуур байр, цэцэрлэг, Баян-өндөр сумын сургууль, дотуур байр, Баянбулаг сумын цэцэрлэгт 2021-2022 онд хийж ашиглалтад орууллаа. Богд, Шинэжинст сумын сургууль, цэцэрлэг, Хүрээмарал, Гурванбулаг сумын сургууль, цэцэрлэгийн ариун цэврийн байгууламж барих судалгаа хийгдлээ. Үүний үр дүнд 5 сургууль, 3 дотуур байр, 5 цэцэрлэг ариун цэврийн байгууламжтай болж нийт сургуулийн 71,4 хувь, дотуур байрны 72,7 хувь, хүүхдийн цэцэрлэгийн 88,5 хувь орчин үеийн ариун цэврийн байгууламжтай болсон нь 2021 онтой харьцуулахад сургууль 15 хувиар, дотуур байр 10 хувиар, цэцэрлэг 7.5 хувиар өслөө. | |
| 47 | | 3. Цэцэрлэгийн гадна талбайг стандартын шаардлагын дагуу тохижуулах | 2021 - 2024 | | 2 | | Баянхонгор сумын 11,12 дугаар цэцэрлэгийн гадаа талбайн тоглоомыг 26,490,000 төгрөгийн гадаа талбайн тоглоом, биеийн тамирын хэрэгслийг хүлээлгэн өгч тохижилтыг бүрэн хийсний зэрэгцээ Баянхонгор сумын 6 дугаар цэцэрлэгт НҮБ-ын Хүүхдийн сангийн санхүүжилтээр /17,6 сая төгрөг/ 3-5 настай хүүхдийн хөдөлгөөн эрүүл мэндийг дэмжсэн жишиг орчныг бүрдүүлсэн. | |
| 48 | 2.3.5. Сургуулийн дотуур байр, гал тогоо, спорт болон урлагийн заалны хүртээмжийг нэмэгдүүлж, | 1. Ерөнхий боловсролын сургуулиудыг хоол үйлдвэрлэлийн тоног төхөөрөмжөөр | 2021 - 2024 | | 80 | | Сургуулийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний үндэсний тогтолцоог хөгжүүлэн бүх сурагч үдийн хоолны хөтөлбөрт хамрагдаж, сургууль бүр стандартын шаардлага хангасан хоол үйлдвэрлэлийн байр, тоног төхөөрөмж, хүний нөөцтэй байх хүрээнд НҮБ хүүхдийн сангийн хөрөнгө оруулалтаар нийт 30,5 сая /Эрдэнэмандал/ төгрөгийн тоног төхөөрөмж, Улсын төсвөөр Эрдэм, Соогo сейкео, Номундалай, Политехник коллеж, Бөмбөгөр сумд шаардлагатай | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сургууль бүрт “Үдийн хоол” олгох боломжийг бүрдүүлнэ. | хангах | | | | тоног төхөөрөмжөөр хангагдсан байна. Эрдэм, Соого сейкео, Өлзийт сумын сургуулийн гал тогоог иж бүрэн тоног төхөөрөмжөөр хангасан байна. Аймгийн хэмжээнд нийт 30 сургуулийн 20 сургууль буюу 66,6 хувь нь зориулалтын хоол үйлдвэрлэлийн танхимтай, 10 сургууль нь буюу 33,3 хувь зориулалтын хоол үйлдвэрлэлийн заалгүй байна. | |
| 49 | 2.3.6. Насан туршийн боловсролын хүртээмжийг нэмэгдүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ. | 1. Тэгш хамран сургах дүйцсэн хөтөлбөр, бичиг үсгийн сургалтын хүртээмж, чанарыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 650 | 2021-2022 оны хичээлийн жилд Боловсрол нөхөн олгох хөтөлбөрт 387 суралцагч суралцсанаас бага боловсролд 21, суурь боловсролд 174, бүрэн дунд боловсролд 192 суралцагч суралцаж, бага боловсролыг 4, суурь боловсролыг 63, бүрэн дунд боловсролыг 69 суралцагч эзэмшлээ. 2022-2023 оны хичээлийн жилд 473 суралцагч суралцаж байгаагаас бага боловсролд 30, суурь боловсролд 220, бүрэн дунд боловсролд 223 суралцагч байна. Суралцагчдын тоо өмнөх хичээлийн жилээс 17 хувиар нэмэгдсэн байна. Нийт суралцагчдын 36 нь хийдэд шавилан суудаг ламхай, 22 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэн байна | |
| 50 | | 2. Насанд хүрэгчдийн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх | 2021 - 2024 | | 15000 2 | Насан туршийн боловсролын төвөөс орон нутгийн Насан туршийн боловсролын нэгжүүдийг удирдлага арга зүйгээр хангаан ажилладаг. Энэ жилийн онцлог ажил нь “Өрхийн хөгжлийг дэмжих арга хэмжээ”, Нэг нэгж-Нэг брэнд ажил”, “Захиалгат сургалт” байсан. Төв болон нэгжүүдээр 2022 онд хийгдсэн иргэдийн боловсролыг дээшлүүлэх сургалт, нөлөөллийн үйл ажиллагааг нэгтгэн харвал: Амьдрах ухаан, гэр бүл, иргэний, гоо зүй, ёс зүй, шинжлэх ухааны боловсрол гэсэн үндсэн агуулгаар 886 удаагийн сургалтаар 43270 иргэнд, 460 удаагийн нөлөөллийн үйл ажиллагаагаар 30485 иргэнд боловсролын үйлчилгээг үзүүлсэн байна. Боловсролын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн 65 хувь нь эмэгтэй, 49 хувь нь хүүхэд, 25,3 хувь нь төрийн албан хаагч, 8,1 хувь нь малчин, 10,1 хувь нь хувиараа хөдөлмөр эрхлэгч, 5 хувь нь ажилгүй, 2,4 хувь нь тэтгэврийн насны иргэд байна. Иргэдийг зөв хандлага, зөв үйлд уриалсан 543 постер, 229 шторк, 290 видео бичлэгийг гарган орон нутгийн цахим сүлжээгээр олон нийтэд хүргэн тэдний амьдралын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | чанарыг дээшлүүлэхэд чиглэсэн боловсролын үйлчилгээг үзүүлсэн. НТБ-ын нэгжүүд “Уран бичлэг”, “Үсчин”, “Гоо сайхан”, “Уран уншигч” зэрэг 10 гаруй дугуйланг хичээллүүлсэн. Монгол банк, арилжааны банкнууд, сургууль, эрүүл мэндийн төв, ХХҮГ, ЭМГ, ГБХЗХГ, Улсын бүртгэлийн хэлтэс зэрэг 20 гаруй төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран ажиллаж салбар хоорондын уялдааг хангасан. | |
| 51 | 2.3.7. Орон нутагт эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтнуудыг бэлтгэнэ. | 1. Эрэлт хэрэгцээтэй мэргэжилтэй ажилтанг бэлтгэж, ажлын байраар хангах | 2021 - 2023 | | 400 | Баянхонгор коллежийн 2021-2022 оны хичээлийн жилд 18 мэргэжлээр 42 бүлгийн 848 суралцагч мэргэжлийн боловсрол эзэмшиж байна. Үүнээс 2021 онд 339 суралцагч мэргэжлийн боловсрол эзэмшиж төгссөнөөс 208 буюу 58% нь ажлын байраар хангагдлаа. Үндсэн сургалтуудаас гадна богино хугацааны түр сургалтыг Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр, аймгийн ХХҮГ-тай хамтран иргэдэд мэргэжил олгох 14-21 хоногийн түр сургалтуудыг тогооч, үсчин, барилгын засал чимэглэлчин, барилгын өрөг угсрагч, автомашины засварчин, оёмол бүтээгдэхүүний оёдолчин мэргэжлүүдээр зохион байгууллаа. Нийт 400 гаруй хүн сургалтад хамрагдаж ажлын байртай боллоо. | |
| 52 | 2.3.8. Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжоор хангах, сургуулийн орчны нэвтрэлт бүртгэлийн | 1. "Онлайн кабинет" төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 5 | Ерөнхий боловсролын сургуулийн сургалтын үйл ажиллагааг цахимаар зохион байгуулах боломжийг нэмэгдүүлж Малчдын хүүхдийн боловсролыг дэмжих тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд 641,0 сая төгрөгийн өртөг бүхий "Дижитал танхимыг" Баянхонгор сумын Номгон, Эрдэнэмандал, Эрдэм, Соого сейкео, Гэгээн Сумади сургууль, Бууцагаан, Өлзийт, Бөмбөгөр, Жаргалант сумын ЕБС нийт 9 сургуульд байгууллаа. Ухаалаг самбарыг ЕБС-д нийлүүлж сургалтын орчныг бүрдүүлсэн. Мөн боловсролын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн хүрээнд бичил лабораторийг Баянхонгор сумын 5 дугаар сургууль, Богд, Эрдэнэцогт, Галуут, Баянлиг сумын Ерөнхий боловсролын сургуулиудад нийлүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 53 | системийг шинээр нэвтрүүлнэ. | 2. Багш нарыг компьютер, таблетаар хангах | 2021 - 2024 | | 300 | Боловсролын салбарын тоног төхөөрөмж нийлүүлэх төслийн 1 тэрбум 478,9 сая төгрөгөөр сургууль, цэцэрлэгийн багш нарын 50 хувийг компьютержуулах ажлын тендерт Саммет компьютер технологи ХХК шалгарч сүүлийн үеийн үзүүлэлт өндөр нийт 600 ширхэг зөөврийн компьютерыг сургууль цэцэрлэгт нийлүүлснээр багш нар цахим орчин сургалт явуулах нөхцөл бүрдсэн. | |
| 54 | 2.4.1. Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн үйл ажиллагааг сайжруулна. | 1. Сургалтын орчныг сайжруулж, боловсон хүчнийг чадавхжуулах | 2021 - 2024 | | 150 сая | Худалдаа үйлдвэрлэлийн дээд сургуулийн менежментийг өөрчилж хөдөө аж ахуйн их сургуулийн салбар сургууль болгон улирлын болон эчнээ ангиудыг нэн шаардлагатай мэргэжилтнүүдээр нээн элсэлтээ авч байна. Сургуулийн барилга барих газрын асуудлыг шийдвэрлэж зураг төсөв хийгдсэн Баянхонгор аймагт ХААИС-ийн салбар сургууль бий болж байгаатай холбоотой ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн захирал тус аймагт ажиллаж хамтран ажиллах болсон. Сургалтын орчныг сайжруулах чиглэлээр боловсролын салбарын тоног төхөөрөмжийг нийлүүлсэн байна. | |
| 55 | 2.4.2. "Бизнесээ эхэл-Бизнесээ хөгжүүл" сургалтыг үе шаттайгаар зохион байгуулж, жижиг дунд үйлдэрлэл эрхлэгчдийг дэмжинэ. | 1. Аж ахуй эрхлэлтийн сургалтыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 100 | Аж ахуй эрхлэлтийг дэмжих "Бизнесээ эхэл-бизнесээ хөгжүүл" сургалтыг "Хөгжлийн шийдэл" ТББ-тай хамтран зохион байгуулж, хөдөлмөр эрхлэлтийн төсөл, хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй 250, төсөл хөтөлбөрт хамрагдсан 264, нийт 514 жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчид, иргэдийг хамруулж чадавхжууллаа. Арга хэмжээнд Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 14.724.00 төгрөгийг зарцуулсан. Сургалтад хамрагдсан иргэдийн тоо өмнөх оноос 211 хүнээр өссөн байна. | |
| 56 | 2.4.3. Шинэ мэдлэг, патент гаргасан эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшлийн | 1. Эрдэм шинжилгээний багийг байгуулж, шинэ мэдлэг патентийг бий | 2022 - 2024 | | 4 | Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дүгээр сарын 05-ны өдрийн А/212 дугаар захирамжаар Шинжлэх ухаан технологийн салбар зөвлөлийг аймгийн Засаг даргын орлогчоор ахлуулан байгуулсан. Шинэ мэдлэг патентад Ингэний сүү сүүн бүтээгдэхүүн, Шинэжинстийн цагаан ямаа, Баянлиг сумын Ламын гэгээний улаан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгааг гарган бүртгэлжүүлж, урамшуулна. | болгох | | | | тэмээ зэрэг үүлдэрт патент олгосон байна. | |
| 57 | 2.5.1. Хүн амын хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлж, иргэдийн амьдралаа авч явах дадал, хэвшлийг дээшлүүлэх чиглэлээр олон талт арга хэмжээг зохион байгуулна. | 1. Аймгийн бүтээн байгуулалтын ажилд ажлын байр бий болгох, ажил хайгч бүртгэлтэй иргэдийг хамруулах | 2021 - 2024 | | 500 | Аймгийн бүтээн байгуулалтын ажлууд буюу ногоон байгууламж бий болгоход дэмжлэг үзүүлж, шон суулгах, хайс хамгаалалт хашлага татах, хог хаягдал ангилан ялгах, засмал зам дагуух хайрга чулууг түүх, динозавртай паркийн хашааг буулгах зэрэг аймгийн өнгө үзэмж, ногоон байгууламжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2022, хувийн аж ахуй нэгж, байгууллага болон бусад хөтөлбөр, төслийн хүрээнд байнгын ажлын байранд 1381, нийт 3403 ажлын байрыг бүртгэл мэдээллийн нэгдсэн санд бүртгэж, мэдээлсэн. Шинээр бий болсон ажлын байрны 692 буюу 31.7 хувь нь байнгын ажлын байр эзэлж байна. Түр ажлын байр бий болгоход Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас 620.0 сая төгрөг зарцуулсан нь өмнөх оны санхүүжилтээс 480.0 сая төгрөгөөр, түр ажлын байраар хангагдсан иргэдийн тоо 1406 хүнээр нэмэгдсэн байна. Энэ нь Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд мод тарих арга хэмжээнд 980 иргэн хамрагдаж, түр ажлын байраар хангагдсан нь нөлөөлсөн. | |
| 58 | 2.5.2. Өрхийн болон хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэдийг дэмжин ажлын байрыг нэмэгдүүлнэ. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлж, ажлын байрыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 250 | Иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж 2021 онд “Цар тахалын үед аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”,”Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг 5 хөтөлбөрийг хэрэгжүүлж, нийт 1301 хүнд 555,7 сая төгрөг зарцуулсан. Үүнээс байнгын болон түр ажлын байранд нийт 1243 иргэн зуучлагдсан. 2022 онд “Хөдөлмөрт бэлтгэх хөтөлбөр”, “Аж ахуй эрхлэгчдийн үйл ажиллагааг сэргээх хөтөлбөр”, “Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр”, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих”хөтөлбөр “Ногоон ажлын байр хөтөлбөр”, “Эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөр” зэрэг 7 хөтөлбөр арга хэмжээнд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | давхардсан тоогоор 4200 иргэн хамрагдаж 1.9 тэрбум төгрөг зарцуулсан. Хөтөлбөрүүдийн үр дүнд байнгын ажлын байр 463, түр ажлын байр 1714 бий болсон. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих үйлчилгээ, арга хэмжээнд хамрагдсан хүний тоо өмнөх оноос 30.9 хувиар өсч, зарцуулсан хөрөнгийн хэмжээ 29.2 хувиар нэмэгдсэн. | |
| 59 | 2.5.3. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн баталгааг хангана. | 1. Иргэдэд нийгмийн даатгалын үйлчилгээний ач холбогдлыг таниулж, нийгмийн баталгааг хангах | 2021 - 2024 | | 7820 | Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг нийгмийн даатгалд хамруулах ажлыг эрчимжүүлэх зорилгоор сумдын Засаг дарга нартай гурвалсан гэрээ байгуулж ажиллалсан. Гэрээний хэрэгжилтийн дундаж 95.6 хувьтай байна. Малчид болон албан бус хөдөлмөр эрхлэгч мөн ажил хөдөлмөр эрхэлдэггүй 12188 иргэнийг нийгмийн даатгалын сайн дурын даатгалд, 0-3 настай хүүхдээ асарч буй эх 1409 иргэний сайн дурын гэрээг байгуулж, шимтгэлийг санд төлүүлсэн. Даатгалд хамрагдсан 13597 даатгуулагчийн хамрагдалтыг ажил хөдөлмөр эрхлэлтийн төрлөөр авч үзвэл малчид 6759, хувиараа хөдөлмөр эрхлэгч 1826, ажил хөдөлмөр эрхэлдэггүй иргэн 1253, оюутан 21, бусад 2329, 0-3 насны хүүхдээ асарч байгаа эх 1409 байна. Хувиараа хөдөлмөр эрхлэгч болон тодорхой хөдөлмөр эрхэлдэггүй иргэд 5826, малчин 12273, оюутан 1373, нийт 19472 даатгуулагч эрүүл мэндийн заавал даатгалд хамрагдсан нь нийт /40860 хүн/ хамруулбал зохих иргэдийн 47.6 хувь байна. Шинээр сайн дурын нийгмийн даатгалд даатгуулагчдын хувь өмнөх онуудаас 2.9 хувиар, эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагч 3950 хүнээр буюу 5.1 хувиар тус тус өссөн байна. | |
| 60 | 2.5.4. Нийгмийн халамжийн бодлогын хүрээнд амжиргааны баталгаажих түвшингээс доогуур орлоготой, | 1. Хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийг нийтийг хамарсан ажилд хамруулах | 2021 - 2024 | | 200 | Хүнсний эрхийн бичгийн үйлчилгээ авч байгаа иргэдийн судалгаагаар хөдөлмөрийн насны 1100 иргэн байгаагаас ажил идэвхтэй хайгч 609 иргэн байна. Дээрх иргэдээс байнгын ажлын байранд 28 иргэн, аймгийн бүтээн байгуулалтын ажил буюу мод тарих, явган замын өнгөт хавтан суурилуулах, хог хаягдал ангилан ялгах, цэвэрлэх, улирлын чанартай түр ажлын байранд 300 иргэнийг тус тус зуучилж, ажлын байраар хангасан. Хөдөлмөрт бэлтгэх сургалтад 220, аж ахуй эрхлэлт, төсөл хөтөлбөрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хөдөлмөр эрхлэх чадвартай иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ. | | | | | сургалтад 50, амьдралын итгэл үнэмшил олгох, хөдөлмөрт бэлтгэх, авьяасыг нь дэмжих бүлэг үүсгэх сургалтад 160, өдөрлөг яармаг, бусад арга хэмжээнд 349, 779 иргэнийг хамруулж чадавхжууллаа. Нийгмийн халамжийн сангийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээний бүлгийн төсөлд 2021 онд 6 бүлгийн 14 гишүүнийг 8.7 сая төгрөгийн, 2022 онд 4 бүлгийн 8 гишүүнийг 6.9 сая төгрөгийн буцалтгүй санхүүгийн дэмжлэгт хамруулж, түр ажлын байраар хангасан. Дээрх арга хэмжээнүүдэд давхардсан тоогоор амьжиргааны түвшнээс доогуур орлоготой 1136 иргэн хамрагдсан байна. | |
| 61 | 2.5.5. Иргэдийн санхүүгийн боловсролыг нэмэгдүүлэх замаар хуримтлалтай болгох арга зүйд сургаж, аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх чадвартай болгон “Хуримтлалтай хүүхэд” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Хүүхэд бүрт хүүхэд хөгжлийн карт олгож, сар бүр тус картад хүүхдийн хөгжилд зарцуулах дэмжлэг олгох" | 2022 - 2024 | | 10000 | Монгол улсын Засгийн газраас ирээдүйн өв сангийн тухай хуульд заасны дагуу бэлнээр болон хуримтлуулах хүсэлт гаргасан иргэдийн хүсэлтийг хүлээн авч ажиллаж байна. Аймгийн хэмжээнд жилийн эцсийн байдлаар 0-18 хүртэлх насны 33996 хүүхдэд 40,781.2 сая төгрөгийг олгон ажиллалаа | |
| 62 | 2.6.1. Түүх соёлын дурсгал, биет болон биет бус өвийн хадгалалт, | 1. Түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалтыг сайжруулах | 2021 - 2024 | | 8 | Улсын хамгаалалтай 13, аймгийн хамгаалалтай 53 нийт 66 түүх соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг ойролцоо нутагладаг малчин иргэд, соёлын төв, сумын Засаг дарга нартай гурвалсан гэрээг байгуулан орон нутгийн түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулахад анхаарч ажилласан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 63 | хамгаалалтыг сайжруулан, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлэн сурталчилна. | 2. Иргэдийн гар дээр байгаа баримтат өвийг бүртгэх | 2021 - 2024 | | 45 | Ард иргэдийн гар дээр хадгалагдаж байгаа баримтат өвийг хэрхэн бүртгэх талаарх мэдээллийг цахим хэлбэрээр иргэдэд сурталчиллаа.Соёлын төвийн ажилтнуудаар дамжуулан сум орон нутгийн иргэдэд сурталчлах ажлыг зохион байгуулсан.Гонгандандэдлин хийд, Чинсүжигт Номунханы хийдийн 30 баримтат өвийг цахим бүртгэлд баримтжуулсан. | |
| 64 | | 3. Биет бус өвийг хамгаалан түгээн дэлгэрүүлэх сургалт, уралдаан тэмцээн зохион байгуулах | 2022 - 2024 | | 3 | Түүх, соёлын үл хөдлөх дурсгалын улсын үзлэг тооллогыг амжилттай зохион байгуулж Улсын хамгаалалтай 13, Аймгийн хамгаалалтай 53 дурсгалт газрын Улсын тооллого-2022” хээрийн үзлэг судалгаанд 20 сумын нутаг дэвсгэрт нийт 346 дурсгалт газрын 4517 дурсгалыг тооллогод хамруулахаас 333 дурсгал тоологдож бүртгэлийн RICH 3.0, www.rich.mongoluv.mn программд тус тус бүртгэн аймгийн хэмжээнд 96.24 % хувьтай явагдаж дууссан. Мөн түүх, соёлын үл хөдлөх дурсгалт газруудыг ойролцоох айлуудад гэрээгээр хамгаалуулах ажлыг хийсэн Монгол Улсын Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Соёл,урлагийн газрын даргын тушаал 2022 оны А/42 тоот тушаалаар Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах ажлыг Аймгийн Засаг даргын 2022 оны А/652 тоот захирамжаар тооллогын ажлын хэсэг томилж бүсчилсэн судалгаа хийж нийт 315 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хамрагдахаас 202 өвлөн уламжлагчаас 3 багц төрлийн 55 асуулгаар судалгааг авч ажиллалаа. Аймгийн хэмжээнд 20 сумын ардын авьяастнуудын дунд соёлын биет бус өвийг түгээн дэлгэрүүлж, олон нийтэд хүргэх зорилго бүхий урлагийн бага наадам зохион байгуулж нийт 120 гаруй өвлөн уламжлагчдыг оролцуулж "Нүүдэлчин монгол" наадамд Баянхонгор аймгаас 60 гаруй хүний бүрэлдэхүүнтэй 7 ай савын төрлөөр оролцож 3 төрөлд шагналт байр эзлэн соёлын биет бус өвийг олон нийтэд сурталчилсан. | |
| 65 | 2.6.2. Соёл урлагийн салбарыг | 1. Мэргэжлийн урлагийн байгууллага, | 2021 - 2024 | | 70<br>170 | Соёл урлагийн салбарын албан хаагчдыг 3-4 удаагийн цахим болон танхимын сургалтад хамруулж давхардсан тоогоор 458 хүн хамрагдаж, 6 сумыг мэргэжлийн хөгжмийн багш, эрхлэгч, орон | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэргэжлийн боловсон хүчнээр хангаж, тэдний ур чадвар, ажиллах орчин нөхцлийг сайжруулна. | соёлын төвүүдийг мэргэжлийн боловсон хүчнээр хангах | | | | нутаг судлах танхимын ажилтнаар хангаж, Хөгжимт драмын театрын 4 бүжигчнийг мэргэжил дээшлүүлэх сургалтад хамрагдаж мэргэжлийн боловсон хүчний хангалт 64 хувьд хүрч өмнө оноос 7 хувиар нэмэгдсэн. | |
| 66 | | 2. Соёлын төвийн бүтэц орон тоог нэмэгдүүлэн соёлын өвийн ажилтны орон тоог нэмэгдүүлэх | 2022 - 2023 | | 6 | Мэргэжлийн хөгжмийн багш, соёлын төвийн эрхлэгч, орон нутаг судлах танхимын ажилтанаар 6 сумын соёлын төвийг ханган ажиллалаа. Соёлын өвийн ажилтаны ажлын байрыг 11 сумд шийдвэрлэсэн байна. | |
| 67 | 2.6.3. “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Соёлтой Баянхонгорчууд" хөтөлбөр боловсруулан хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 70 | “Соёлтой-Хонгорчууд” арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах хүрээнд бүх сум, орон нутгийн иргэдээс авсан иргэдийн соёлын боловсролын түвшин тогтоох судалгааг 20 сумын нийт 1050 гаруй иргэдээс судалгаа авч нэгтгэн дүгнэлт гаргасан. “Бүх нийтийн соёлын боловсролыг дээшлүүлэх ажил арга хэмжээг сар бүрийн ажлын төлөвлөгөөнд тусган үе шаттай зохион байгуулж "Соёлын бүтээлч сар” аяныг гурван зорилтын хүрээнд 30 үйл ажиллагаа, 97 арга хэмжээгээр 22633 хүнд соён гэгээрүүлэх соёлын олон талт арга хэмжээг зохион байгуулан, нутгийн онцлог өв соёлоо таньж мэдэх, өвлүүлэх, сурталчлан дэлгэрүүлэх ажлуудыг зохион байгуулсан. | |
| 68 | 2.6.4. Соёлын төвүүдийн орчин нөхцлийг сайжруулж, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. | 1. Соёлын төвүүдийн барилгыг шинэчлэх, иргэдийг соёлын боловсролын судалгааг хийх | 2021 - 2024 | | 0<br>40 | Хүрээмарал, Заг, Баянлиг, Галуут, Өлзийт, Жинст, Эрдэнэцогт, Бууцагаан, Гурванбулаг, Шинэжинст сумдын соёлын төвийг шинээр барьж ашиглалтад оруулж тоног төхөөрөмжөөр хангах үйл ажиллагааг үе шаттайгаар шийдвэрлэж байна Иргэдээс соёлын боловсролын судалгааг түүвэрлэн авч цаашид авах арга хэмжээний талаар саналт хүсэлт боловсруулсан | |
| 69 | | 2. Зарим сумдын соёлын төвийн | 2022 - | | 1 | Баянлиг, Шинэжинст сумдын ОНСТ-д камержуулалт, Баянговь, Жаргалант сумдын ОНСТ-д үзмэрийн баяжилт, тохижилт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | орон нутаг судлах танхимыг өргөжүүлэх | 2023 | | | камержуулалтын ажлыг тус тус хийсэн байна. Баян-овоо сумд орон нутгийн музейг барихаар барилгын ажил явагдаж гүйцэтгэл 40 хувьтай байна. | |
| 70 | | 3. Соёлын төв, мэргэжлийн урлагын байгууллагын тоног төхөөрөмжийг сайжруулах | 2021 - 2024 | | 2 | Хүүхдийн Тэмүжин театрыг нэн шаардлагатай 16 нэр төрлийн тоног төхөөрөмжөөр, Байгалийн түүхийн музей, болон түүх угсаатны зүй музейн үзмэрийн хадгалалт хамгаалалтыг сайжруулах дохиолол хамгаалалтын системийг шинэчлэх, зарим эд зүйлсийг хамгаалалтад авах ажлыг хийж гүйцэтгэсэн. Хөгжимт драмын театрын 60 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх зорилтот ажлын хүрээнд Хөгжимт драмын театрын нүүрэн талын их засварын ажлыг хийж, гэрэлтүүлгийг шинэчилж гадна орчны тохижилтыг сайжруулсан. | |
| 71 | 2.6.5. Иргэн бүрийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлж, сумдын номын сангийн үйлчилгээг өргөжүүлж, үйл ажиллагааг сайжруулна. | 1. Иргэдийн ном унших дадал, хэвшлийг нэмэгдүүлэх арга хэмжээ зохион байгуулах | 2021 - 2024 | | 90<br>1.5 | Улс болон орон нутгийн төсвийн 24 250 000 төгрөгийн хөрөнгө оруулалтаар нийтийн номын сан болон сумдын номын сангуудыг ном хэвлэлээр хангаж сан хөмрөгийн баяжилтыг хийж уншигчдын тав тухтай үйлчлүүлэх орчин нөхцөлийг бүрдүүлж “Номын баяр”, “Соёлын бүтээлч сар” аяны хүрээнд “Урилгатай уншлага” аяныг өрнүүлж 3715 иргэнийг цахимаар болон танхимаар хамруулсан. Мөн соёл, танин мэдэхүй, соён гэгээрүүлэх 55 төрлийн ажил, арга хэмжээг зохион байгуулан 8578 хүнд үйлчилсэн байна. | |
| 72 | 2.6.6. Аймгийн түүхийн музейн барилгыг барьж биет болон биет бус өвийн мэдээллийн сангийн баяжилтыг | 1. Хөдлөх дурсгалын мэдээллийн санг баяжуулах | 2021 - 2024 | | 800 | Түүх угсаатны зүй байгалийн музейн сан хөмрөгт байсан 10598 ширхэг үзмэрт 21 үзмэрээр баяжилт хийж үзмэрийн тоо 2,2 хувиар өссөн байна. | |
| 73 | | 2. Биет бус өвийн мэдээллийн санг | 2021 - 2024 | | 11 | Монгол Улсын Засгийн хэрэгжүүлэгч агентлаг Соёл,урлагийн газрын даргын тушаал 2022 оны А/42 тоот тушаалаар Соёлын биет бус өвийн үзлэг, бүсчилсэн судалгааг зохион байгуулах ажлыг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулна. | баяжуулах | | | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/652 тоот захирамжаар тооллогын ажлын хэсэг томилж бүсчилсэн судалгаа хийж нийт 315 соёлын биет бус өвийг өвлөн уламжлагч хамрагдахаас 202 өвлөн уламжлагчаас 3 багц төрлийн 55 асуулгаар судалгааг авч ажилласан. | |
| 74 | 2.7.1. Хүүхдийн хөгжил, төлөвшлийг сайжруулж, монгол өв соёл, зан заншлаа дээдэлсэн, бүтээлч, оюунлаг иргэн болгож, эцэг, эхийн үүрэг оролцоо, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | 1. "Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа" зорилтот төсөл хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 5500 | Арга хэмжээний хүрээнд хүмүүжлийн эерэг аргын сургалтыг 27.075 хүнд зохион байгуулсан.20 сумын сургууль, цэцэрлэгийн “Хүүхэд хамгааллын баг”-ийн нийт 450 орчим гишүүдийг арга зүйгээр хангасан.ЕБС-ын “Хүүхэд хамгааллын баг”-ийн гишүүдийг чадавхжуулах сургалт 70 хүнийг хамруулж Боловсролын салбарын “Хүүхэд хамгааллын баг”-ийн гишүүдийг чадавхжуулах танхимын сургалтыг 2 удаа, ажлын байранд зөвлөн туслах ажлыг 2 удаа зохион байгуулж арга зүйгээр хангасан. “Хүүхдийн хүмүүжил, хөгжил, хамгаалалд хамтдаа” арга хэмжээний хүрээнд 4 зорилт 15 ажил арга хэмжээтэй төлөвлөн хэрэгжүүлж 29714 насанд хүрэгч, 926 сурагчдад хүрч ажилласан. Төлөвлөгөөний биелэлт 92.5 хувьтай.Нөлөөллийн арга хэмжээний үр дүнд үе тэнгийн дээрэлхэлтийн чиглэлээр 75 сургагч багш бэлтгэгдсэн, сургууль, цэцэрлэгийн хүүхэд хамгааллын багийн гишүүд чадавхижсан, нийт эцэг эхчүүдийн 29.9% нь хүмүүжлийн эерэг аргын талаар мэдлэгтэй болсон, Хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын 35.7 хувийг гэрчилгээжүүлсэн, Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагад хамрагдаж байгаа хүүхдийн тоо 14.5 хувиар өссөн. | |
| 75 | | 2. Эцэг эхчүүдийн оролцоог нэмэгдүүлэх сургалт  зохион байгуулах | 2021 - 2024 | | 2500 | ГБХЗХГазар гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг 20 сумын 10623 өрхөд сурталчилсан. Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн халуун дулаан уур амьсгалыг бүрдүүлэх зорилгоор “Хайр түгээе” цахим нөлөөллийн арга хэмжээг зохион байгуулж арга хэмжээний хүрээнд “Хуулиа мэдье” сургалтыг 352 иргэнд зохион байгуулсан. Эерэг хандлага афоризм 2 ширхгийг бэлтгэн олон нийтийн сүлжээгээр цацсан. Нийт хандалтын тоо 2156. 05 сарын байдлаар гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг 19 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 1 нэгжээр буюу 5.5%-иар өссөн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Зөрчил 80 бүртгэгдэж өнгөрсөн оны мөн үеэс 3 нэгжээр буюу 3.9%-иар өссөн дүнтэй байна. Гэмт хэрэг, зөрчлийн тоо өссөн нь илрүүлэлт сайжирсантай холбоотой гэж дүгнэн мэргэжлийн байгууллагуудтай хамтран судалж байна. Төрийн байгууллагын дэргэдэх эцэг эхийн зөвлөлүүдэд зөвлөн туслах арга хэмжээ, сургалтыг 3 удаа зохион байгуулж төрийн 235 байгууллагын ажилтан албан хаагчид хамрагдсан. | |
| 76 | | 3. Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулган зохион байгуулах | 2021 - 2024 | | 70 | Аймгийн хүүхдийн нэгдсэн чуулганыг жил бүр зохион байгуулж хэвшсэн.2022 онд " Нэгдүгээрт хүүхэд" уриан дор “Оролцоог эрхэмлэе-хөгжлийг түүчээлье” сэдвийн хүрээнд зохион байгуулж хүүхдийн өөрөө удирдах байгууллагуудын төлөөлөл 250 гаруй хүүхэд, хүүхдийн элч нар оролцсон.Хүүхдийн нэгдсэн чуулганаар 5 салбар хуралдаан хуралдаж чуулганд оролцогч хүүхдүүдээс 60 төрлийн санал гарсан. Саналыг нэгтгэн шийдвэр гаргагчид болон мэргэжлийн байгууллагуудад хүргүүлж хяналтанд авхуулсан.2020, 2021 оны хүүхдийн чуулганаас гарсан саналын шийдвэрлэлтийн дундаж 77.5 хувьтай хэрэгжсэн. | |
| 77 | | 4. "Хамтдаа шийдье" төсөл хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газар “Хамтдаа шийдье” төсөлт арга хэмжээг мэргэжлийн удирдлага арга зүйгээр ханган НҮБ-ын хүүхдийн сан, аймгийн Засаг даргын тамгын газар,Нийгмийн бодлогын хэлтэс, сумдын ЗДТГ, Жаргалтай амьдрал төвтэй хамтран хэрэгжүүлсэн. Төслийн хүрээнд нийт 20 сумын 10623 өрхөд бага насны хүүхдийн цогц хөгжил, хүмүүжлийн эерэг арга, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хууль, архидалтаас урьдчилан сэргийлэх нь сэдвээр сургалт зохион байгуулан, эрсдэлийн үнэлгээ хийсэн. Төслийн үр дүнд: Сургуулийн өмнөх боловсролоос завсардсан 1168, сургууль завсардсан 12, өсөлт хөгжлийн хоцрогдолтой 4 хүүхэд, архины хамааралтай 8 иргэн, гэр бүлийн хүчирхийллийн 14 кейс нийт 154 кейсийг илрүүлж сумдын хамтарсан баг, Жаргалтай амьдрал төвд холбон зуучилсан. Сумдын хамтарсан багийн 316 албан хаагчийг сургагч багшаар бэлтгэж мэдлэг, чадварыг нэмэгдүүлсэн.Сэтгэл зүйн ганцаарчилсан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | зөвлөгөөг 196 иргэнд өгч, хүүхдийн мөнгөний 19 өргөдлийг шийдвэрлэсэн. Явцын хяналт, шинжилгээ зөвлөн туслах үйл ажиллагааг Нийгмийн бодлогын хэлтсээс 2 удаа зохион байгуулсан. Шинээр 7423 өрхийг хамруулсан. | |
| 78 | | 5. 4 настай хүүхэдтэй аавуудад чиглэсэн зорилтот хөтөлбөр хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 50 | Хүүхдийн хүмүүжилд аавуудын нөлөөлөл судалгааны үндсэн дээр 4 настай хүүхэдтэй аавуудад зориулсан хөтөлбөрийг Баян-Ойт цогцолбор, 5-р цэцэрлэгт туршилтын сургалтыг 2019 оноос зохион байгулж жил бүр сайжруулалт хийж түгээн дэлгэрүүлж байна. 2022 онд 384 аавд хүүхдийн насны онцлог, тархины хөгжил, анхаарах асуудлуудын талаар зорилтот хөтөлбөрт сургалтад хамруулсан. | |
| 79 | 2.8.1. Гэр бүлийн боловсролыг бүх насны хүмүүст амьдралын мөчлөг, насны онцлогт тохирсон байдлаар олгоно. | 1. "Хонгорын гэр бүл" зорилтот арга хэмжээг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | | 60 | “Хонгорын гэр бүл” арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж АЗДТГ-ын Удирдлагын багийн хурлаар хэлэлцүүлэн Засаг даргын А/265 тоот захирамжаар батлуулж хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Захирамжийн хэрэгжилтийг хангах арга зүйн зөвлөгөөг албан байгууллага, сумдын холбогдох мэргэжилтэнүүдэд өгч сум, байгуулагууд үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж эхлээд байна. Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлын хүрээнд гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтыг 1869 хүнд үе шаттайгаар зохион байгуулж 59 сургагч багш бэлтгэсэн. Архины хамааралтай 28 иргэнийг “Жаргалтай амьдрал төв”-д холбон зуучлах, хүүхдийн “Өвгөнжаргалант” зусланд “Аз жаргалтай гэр бүл” тусгай ээлжинд 15 гэр бүлийг хамруулан ажилласан. | |
| 80 | | 2. Хувь хүн, гэр бүлтэй ажиллах хүний нөөцийг бэлтгэх, ажлын байраар хангах, тогтвор суурьшилтай ажиллахад | 2022 | | | Гэр бүлийн боловсрол олгох 8 модуль сургалтын сургагч багш бэлтгэх сургалтыг танхимын хэлбэрээр зохион байгуулж нийгмийн бодлогын мэргэжилтэн-16, насан туршийн боловсролын нэгжийн менежер-33, багийн нийгмийн ажилтан -10 нийт 59 хүнийг хамруулсан. Олон Улсын Улаанбатар Их сургуультай хамтран “Гэр бүл судлал”-ын магистрын ангид орон нутагтаа 30%-ийн хөнгөлөлттэй суралцах боломжийг бүрдүүлж магистрын ангид 8 сумын 25 оюутан элсэн орж амжилттай суралцаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэмжлэг үзүүлэх | | | | | |
| 81 | 2.8.2. Хуримын ордныг ашиглалтад оруулж, гэр бүлд чиглэсэн үйлчилгээний төрлийг өргөжүүлж, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх үйлчилгээг сайжруулна. | 1. Хуримын ордныг ашиглалтад оруулах | 2021 - 2022 | | | Барилгын гүйцэтгэл 95 хувьтай Улсын комисс хүлээн авахад бэлэн болсон. | |
| 82 | | 2. Хуримын ордныг түшиглэсэн гэр бүлийн зөвлөгөө өгөх төв, сумдад загвар төв байгуулах | 2022 - 2024 | | 2 300 | Гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газрын гэр бүлийн мэргэжилтэн, сэтгэл зүйч нар хосын зөвлөгөөг 19 гэр бүлд, ганцаарчилсан зөвлөгөөг 286, бүлгийн зөвлөгөөг 3 бүлгийн 80 хүнд өгсөн. Сэтгэл зүйн зөвлөгөө авсан хүний тоо өмнөх оноос 31.8 хувиар өссөн байна. | |
| 83 | | 3. Монголын гэр бүл судлаачид, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчдийн мэргэжлийн холбоодтой хамтын ажиллагааг өргөжүүлж техникийн туслалцааны төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 190 | Монголын гэр бүл судлаачдын мэргэжлийн холбоотой хамтран гэр бүл судлаачдыг бэлтгэх арга хэмжээг амжилттай хэрэгжүүлсэн | |
| 84 | 2.8.3. Залуучуудын сэтгэл зүй, хөгжил, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн | 1. Залуучуудын хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | Аймгийн Засаг даргын 2022 оны А/196 дугаар захирамжаар Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн бүрэлдэхүүнийг шинэчлэн байгуулсан. Жил бүр гишүүдийн санал зөвлөмжийг тусган үйл ажиллагааны төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж байна. Төлөвлөгөөний биелэлтийн дундаж 94 хувьтай. Үндэсний хөтөлбөр амжилттай хэрэгжиж хугацаа дууссан. | |
| 85 | | 2. "Хариуцлагатай | 2021 - | | 8000 | "Хариуцлагатай 100 залуу" зорилтот арга хэмжээг жил бүр зохион | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | оролцоог дэмжсэн хөтөлбөрт арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 100 залуу элч"- ийг бэлтгэх | 2024 | | | байгуулж хариуцлагатай элчээр 43 байгууллагын 84 залуу бэлтгэгдсэн. 20 сумд Залуучуудын хөгжлийн зөвлөл байгууллагдсан. Тухайн жилийн чиглэл урианы дагуу арга хэмжээг төлөвлөн биелэлтийг ханган ажиллаж байна.“Ирээдүйн босго” төвөөс нөхөн үржихүй эрүүл мэндийн боловсрол олгох зорилгоор өсвөрийн эмч бүлгэмийн 100 сурагчыг үе тэнгийн сургагч багшаар бэлтгэн аймгийн төвийн 7 сургуулийн 350 гаруй сурагчдад энэ талаарх сургалт мэдээлэл, нөлөөллийн үйл ажиллагааг зохион байгуулсан. | |
| 86 | 2.8.4. Жендэр ба хөгжил хандлагыг төлөвшүүлнэ. | 1. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2022 | | | Жендэрийн үндэсний хорооны дүрэм шинэчлэгдсэнтэй холбоотой Аймгийн Засаг даргын А/618 дугаар захирамжаар жендэрийн салбар хороог чиг үүргийн дагуу 25 гишүүнтэй шинэчлэн томилж жил бүр салбарын жилийн төлөвлөгөөг батлан Жендэрийн Үндэсний хороо болон ИТХ-ын тэргүүлэгчид, гишүүдэд тайлагнасан. Аймгийн Засаг дарга, жендэрийн салбар хорооны даргын албан тоотоор сумдад чиглэл хүргүүлж 20 сумд дэд салбар хороо байгуулсан.Гишүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж 155 удирдах ажилтан, гишүүдийг чадавхжуулсан.Аймгийн Засаг даргын сумын Засаг дарга нартай байгуулах гэрээнд жил бүр тусгаж хяналт тавьж хэвшсэн.Сумдын дарга нарын гэрээний хэрэгжилтийн дундаж 57 хувьтай.Сумдын ИТХ-ын дарга, Засаг дарга нарыг мэдээллээр хангах эрчимжүүлэх чиглэл өгсөн.Жендэрийн үндэсний хорооноос зарласан тэтгэлэгт төсөлд хамрагдсан багын боловсруулсан 5 төрлийн контент, шторкыг ГБХЗХГ, Цагдаагийн газар, Хүндлэл хүйс хамааралгүй фэйс бүүкийн чаатаар түгээж 13000 хүн сэтгэгдлээ илэрхийлж дэмжсэн.Жил бүр Өнөөгийн Баянхонгор сонинтой гэрээ байгуулан иргэдэд мэдээлэл олгох ажлыг хэрэгжүүлж 3500 уншигчдад хүргэсэн. Үр дүнгийн уулзалт шийдвэр гаргагч 18 хүн оролцож мэдээллээр хангагдсан.Тайланг нэгтгэж ЖҮХ-д хугацаанд нь хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 87 | | 2. Жендэрийн салбар хороо, дэд хороодын гишүүдийн чадавхийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 80 | Гишүүдийг чадавхжуулах сургалтыг цахимаар болон танхимаар зохион байгуулж 155 удирдах ажилтан, гишүүдийг чадавхжуулсан.Жендэрийн Үндэсний хорооны цахим сургалтад удирдлагуудыг хамруулах арга хэмжээг нэгдсэн журмаар зохион байгуулж байна. | |
| 88 | 2.8.5. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлж, сум бүрт хөдөлмөр зуслан байгуулж, хүүхдийг монгол ахуйд сургана. | 1. Зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хүүхдүүдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 800 | “Өвгөнжаргалант” зусланг түшиглэн “Хүүхэд, гэр бүлд ээлтэй Өвгөнжаргалант зуслан” тусгай хөтөлбөрийн хүрээнд “Хүмүүнлэг иргэн хөгжлийн ирээдүй”, “Зуслан тэгш боломж-тэгш хөгжил”, “Аав, ээж, би - Аз жаргалтай гэр бүл”, “Эрүүл амар тайван гэр бүл” зэрэг хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж Ковид цар тахлын улмаас 2020, 2021 онуудад зуслан ажиллаагүй 2022 онд 337 хүүхэд хамрагдсан. | |
| 89 | | 2. Хөдөлмөр зусланг ажиллуулах | 2021 - 2024 | | 3 | Ковид цар тахлын улмаас хөдөлмөр зуслан ажиллуулаагүй.Өвгөнжаргалант зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан 338 хүүхдэд малчин айлыг түшиглэсэн сургалтыг зохион байгуулсан. | |
| 90 | | 3. Өвгөнжаргалант зусланг орчин үеийн хүүхдийн зуслангийн жишигт нийцүүлэн тохижуулах | 2021 - 2024 | | 40 | Ковид цар тахлын улмаас хөдөлмөр зуслан ажиллуулаагүй.Өвгөнжаргалант хүүхдийн зуслангийн хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан 338 хүүхдийг малчин айл түшиглэн зохион байгуулдаг хөтөлбөрт сургалтад хамруулсан. | |
| 91 | 2.8.6. Хүүхдийн эрхийг дээдлэн “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийг хэрэгжүүлж, аливаа хэлбэрийн хүчирхийлэл, | 1. "Хүүхдэд ээлтэй орон нутаг" хөтөлбөрийн удирдлагын болон хэрэгжүүлэгч багуудын ажлын уялдаа холбоог | 2021 - 2022 | | | “Хүүхдэд ээлтэй орон нутаг” хөтөлбөрийн тайланг нэгжүүдээс 1, 6, 8 саруудад авч нэгтгэн хугацаанд нь тайлагнасан.Засаглал, хүүхэд хамгааллын тайлангийн хуралд орон нутгийн мэдээллийг бэлтгэн цахимаар 1, танхимаар 1 нийт 2 удаа оролцож амжилттай хамгаалсан.“Хүүхдэд ээлтэй орон нутаг хөтөлбөр”-ийн сайн туршлагын эмхэтгэл хэвлэх асуудлыг НҮБ-ын Хүүхдийн сангийн зөвлөх, орон нутгийн удирдлагын багт уламжилж 2650000 төгрөгийн санхүүжилтийг шийдвэрлүүлсэн.ГБХЗХГ, ЭМГ, БШУГ, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | дарамтад өртсөн иргэнийг хамгаалах нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байрны үйл ажиллагааг өргөжүүлнэ. | сайжруулах | | | | төсөл хэрэгжүүлэгч нэгжүүдээс эмхэтгэлийн материалыг хүлээн авч боловсруулж 500 ширхэгийг хэвлэн сум, байгууллага, хамтрагч нарт түгээсэн. | |
| 92 | | 2. Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагуудын үйл ажиллагааг идэвхжүүлэх | 2021 - 2024 | | 10 | Хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагын тоо жил тутам 2020 онд 83 2021 онд 90 болж нэмэгдэн ГБХЗХГазар хүүхдийн өөрөө удирдлагын байгууллагын 80 гишүүнийг Монголын урлагын сэтгэл заслын холбоотой хамтран Банхар арт терапигийн сургагч багшаар бэлтгэн чадавхжуулснаар үйл ажиллагаа идэвхжиж, сайжирсан бөгөөд аймгийн хэмжээнд 156 байгууллага ажиллаж байна. ХӨУБ-д хамрагдаж байгаа хүүхэд өмнөх онтой харьцуулахад 42.3 хувиар өссөн. Сурагчдын нэгдсэн зөвлөлийн салбаруудыг гэрчилгээжүүлсэн. | |
| 93 | | 3. Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах | 2021 - 2024 | | 35 , 85 | ГБХЗХГазар хамтарсан багуудын үйл ажиллагаанд жил бүр хяналт үнэлгээг хийж үр дүнг тооцох ажлыг тогтмол зохион байгуулж мэргэжлийн удирдлага арга зүйгээр хангаж ажиллаж байна. "Шилдэг хамтарсан баг" болзолт уралдааныг аймгийн ГХУСАЗЗөвлөлтэй ГБХЗХГ хамтран зарлаж дүгнэсэн.Сумдын нийгмийн бодлогын мэргэжилтэн, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, дуу хөгжмийн багш нийт 110 хүнийг сэтгэл зүйн анхан шатны зөвлөгөө өгөх арга зүйн сургалтанд хамруулсан. Гишүүдийн мэргэжлийн ур чадвар сайжирч кейс шийдвэрлэлт 25 хувиар нэмэгдсэн. | |
| 94 | 2.8.7. Угийн бичиг хөтлөх уламжлалыг сэргээж, өрх бүр угийн бичиг хөтөлж, хүүхэд, залуучуудад түгээн дэлгэрүүлсэн | 1. Угийн бичгийн хэрэглээг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 25 | Аймгийн Засаг даргын А/542 дугаар захирамжаар Аймгийн төрийн архивын дэргэд "Ураг удмаа судлах" танхим байгуулж, “Угийн бичиг” хөтлөхөд ашиглах программыг нэвтрүүлэх, аймгийн төрийн архивын тасагт бүрдсэн хүн амын тооллогын баримтуудад түшиглэн иргэдийг архивын лавлагаа мэдээллээр хангаж уншлагын танхимаар үйлчлэх боломжийг бий болгож шаардлагатай мэдээлэл лавлах материалын сан бүрдүүлэн ажиллаж байна. Аймгийн Засаг даргын А/650 дугаар захирамжаар ажлын хэсэг байгуулагдан 5-багт хуваагдан нийт 19 сумд ажиллаж угийн бичиг хөтлөлтийн суурь | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байна. | | | | | судалгаа хийж угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх арга зүйн сургалтыг зохион байгуулсан. Сургалтад 8130 хүн хамрагдсан. Суурь судалгааны дүнд угийн бичиг хөтлөлт 10.2 хувьтай болж 2.1 хувиар өссөн. | |
| 95 | 2.8.8. Сайн дурын үйл ажиллагааг дэмжин ажиллана. Сайн дурын үйл ажиллагаа эрхлэх иргэд, ААН-үүдийг хооронд нь холбох, үнэлэх системийг сайжруулна. | 1. Сайн дурын ажлыг бүртгэх, баталгаажуулах | 2021 - 2024 | | 70 | Жил бүрийн 4 дүгээр сарыг “Сайн үйлсийн сар” болгон Дэлхийн олон орны иргэд сайн дураараа нийгмийн сайн сайхны төлөө, нийтэд тустай ажил өрнүүлж сайн үйлсийн өдрийг тэмдэглэн өнгөрүүлдэг уламжлалтай. Тус аяныг 4 дүгээр сард аймаг орон нутгийн хэмжээнд өрнүүлэн, төрийн болон төрийн бус байгууллага, иргэд, залуучуудад сайн үйлсийн ойлголт хандлагыг бий болгох идэвхжүүлэхэд хувь нэмэр оруулах зорилгоор - Нэг залуу - Нэг санаачилга - Нэг байгууллага - Нэг сайн үйлс Нэг анги - Нэг сайн дурын үйл ажиллагаа уриан дор сайн үйлсэд нэгдэхийг уриалж 30 байгууллагад албан бичиг уриалгыг хүргүүлж 18 байгууллага оролцож 3354 хүүхэд, залуучууд, ахмад настнуудад сайн дур, сайн үйлсийн ажил үйлчилгээ хүрсэн. Цаашид сайн дурын ажлын ойлголт мэдээллийг нэмэгдүүлэх, ажлын цагийг баталгаажуулах үнэлэх ажлын арга зүйг боловсруулж байна. | |
| 3. ГУРАВ. ЭДИЙН ЗАСГИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 96 | 3.1.1. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган татвар төлөгчдийг бүрэн хамруулж татварын орлогын суурийг нэмэгдүүлнэ. | 1. Төрийн бусад байгууллагуудтай хамтран хөрөнгийн татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах | 2021 - 2024 | | 1150 | 2021 онд “Галт зэвсгийн албан татвар төлөгчийн бүртгэл мэдээллийг Цагдаагийн байгууллагын нэгдсэн сантай тулгах, бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг хамруулах, бүртгэлийн зөрүүг арилгаж, нуугдмал галт зэвсгийг илрүүлэх ажлын удирдамж”, авто тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг татварт бүрэн хамруулах зорилгоор “Цахимаар татвараа төлж, цар тахлаас сэргийлье” удирдамжийн дагуу татварын системд бүртгэлтэй 5247 галт зэвсгийн бүртгэлийг Цагдаагийн газрын галт зэвсгийн сангийн 1970 галт зэвсгийн мэдээлэлтэй тулгаж, 2878 галт зэвсгийг мэдээллийн сангаас хассан. Галт зэвсэг эзэмшдэггүй хуулийн этгээд дээр ногдол үүссэн 32 галт зэвсгийг хасаж, 583 галт зэвсэг эзэмшигчийн мэдээллийг засварлан Цагдаагийн газрын галт зэвсгийн сангаас 38 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | галт зэвсгийг хассан. 2022 онд "Татварын удирдлагын нэгдсэн системд бүртгэлтэй татвар төлөгч хувь хүн, хуулийн этгээдийн үл хөдлөх эд хөрөнгийн бүртгэлийн мэдээллийг сайжруулах зөрүүг арилгах хүрээнд татварын хэлтэст бүртгэлтэй 950 үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээг татварын зорилгоор шинэчилж, 44 үл хөдлөх эд хөрөнгийг шинээр бүртгэлжүүлсэн. Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар төлөгчөөр 2022 онд 53 иргэн, хуулийн этгээдийг шинээр татвар төлөгчөөр бүртгэсэн. Татан буугдах хүсэлт ирүүлсэн 8 хуулийн этгээдийн хүсэлтийг Татварын ерөнхий газарт хүргүүлэн 7 хуулийн этгээдийг бүртгэлээс шууд хасалт хийгдсэн. Мөн нэмэгдсэн өртгийн албан татвар суутган төлөгчөөр 56 аж ахуйн нэгж, иргэнийг шинээр бүртгэж, 5-аас дээш жил үзлэг оношлогоонд хамрагдаагүй 3308 тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасалт хийж, авто тээврийн хэрэгслийн албан татвараар 640.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 656.7 сая төгрөг төвлөрүүлсэн, төлөвлөгөөний биелэлт 102.6 хувь, үл хөдлөх эд хөрөнгийн албан татвараар 400.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 392.4 сая төгрөг төвлөрүүлсэн, төлөвлөгөөний биелэлт 98.1 хувь, галт зэвсгийн албан татвараар 55.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 51.2 сая төгрөг төвлөрүүлсэн төлөвлөгөөний биелэлт 93.0 хувь байна. | |
| 97 | | 2. Газрын төлбөр ногдуулалт нэхэмжлэлийг 100% хийж дуусгах, шугам сүлжээнээс газрын төлбөр авч татварт хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулж бааз суурийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 380 | Аймгийн ИТХ-ын 2021 оны 6/24 тогтоолоор 2022 онд 460.0 сая төгрөгийн газрын төлбөрийн орлого төсөвт төвлөрүүлэх төлөвлөгөөтэйгээс жилийн эцсийн байдлаар 76 хувь буюу 349,7 сая төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Аймгийн ИТХ-ын 2021 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн 6/25 тогтоолын дагуу 20 сумын хэмжээнд тайлант онд 25552 нэгж талбарт газрын төлбөр, татварын ногдуулалтыг үүсгэхээс 2022 оны жилийн эцсийн байдлаар 22573 нэгж талбарт 631.7 сая төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэсэн татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг 20 сумын хэмжээнд зохион байгуулан ажиллаа. Үүнээс: Бөмбөгөр суманд байрлах уурхайтай холбоотой 160 гаруй сая төгрөгийн газрын төлбөрийн ногдлыг хураахаар татвар төлөгчдөд хандахад | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үндэслэлгүйгээр их төлбөрийн ногдол үүсгэсэн, маргаантай байгаа үндэслэлээр Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрыг шүүхэд өгнө гэсэн байдлаар нэг ч уурхай төлбөрөө төлөөгүй байна. Энэ нь газрын төлбөрийн орлогын гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж байна. Газрын төлбөрийн орлогоор 2022 онд 460.0 сая төгрөг төвлөрүүлэхээс 349.7 сая төгрөгийг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 76.0 хувь байна. | |
| 98 | 3.1.2. Аймгийн Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг сумдад зохион байгуулна. | 1. Эрсдэл өндөртэй төсөвт байгууллагуудад санхүүгийн хяналт шалгалт, үзлэг зохион байгуулах | 2021 - 2024 | | 9 | Засаг даргын нэрэмжит санхүүгийн нэгдсэн шалгалтыг 2021 онд Баацагаан, Баянлиг, Эрдэнэцогт, Жаргалант сумд , 2022 онд Баян-Овоо, Бууцагаан, Шинэжинст, Баян-Өндөр нийт 8 сумдын төсөвт байгууллагуудын 2019-2021 санхүүгийн үйл ажиллагаанд хяналт шалгалт, дотоод аудит, санхүүгийн үзлэг зөвлөн туслах ажлыг хийж гүйцэтгэсэн . Тус шалгалтаар 347,713.0 мянган төгрөгийн зөрчил илрүүлж 17,812.9 мянган төгрөгийн албан шаардлага бичиж, 63,929.4 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 265,970.7 мянган төгрөгийн зөвлөмж өгч, санхүүгийн үйл ажиллагааны эрсдэлийг 8 хувиар бууруулсан. Тайлант онд 586,181.7 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 68,388.2 мянган төгрөгийн албан шаардлага , 31,036.1 мянган төгрөгийн төлбөрийн акт, 486,730.4 мянган төгрөгийн зөвлөмжийг өгч Баян-Овоо сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 28,8 хувь, Бууцагаан сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 32,2 хувь, Шинэжинст  сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 21,4 хувь, Баян-Өндөр сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 16,2 хувь, Эрдэнэцогт сумын төсөвт байгууллагуудын эрсдэлийг 42,65 хувь тус тус бууруулж ажилласан. Нийт эрсдэлийн түвшинг бууруулж 24,65 хувьд хүргэж, 31,063,101 төгрөгөөр төсвийн үр ашгийг дээшлүүлж ажилласан. | |
| 99 | | 2. Аудитын шалгалтаар илэрсэн зөрчил, алдаа дүгнэлтийг байгууллага тус | 2021 - 2024 | | 3 | Санхүү, төрийн сангийн хэлтсийн зүгээс төсөвт байгууллагуудын санхүүгийн тайланд өгсөн аудитын зөвлөмж, алдаа зөрчлийг бууруулах зорилгоор 2021, 2022 оны 10 дугаар сард аймгийн хэмжээний төсөвт 151 байгууллагуудын 3 дугаар улирлын санхүүгийн тайланг гаргуулан хянаж, анхан шатны бүртгэл хөтлөлт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бүр дээр хэлэлцүүлж, залруулах арга хэмжээ авах | | | | болон санхүүгийн программын ашиглалтын байдалд хяналт хийн, санхүүгийн тайлангаар илэрдэг нийтлэг алдаа зөрчил, түүнийг хэрхэн арилгах заавар зөвлөгөө өгч, залруулга хийж, холбогдох хяналт шалгалтын байгууллагуудаас хууль, тогтоомж, цаашид анхаарах асуудлын талаар мэдээ мэдээллийг өгч ажиллалаа. | |
| 100 | 3.1.3. Хуримтлалтай хонгорчууд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Хуримтлалын бүлгийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 138 | Тус аймгийн хэмжээнд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байгаа хуримтлалын 125 бүлэг байгаа бөгөөд нэг бүлэг 1 жилд 5 саяас 30 сая төгрөгийг хуримтлуулж, ноогдол болгон хуваан авч байна. Нийт хуримтлуулсан мөнгөний 60% нь зээлд гарсан байна. Зээлийг Бизнес, Эрүүл мэнд, Боловсрол, Өдөр тутмын ахуйн хэрэгцээндээ зориулж авсан байна. Тус оны төсөвт санхүүжилт тусгаагүй болон COVID-19 цар тахалтай холбоотойгоор Бүх нийтийн бэлэн байдал зарлаж, сургалт уулзалтууд цуцлагдсан тул бүлгийн сургалт зохион байгуулаагүй боловч өмнө үүсгэсэн бүлгүүдэд заавар зөвлөгөө өгч үйл ажиллагаа хэвийн явж байна. Өнгөрсөн онд хуримтлалын бүлгүүдийн төлөөлөл 315 хүнийг хамруулсан зөвлөгөөн болон спортын тэмцээнийг зохион байгууллаа. Зөвлөгөөнөөр "Хуримтлалтай Хонгорчууд" дэд хөтөлбөрийн хүрээнд гишүүдийг нэгдсэн зохион байгуулалтанд оруулах, дотоод дүрэм журам боловсруулах ажлууд хийгдлээ. Энэ онд 3 бүлгийг шинээр зохион байгууллаа. Хуучин бүлгүүдийн судалгааг цуглуулж мэдээллийн сантай болсон. | |
| 101 | | 2. Ерөнхий боловсролын сургуулийн сурагчид, иргэдэд санхүүгийн мэдлэг олгох | 2021 - 2024 | | 6 | Дэлхийн хуримтлалын өдрийг зохион байгуулж Хадгаламжийн даатгалын корпорацитай хамтран ЕБС-ийн 1-5 ангийн сурагчдын дунд гар зургийн уралдаан, 6-12-р анги болон Политехнкийн коллеж, Өлзийт МСҮТ-ийн сурагчдын дунд “Ирээдүйнхээ төлөө хуримтлуулцгаая” уриатайгаар постерийн уралдааныг зарлаж 150 орчим гар зургийн бүтээл ирснээс шилдэгүүдээ шалгаруулж постерийн уралдааны эхний 6 байр, видео бичлэгийн 3 байрууд, 50,000 төгрөгийн хадгаламжийн эрхийн бичиг, дурсгалын зүйлээр урамшуулсан. Аяны хүрээнд санхүүгийн боловсролыг түгээснээрээ аймгийн хэмжээнд 100 орчим хүүхэд 22.5 сая төгрөгийн хадгаламж | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр үүсгэсэн байна. Сошиал орчинд давхардсан тоогоор 215 мэдээ, мэдээлэл түгээж 41241 иргэн үзэж сонирхон лайк, шейр хийсэн байна. Мөн "Дэлхийн мөнгөний долоо хоног" аяны хүрээнд Насан туршийн боловсролын төв, Баянхонгор аймаг дахь Монголбанк, Хадгаламжийн Даатгалын Корпораци, хамтран Ерөнхий боловсролын сургуулиудын ахлах, дунд ангийн 620 орчим сурагчдын дунд цахим сургалт зохион байгуулж, “Жижиг мөнгөн тэмдэгтийг хэн сайн цуглуулах вэ” уралдааныг 1 сарын хугацаанд зарласан нийт Баянхонгор аймаг болон 19 сумдаас 60 орчим хүүхэд багачууд цуглуулсан жижиг дэвсгэртээ тушааж нийтдээ 63,000 орчим ширхэг жижиг мөнгөн дэвсгэртийг банкуудад тушааж оролцсон. Дэлхийн мөнгөний 7 хоног аян явагдсан хугацаанд аймгийн банкуудын харилцах 2.6 тэрбум төгрөгөөр өссөн нь иргэд, байгууллагын санхүүгийн боловсрол дээшилсэн төдийгүй банкинд хадгалуулах, хуримтлуулах хандлагатай байгааг илтгэж байна. | |
| 102 | 3.1.4. Тунгалаг санхүү хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. “Жишиг санхүүгийн алба” үзүүлэх сургалт” зохион байгуулах | 2021 - 2024 | | 14 | "Жишиг Санхүүгийн алба үзүүлэх" сургуулийг 2021 онд Баянхонгор, Баян-овоо сумдад зохион байгуулж, 2022 онд Хүрээмарал, Баянбулаг, Заг, Баянцагаан сумдад зохион байгуулахаар төлөвлөсөн ч Ковид цар тахал, Төрийн хэмнэлтийн хуулийг хэрэгжүүлэх хүрээнд Заг, Хүрээмарал, Баянбулаг суманд зохион байгуулах ажлыг цуцалж, Аймгийн Санхүү, төрийн сангийн хэлтэст "Жишиг санхүүгийн алба" үзүүлэх сургуулийг 2022 оны 4 дүгээр сарын 19-22-ны өдрүүдэд 20 сумын Санхүүгийн албаны дарга, мэргэжилтэн нийт албан хаагч нарт, Баянцагаан сумын Санхүүгийн албанд 2022 оны 11 дүгээр сарын 17-ны өдөр Баян-Овоо, Эрдэнэцогт, Богд, Хүрээмарал, Баянговь сумын санхүүгийн албаны шинэ ажилтнуудыг хамруулан тус тус зохион байгуулсан. Энэ сургалтаар төрийн сангийн үйл ажиллагааны журам, төлбөр тооцоо хэрхэн гүйцэтгэж байгаатай нь ижил түвшний нэгжийн үйл ажиллагаатай газар дээр нь танилцснаар ажлын байранд хурдтай дадлагажих төдийгүй харилцан туршлага солилцох давуу талтай. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 103 | | 2. Аж ахуйн нэгжүүд, төрийн бус байгууллагууд санхүүгийн тайлагналт, баталгаажуулалтын хувийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 83 | ААНэгжийн тайланг 2020 онд шинээр бүртгэгдсэн 104 аж ахуйн нэгж, байгууллага,жилийн эцсийн байдлаар нийт 2230 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байснаас төсөвт байгууллага /233/, толгой компани сонгож эрх нь хязгаарлагдсан /70/, хуулийн этгээд дампуурсан /204/, Сураггүй алга болсон /218/ байгууллагуудыг хасч тайлан тушаавал зохих аж ахуйн нэгж, байгууллага 1505 байсан ба нийт тайлан ирүүлэх 1505 аж ахуйн нэгж байгууллагаас 295 аж ахуйн нэгж, байгууллага тайлан ирүүлээгүй,1210 аж ахуйн нэгж, байгууллага тайлан ирүүлж, тайлангийн ирц 80.4 хувьтай байна. 2022 оны тайлангийн хувьд 2021 онд 161 аж ахуйн нэгж, байгууллага шинээр бүртгэгдэж, жилийн эцсийн байдлаар нийт 2358 аж ахуйн нэгж, байгууллага бүртгэлтэй байснаас төсөвт байгууллага /191/, Толгой компани сонгосон /72 /хуулийн этгээд дампуурсан /318/, Сураггүй алга болсон /212/ байгууллагуудыг хасч тайлан тушаавал зохих аж ахуйн нэгж, байгууллага 1565 байна. Нийт тайлан ирүүлэх 1565 аж ахуйн нэгж байгууллагаас 281 аж ахуйн нэгж, байгууллага тайлан ирүүлээгүй,1284 аж ахуйн нэгж, байгууллага тайлан ирүүлж, тайлангийн ирц 83 хувьтай байна. | |
| 104 | | 3. Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой санхүүгийн тайлангийн программыг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 53 | Жижиг, дунд аж ахуйн нэгжүүдэд ашиглаж болох энгийн ойлгомжтой, Сангийн яамны зөвшөөрөлтэй санхүүгийн тайлангийн программыг 2022 онд 16 аж ахуйн нэгж үйл ажиллагаандаа ашиглаж байна. | |
| 105 | 3.1.5. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт хамгаалалтыг | 1. Төсөвт байгууллагуудын дансанд бүртгэлтэй тээврийн хэрэгслийн ашиглалт, | 2021 - 2024 | | 3 | Орон нутгийн өмчит эд хөрөнгийн 2022 оны улсын үзлэг тооллогод орон нутгийн өмчит 173 байгууллагын 740 ширхэг 10,8 тэрбум төгрөгийн тээврийн хэрэгсэл хамрагдлаа. • Тооллогоор “ХУР” системээс 399 ширхэг 7,8 тэрбум төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгсэл татагдаж, 215 ширхэг 3,0 тэрбум төгрөгийн өртөг бүхий тээврийн хэрэгслийг гараас оруулсан. Нийт 740 тээврийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сайжруулна. | хамгаалалттай холбоотой зөрчлийг арилгах | | | | хэрэгслээс 650 тээврийн хэрэгсэл зөрчилгүй, 25 тээврийн хэрэгсэл улсын дугаар авах, 65 тээврийн хэрэгслийн авто тээврийн нэгдсэн сангаас хасалт хийлгэх шаардлагатай байгааг холбогдох байгууллагад хүргүүлсэн. Тооллогод маргаантай 2 тээврийн хэрэгсэл, 1 дутагдуулсан тээврийн хэрэгсэл байгаагаас Богд сумын ЗДТГ-ын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй дутагдуулсан гинжин тракторыг хуулийн байгууллагад шилжүүлсэн. Мөн www.smart.mn сайтаас 67 авто машины 9,5 сая төгрөгийн төлөгдөөгүй татвар, торгуулийг зөрчлийн судалгааг гаргаж холбогдох байгууллагуудад хүргүүлсэн 2022 оны жилийн эцсийн байдлаар 35 авто машины зөрчил арилсан байна. | |
| 106 | | 2. Бүртгэлээр тавих хяналтыг нэмэгдүүлэх, өмч хөрөнгийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, коджуулах | 2021 - 2024 | | 15 | Орон нутгийн өмчит 263 байгууллагын 350,4 тэрбум төгрөгийн хөрөнгийн мэдээллийг www.burtgel.pcsp.gov.mn холбоосонд байршуулж “Төрийн болон орон нутгийн өмчийн тооллогын систем”-д оруулж нэгтгэсэн. Тооллогын хүрээнд : 1. Аймгийн хэмжээнд нийт 696 нэгж талбарын 5,422,454 м2 газар байгаагаас 325 нь буюу 46,7 хувь зөрчилгүй, 298 нь буюу 42,8 хувь нь санхүүгийн тайланд бүртгэлгүй, 117 нь буюу 16,8 хувь нь суурь үнэлгээ зөрүүтэй байгааг холбогдох байгууллагууд болон Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газарт зөрчлийг арилгуулахаар албан тоот хүргүүлсэн. 2. Улсын бүртгэлийн хэлтэстэй хамтарч орон нутгийн өмчит 198 байгууллагын хуулийн этгээдийн хэлбэр хаягийн өөрчлөлтийг бүртгүүлэхэд хамтарч ажиллан 66 байгууллагын зөрчлийг арилгасан, 32 байгууллага мэдээллийг шинэчлүүлэх шаардлагагүй, зөрчилтэй 100 байгууллагын мэдээллийг шинэчлүүлэхээр холбогдох байгууллага болон Улсын бүртгэлийн хэлтэст хүргүүлж 2022 оны жилийн эцсийн 35 байгууллага зөрчлийг арилгасан байна. 3. “Гүүр софт” ХХК-ний гаргасан хөрөнгийн бүртгэлийн программыг ашиглан Баянхонгор аймгийн ЗДТГ, Аймгийн ИТХ, Санхүүгийн хяналт аудитын алба, Орон нутгийн өмчийн газрын үндсэн хөрөнгүүдийг QR коджуулан хөрөнгө тус бүрийг нэг бүрчлэн зургаар баталгаажуулан ажилласан. 4. Аймгийн Засаг даргын 2022 оны А/221 дугаар | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | захирамжаар байгуулагдсан нэгдсэн шалгалтаар Бууцагаан, Баян-Овоо, Шинэжинст, Баян-Өндөр сумдад хөрөнгийн өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалттай танилцаж хяналтын тооллого хийж, зөрчил дутагдлыг арилгуулахаар зөвлөмж өгч, актлах, худалдах, ашиглалтгүй хөрөнгийг судалгааг гарган холбогдох тогтоол шийдвэрийг гаргуулан ажиллалаа. | |
| 107 | 3.2.1. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхижүүлж оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана. | 1. Олон улсын байгууллагуудтай хамтран ажиллаж, төсөл хөтөлбөр хамтран хэрэгжүүлэх санал хүргүүлэх, уулзалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 1 | Олон улсын төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд: Аймгийн хэмжээнд Щвейцарийн хөгжлийн агентлагийн санхүүжилтээр Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь төсөл, НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр “Утаагүй Баянхонгор” төсөл, НҮБ-ын Хүүхдийн сан, БНСУ-ын “Орон нутгийн иргэдэд түшиглэсэн уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй ус хангамж, ариун цэвэр, эрүүл ахуйн үйлчилгээ” төсөл, Франц улсын санхүүжилтээр Тогтвортой ноолуур төсөл, Европын Холбооны санхүүжилтээр Бүгд Залуусын төлөө, Залуус бүгдийн төлөө, Best хөтөлбөр, Дэлхийн банкны санхүүжилтээр Тогтвортой Амьжиргаа-3 төсөл, Монголын Улаан Загалмайн нийгэмлэг, НҮБ-ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр “Хүүхэд эсэн мэнд амьдрахуй” төсөл, Монгол улс дахь Австралийн Элчин сайдын яамтай хамтран “Малчдын эрүүл мэндийг хамгаалах, тэдгээрийн аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх ”төслүүдийг тус тус амжилттай хэрэгжүүлсэн. Гадаад харилцааг идэвхижүүлэх ажлын хүрээнд: COVID-19 -ийн цар тахал намжсанаар 2022 оны 6 дугаар сараас аймгийн гадаад харилцаа, хамтын ажиллагааг идэвхижүүлэх шат дараатай арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэн, дараах үр дүнд хүрэв. Үүнд: 1. Монгол улс дахь АНУ-ын Элчин сайдын яам, Онцгой байдлын Ерөнхий Газар, АНУ-ын Номхон далайн цэргийн командлалтай хамтран Гамшигийн эрсдлээс урьдчилан сэргийлэх “Говийн чоно-2022” арга хэмжээг зохион байгуулав. Үүний үр дүнд аймгийн онцгой комиссын чиглэлийн албан хаагчид тухайлбал эмч эрүүл мэндийн салбарын албан хаагчид гамшгийн үед авах хариу арга хэмжээний цогц чадамжийг эзэмшсэн байна. 2. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Альшаа аймагтай тогтоосон харилцаа, хамтын ажиллагааг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | идэвхжүүлэн тус аймгийн Баруун хошуун дахь Ингэний сүүний үйлдвэрт 40 гаруй албан хаагчид, ингэний ферм эрхлэх малчдын төлөөллүүд туршлага судлан танилцсан. 3. ОХУ-ын орос хэлний хоёр багшийг Өлзийт, Гурванбулаг сумдад 2022-2023 оны хичээлийн жилд ажиллуулсан. | |
| 108 | 3.3.1. Орон нутагт уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдтэй байгуулах гэрээнд төр, иргэдийн оролцоог хангаж ажиллана. | 1. Ашиглалтын үйл ажиллагаа явуулж буй ААН-үүдийн гэрээний хэрэгжилтийг хангуулах | 2021 - 2024 | | 70 | Уул уурхай бүхий 6 сумын давхардсан тоогоор 27 ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжтэй “Байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, үйлдвэр байгуулахтай холбогдсон дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх” тухай 12,7 тэрбум төгрөгийн гэрээг байгуулсан. Гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч аж ахуйн нэгжүүдээс төвлөрөх хөрөнгө оруулалтын гүйцэтгэл 75 хувийн биелэлттэй ба хамтран хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 38 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжүүлсэн. | |
| 109 | 3.3.2. "Хариуцлагатай уул уурхай-Эдийн засгийн үндэс" сургалтыг уул уурхай бүхий сумдын иргэдэд зохион байгуулна. | 1. Уул уурхай бүхий сумдын иргэдэд сургалт зохион байгуулах | 2021 - 2024 | | 8 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай уул уурхай-2022" зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн төлөөлөл 120 гаруй хүн оролцсон. Зөвлөгөөний үеэр орон нутаг дахь бичил уурхай эрхлэгчдийн төлөөлөл хууль, журмын талаарх мэдлэгээ нэмэгдүүлж, тулгамдаж буй асуудлуудаар хэлэлцүүлэг зохион байгуулсан. Зөвлөгөөнөөс гарсан саналыг Монгол Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайд нарт албан бичиг хүргүүлсэн. Мөн Аймгийн Засаг дарга болон мэргэжлийн байгууллагууд 2022 оны 09 дүгээр сарын 03-04-ний өдрүүдэд Шинэжинст, Баян-Өндөр сумын 125 иргэнд сургалт, хэлэлцүүлгийг зохион байгуулсан. Сургалтын үр дүнд төрийн байгууллага иргэдийн хамтарсан ажлын хэсэг гарч ажиллахаар шийдвэрлэгдэж төрийн байгууллага иргэдийн уялдаа | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | холбоо сайжирсан. | |
| 110 | 3.3.3. “Баялагийн сан” байгуулж, олон нийтийн хяналтан дор байгаль хамгаалах, нөхөн сэргээх, нийгмийн шинжтэй төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлнэ. | 1. Баялагын сан байгуулж, төсөл хөтөлбөрийг иргэдийн оролцоотойгооор хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 20 | "Баянхонгор сан"-г байгуулж, сан бүрдүүлэх захиран зарцуулах, түүнд хяналт тавих журмыг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын хуралдааны 2022 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн 8/07 дугаар тогтоолоор баталсан. Тус журмыг Хууль зүй, дотоод хэргийн яамруу хүргүүлсэн боловч журмыг шинэчлэн дахин батлуулах чиглэл ирсэн. | |
| 111 | 3.3.4. Хариуцлагатай уул уурхайг хөгжүүлж, хууль, тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бичил уурхай эрхлэгчдийг дэмжиж ажиллана. | 1. Бичил уурхайгаар ашигт малтмал олборлогч нөхөрлөл, хоршоо болон иргэдэд хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх чиглэлээр нөлөөллийн ажил зохион байгуулах. | 2021 - 2024 | | 25 | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам, Ашигт малтмал, газрын тосны газар, Аймгийн Засаг даргын Тамгын газар хамтран эрдэс баялгийн салбарын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад төр, хувийн хэвшил, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх зорилгоор "Хариуцлагатай уул уурхай-2022" зөвлөгөөнийг 2022 оны 04 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулсан. Зөвлөгөөнд Баянхонгор аймгийн бичил уурхай эрхлэгчид оролцож бичил уурхайн талаарх журмын зөрүүтэй ойлголтуудыг засаж нэгдсэн ойлголтод хүрсэн. Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газар, Байгаль орчин, аялал жуулчлалын газар хамтран Хөгжлийн ертөнц ТВ-10 телевизээр Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 2 удаагийн нэвтрүүлэг бэлтгэж иргэдэд мэдээлэл хүргэсэн. Мөн хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх 2 төрлийн 500 ширхэг гарын авлагыг иргэдэд тарааж мэдээлэл хүргэсэн. | |
| 112 | | 2. Бичил уурхай эрхлэгчдийг хууль | 2021 - | | 2 | Мэргэжлийн хяналтын газар, Цагдаагийн газрын Экологийн цагдаагийн албатай хамтран хууль бус ашигт малтмал олборлогч | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоомжийн дагуу үйл ажиллагаа явуулах нөхцлийг бүрдүүлж, хяналт тавих | 2023 | | | иргэн, нөхөрлөл аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд төрийн хяналт, шалгалтыг 3 удаа зохион байгуулсан, Экологийн цагдаагийн албанаас 26 удаа эргүүл, шалгалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Хяналт, шалгалтын явцад Засгийн газрын 2022 оны 296 дугаар тогтоолоор шинэчлэгдэн батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын нөхцөл шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй, газрын хэвлийг дур мэдэн ашигласан 55 иргэн, 15 нөхөрлөлд Зөрчлийн тухай хуулийн дагуу арга хэмжээ авсан. | |
| 113 | 3.3.5. Эвдэрсэн газрын тооллого судалгаан дээр үндэслэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана. | 1. Аймгийн хэмжээний эвдэрсэн газрын тооллого, судалгаанд үндэслэн төлөвлөгөөний хэрэгжилтийг хангуулах | 2021 - 2024 | | 15 | Баянхонгор аймгийн хэмжээнд нийт 13 сумын нутаг дэвсгэрийг хамарсан 21 багийн 120 нэгж талбарт 586,74 га талбай эвдрэлд ороод байна. Үүнээс уул уурхайн ашиглалтын үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдийн дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд 2021 онд 102,4 га, 2022 онд 77.87 га талбай нийт 180,27 га талбай буюу 30,7 хувьд нь  техникийн нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. | |
| 114 | 3.4.1. Хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн цогцолборыг бий болгоно. | 1. Хөдөө аж ахуйн кластерийн хүрээнд шаардлагатай төслүүдийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулах | 2021 - 2024 | | 70 | Хөдөө аж ахуйн цогцолбор байгуулах төслийг 2021-2024 он хүртэл хэрэгжүүлэхээр дараах төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлж, үйлдвэрлэлийг байгуулахаар ажиллаж байна. 1. Ингэний сүүгээр нэмүү өртөг шингэсэн, гадаад зах зээлд худалдан борлуулах үйлдвэр байгуулах төслийг хэрэгжүүлэн үйлдвэрийн барилгын ажлыг 2021 онд тендер сонгон шалгаруулалт зарлан “Базар дарь” ХХК шалгаран барьж 2022 онд үйлдвэрийн барилгыг хүлээлгэн өгсөн. Цаашид тус үйлдвэрийн үйл ажиллагааг "Ингэн Эрдэнэ" ОНӨААТҮГазар хариуцан ажиллах юм. Тус төслийн нийт төсөв 3,8 тэрбум юм. 2. Мах ногооны зоорь, бойны газар барих төслийн нийт төсөвт өртөг 3 тэрбум төгрөг бөгөөд тендер сонгон шалгаруулалтыг зохион байгуулж "Сант-Өндөр" ХХК шалгарч барилгын ажлыг эхлүүлж, 2021 онд 250 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. 2022 онд санхүүжилт олгогдоогүй. Тус мах, ногооны зоорь 2024 онд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ашиглалтад орно. 3. Хөдөө аж ахуйн цогцолборын үйлдвэрлэлийн бүсийн цэвэрлэх байгууламжийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалтын ажилд "Алтай эколос" ХХК, цахилгааны эх үүсвэрийн материал нийлүүлэх ажилд "Эн ди эм эм" ХХК, гадна холбооны шугамын материал нийлүүлэх ажилд "Нью Бест хаус" ХХК тус тус шалгарч дээрх ажлыг бүрэн дуусган хүлээлгэн өгсөн. Энэ онд 850 сая төгрөгийн санхүүжилтийг олгосон. | |
| 115 | 3.4.2. Хоршоог хөгжүүлэх нийгмийн хэмжээний хөтөлбөрийг орон нутагт үр дүнтэй хэрэгжүүлнэ. | 1. Хөдөө аж ахуйн загвар хоршоо байгуулах | 2022 - 2024 | | 1 | Засгийн газраас 2022 оныг "Хоршооны хөгжлийг дэмжих жил" болгон зарлаж, Аймгийн хоршоологчдын бага хурлыг хийж хоршооны талаар төрөөс баримтлах бодлого, хууль эрх зүйн орчны өөрчлөлт, хоршоог дэмжих сангийн талаар сургалт, мэдээллийг ХХААХҮЯ, Монголын ХАА хоршоологчдын холбоотой хамтран зохион байгуулсан.  Түүхий эд бэлтгэн нийлүүлэх чиглэлээр Тогтвортой ноолуур Баян-өндөр, Баянцагаан сумын 2 хоршоодтой гэрээ байгуулан 9.6 сая төгрөгийн цалин, бусад дэмжлэг үзүүлэн хамтран ажиллаж, гэрээ байгуулан түүхий эдийг гадаад зах зээлд нийлүүлж байна. Тогтвортой ноолуур төсөл хэрэгжиж буй 7 сумын 670 өрхөөс 15 тн ноолуурыг стандартын дагуу бэлтгэн 2-тн боловсруулсан ноолуурыг гадаадын зах зээлд нэмүү өртөг шингээн борлуулж  байна "BODIO'S" группийн хөрөнгө оруулалтаар 4 сумын 523 өрхийг "Цагаан ямаат Баянговь" нэртэй хоршооны зохион байгуулалтад малчдын амьжиргааг дэмжих, байгаль орчин экологийн асуудлыг тэнцвэржүүлэх, байгаль хамгаалалд малчид биечлэн оролцох, ноолуурын чанарыг сайжруулах, 16.4 мкм-ээс доогуур байлгах үндсэн 4 зорилтын хүрээнд үйл ажиллагаагаа өргөжүүлэн ажиллаж байна. Тус хоршоо 30 тн түүхий ноолуурыг малчдын гар дээрээс стандартын дагуу бэлтгэн, 10 тонн ноолуурт үйлдвэрийн боловсруулалт хийж гадаадын зах зээлд нийлүүлэн нэмүү өртөг шингээн борлуулсан.  Хоршоодын хөгжлийн үнэлгээ хийх сургалтад хоршооны төлөөлөл 42 хүнийг хамруулж, мэдээллийн баазыг шинэчлэн, нэгдсэн тоо мэдээлэлтэй болж, хоршооны хөгжлийн үнэлгээг 20 сумын 207 хоршоонд хийсэн. Аймгийн хэмжээнд хоршоодоор дамжуулан түүхий эд бэлтгэн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийлүүлэх итгэмжлэлийг 15 сумын 14 хоршоо, 2 иргэн, 2 ХХК авч биржийн арилжаанд шууд оролцох боломж бүрдсэн. Хоршоо хөгжүүлэх сангаас 14 сум 56 хоршоо, иргэдэд нийт 1.9 тэрбум төгрөгийн дэмжлэг үзүүлж ажилласан. | |
| 116 | 3.5.1. “Бизнес инкубатор”-ийн бодлогыг эрчимжүүлж, гарааны бизнесийг дэмжиж бойжуулна. | 1. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан, Жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих сангаас гарааны бизнес эрхлэгчдийг дэмжиж, бойжуулах | 2022 - 2024 | | 30 | Жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 500.0 сая төгрөгийн эх үүсвэр батлагдсан. Хөнгөлөлттэй зээл олгох журмын дагуу 6 аж ахуй нэгжийн 481,202,550 төгрөг хүссэн төслийг нарийвчилсан шатруу шилжүүлж, ЖДҮХСангийн ажлын хэсэгт шалгуулсан. Энэ онд үйлдвэр үйлчилгээний "Ажилсаг төв"-өөр дамжуулан нийт 522.5 сая төгрөгийн зээлийн 39 иргэн аж ахуй нэгжид олгосон байгаа бөгөөд хуучин 95 ажлын байр хадгалагдаж, шинээр 43 ажлыг бий болгоод байна.  -Жижиг, дунд үйлдвэрийг дэмжих сангийн хөнгөлөлттэй зээлд 4 ХХК -ний 291.8 сая төгрөгийн төсөл шалгарч, санхүүжилт авсан. Үүнд:1.Даян дуулим ХХК чацаргана боловсруулах, 2.Тэнгэрийн тэргүүн шим ХХК хүнс, ногооны зоорь, 3.Танан хишиг ХХК хүнс, ногооны зоорь, 4.Нова дент ХХК хүлэмж, хүнсний ногооны төсөлд хөнгөлөлттэй зээл олгогдсон. Бичил үйлдвэр, үйлчилгээ нэмэгдэж, шинээр 22 ажлын байр бий болно. Мөн орон нутгийн төсвөөс гарааны бизнес эрхлэгчдийг дэмжих зорилгоор 10 иргэнд тус бүр 5.0 сая, нийт 50.0 сая төгрөгийн хөнгөлөлттэй зээлийг 3 жилийн хугацаатай, хүүгүй нөхцөлөөр олгоод байна. Хөнгөлөлттэй зээл олгосноор 20 шинэ ажлын байр гарсан. Орон нутгийн Төсвөөс 522.5 сая төгрөг, жижиг дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангаас 291.8 сая төгрөг Нийт -864.3 сая төгрөг Орон нутгийн төсөв болон ЖДҮДСангаас 864.3 сая төгрөгийн Хөнгөлөлттэй зээлүүд олгогдсоноор орон нутагт 9 бичил үйлдвэр, 39 үйлдвэр, үйлчилгээ нэмэгдэж, шинээр 65 ажлын байр бий болсон байна | |
| 117 | 3.5.2. Хүн амын хүнсний хэрэгцээний нөөцийн махыг | 1. Махны нөөцийг бүрдүүлж,  үнийг тогтворжуулах | 2021 - 2024 | | 200 | 2021 оны хаврын улиралд хүн амын махны хэрэгцээг хангах гэрээг байгуулж 350тн махыг зах зээлд хөнгөлөлттэй үнээр хүнсний дэлгүүр болон зоориноос худалдан борлуулсан. Худалдан борлуулах үеэр Мал эмнэлгийн газар, Мэргэжлийн хяналтын газар, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хувийн хэвшлүүдээр бэлдүүлж дэмжлэг олгоно. | | | | | Хүнс, хөдөө аж ахуйн газруудтай хамтран хяналт тавьж ажилласан. Тус үйлдвэрт урамшуулал болгож 75.0 сая төгрөгийн дэмжлэгийг орон нутгийн төсвөөс олгосон. Хүн амын махны нөөц бүрдүүлэх ажлын хүрээнд нээлттэй төсөл сонгон шалгаруулж орон нутгийн "Баянхонгор констракшн" ХХК-ны Мах март махны үйлдвэртэй 160тн, "Баянжаргант хүнс" ХХК-тай 40тн мах нийлүүлэх гэрээ байгуулсан. Тус аж ахуй нэгжүүд Баянхонгор хотын 13 дэлгүүр, цэгээр жижиглэн болон гулууз махыг иргэдэд хөнгөлөлттэй үнээр худалдаалсан. Явцын хяналтыг Мэргэжлийн хяналтын газар, Хүнс, хөдөө аж ахуйн газар, Мал эмнэлгийн газар удирдамжийн дагуу хийсэн. Нөөцийн махны үнийн хувьд ямаа /1кг/ 7000, хонь /1кг/ 8000, үхэр /1кг/ 10000 төгрөгөөр тус тус худалдаалж үнийн хөөргөдөл үүсгэхгүй нөхцөлийг хангаж ажиллаж, зах зээлийн үнээс 1000-1500 төгрөгийн доогуур ханштайгаар 2022 оны 04 дүгээр сарын 10-аас 06 дугаар сарын сарын 10 хүртэл худалдаалсан. Гэрээний гүйцэтгэлээр нийт санхүүжилт 100.0 сая төгрөгийг “Баянхонгор констракшн" ХХК, "Баянжаргант хүнс" ХХК-д тус тус олгосон. | |
| 118 | 3.6.1. Мал сүргийн шилэн сонголтын ажлыг сайжруулж, малын ашиг шимийн түвшинг нэмэгдүүлж, малчдын мэдлэгийг дээшлүүлнэ. | 1. Малын шилэн сонголтын ажлыг үе шаттайгаар зохион байгуулж орон нутгийн онцлогт тохирсон үүлдэр, омгийн малыг сайжруулагчаар ашиглан ашиг шимийг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 70 | Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад байлгах зорилгоор 20 сумын бог малын 10.6 мянган хээлтүүлэгчийг 86 суурьт ялган төвлөрүүлсэн.Бог малын хээлтүүлэгчийг хавар намрын үзлэг ангилалтад 20 сумын 14.1 мянган малыг хамруулсан. Ангилалтаар амьдын жингийн үзүүлэлт аймгийн дунджаар өсвөр хуц 33 кг, бүдүүн хуц 55 кг, өсвөр ухна 22 кг, бүдүүн ухна 41 кг амьдын жинтэй байгаа нь тухайн төрлийн малын амьдын жингийн стандартыг хангаж байна. Эрдэнэцогт сум ОНХС-ын хөрөнгөөр 648 сарлагт үзлэг ангилалт хийсэн. Баталгаажсан үүлдэр омгийн цөм сүргийн малын тоо 86.8 мянган толгой байна. Засгийн газрын 2022 оны 92 дугаар тогтоолоор төрөл бүрийн үүлдэр, омгийн малыг үржүүлэх бүс байршлыг тогтоох журмыг батлан Хүнс, хөдөө аж ахуй хөнгөн үйлдвэрийн сайдын А/144 дугаар тогтоолоор бүс нутагт үржүүлэх үүлдэр, омгийн малын байршлыг тогтоосон. Манай аймаг хонин сүргийг Баянбулаг | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хониор, ямаан сүргийг Бөмбөгөрийн улаан омог, Залаажинст-Эдрэн үүлдрээр сайжруулах, Тэмээн сүргийг Ламын гэгээний улаан тэмээ үржлийн хэсгээр, адуу, үхрийг өөр дотор нь сонгон үржүүлэх бодлого барьж ажиллаж байна. Сүргийн бүтцэд хонин сүргийн эзлэх хувийг нэмэгдүүлэх, бэлчээрийн даацыг сайжруулах, сүргийн чанар, ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор Увс аймгийн Баяд үүлдрийн хонийг цэврээр нь үржүүлэх Цөм сүргийн нэгжийг Баянцагаан сумын Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авсан. AVSF төсөл хэрэгжиж буй 7 сумын 7 хоршоонд малын чанар сайжруулах чиглэлээр Залаа жинст-Эдрэн үүлдэр, Бөмбөгөрийн улаан омгийн 200 эм ямаа, 20 ухныг 45,0 сая төгрөгийн буцалтгүй хөрөнгө оруулалтаар нийлүүлж, сүргийн бүтцийг сайжруулсан. Бог малын хээлтүүлэгчийг хавар, намрын үзлэг ангилалтад 20 сумын 14.1 мянган малыг хамруулсан. Орон нутгийн төсвөөс Баяд үүлдрийн 100 толгой 2-3 настай эм хонь худалдан авч, төсөл хөтөлбөрөөс 200 эм ямаа, 20 ухныг 45,0 сая төгрөгийн буцалтгүй хөрөнгө оруулалтаар нийлүүлсэн | |
| 119 | | 2. Бог малын хээлтүүлэгчийг мэргэжилтэн, мэргэжлийн байгууллагын хяналтад ялган төвлөрүүлэх | 2021 - 2024 | | 70 | Бог малын хээлтүүлэгчийг мэргэжлийн байгууллага, мэргэжилтний хяналтад байлгах зорилгоор 20 сумын бог малын ухна 9071, хуц 5899 нийт 14.9 мянган хээлтүүлэгчийг 88 суурьт ялган төвлөрүүлж, гэрээ байгуулан ажилласан. Нийт хээлтүүлэгчийн 90 хувийг ялган төвлөрүүлсэн | |
| 120 | | 3. Малчдын мэдлэг, мэдээллийг нэмэгдүүлж, сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах | 2022 - 2024 | | 100 | Сумын Засаг даргын тамгын газар, Хөдөө аж ахуйн тасгаар дамжуулан 20 сумын давхардсан тоогоор 5858 малчинд салбарын болон цаг үеийн мэдээлэл сургалт хүргэж, нөлөөллийн арга хэмжээ зохион байгуулсан. Мөн 9,10,11,12 дугаар ангийн 890 гаруй сурагчдад малын эмч мэргэжил болон зорилгодоо хэрхэн хүрэх, талаар сургалтыг амжилттай зохион байгуулсан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 121 | | 1. Малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дархлаажуулалт, угаалга туулгалтад мал сүргийг хамруулах | 2021 - 2024 | | 2 | Орон нутагт зонхилон гардаг мал, амьтны халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 1,9 сая толгой малыг хамруулахаар төлөвлөж төлөвлөгөөг 100 хувь биелүүлсэн. Мөн Шүлхий өвчнөөс урьдчилан сэргийлэх Хаврын масс дархлаажуулалтад нийт 229,2 мянган толгой мал, амьтныг хамруулсан. Дээрх арга хэмжээг үр дүнтэй зохион байгуулснаар мал, амьтны гоц халдварт өвчингүй, ногоон бүс болсон. Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 20 сумын 3,5 сая толгой малыг хамруулахаас 89,4% гүйцэтгэлтэй биелүүллээ. | |
| 122 | 3.6.2. Мал эмнэлгийн чанар хүртээмжийг сайжруулж, эрүүл бүс статусаа бататгана. | 2. Мал эмнэлгийн бүртгэл мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулж, мал болон малын гаралтай бүтээгдэхүүнд хяналт тавих | 2021 - 2024 | | 7000 | Мал эмнэлгийн нэгдсэн системд малчид, мал бүхий иргэдийн хүсэлтээр нийт 8405 гарал үүслийн гэрчилгээ баталгаажуулж иргэн, хуулийн этгээдэд олгож ажилласан. Уг системээр дамжуулан мал, малын гаралтай бүтээгдэхүүний тээвэрлэлт, шилжилт хөдөлгөөн, отор нүүдэл болон малын гаралтай хүнсний бүтээгдэхүүнд хяналт тавьж ажиллаж байна. | |
| 123 | | 3. Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор шаардлагатай эм, бэлдмэл, хувцас хэрэгслийн нөөцийг бүрдүүлэх | 2021 - 2024 | | 15 | Гамшгийн эрсдэлээс хамгаалах зорилгоор аймгийн Онцгой комиссоос ариутгалын бодис 1,0 тн, Халдвар хамгаалалтын хувцас 1000ш, амны хаалт 5000ш, бээлий 100ш, Нүдний шил 1000ш, Улавч 1000 ширхгийг тус тус олгож нөөц бүрдүүлсэн ба Мал эмнэлгийн тандалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зориулалтын дагуу ашигласан | |
| 124 | 3.6.3. Бэлчээр менежментийг сайжруулах | 1. Худаг уст цэг гаргах, шаардлагатай | 2021 - 2024 | | 5 | Улсын төсвийн хөрөнгөөр Өлзийт сумд 1 худаг, аймгийн орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилтээр (Хүрээмарал, Бууцагаан, Бөмбөгөр, Жинст, Эрдэнэцогт) 5 сумд 5 худаг, гадаадын төсөл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зорилгоор шаардлагатай цэгүүдэд уст цэг шинээр гаргах, бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх ажлыг зохион байгуулна. | цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх | | | | хөтөлбөрөөр Шинэжинст сумд 3 худаг, сумдын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр (Баацагаан, Баянговь, Баянлиг, Баян-Өндөр, Баянцагаан, Бөмбөгөр сумд) 19 худаг, малчид өөрсдийн санаачилга, хөрөнгөөр (Бөмбөгөр, Гурванбулаг, Хүрээмарал, Шинэжинст сумд) 6 худаг нийт 34 худаг шинээр гаргаж, засварласан байна. Бэлчээрийн 34.0 мянган га талбайг усжуулсан. Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр уст цэгийн хайгуулыг Баян-Өндөр, Шинэжинст сумд 17 цэгт хийсэн. Худаг уст цэгийн чанар, гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан. | |
| 125 | | 2. Аймгийн хэмжээнд дэвшилтэт аргаар бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх | 2021 - 2024 | | 20 | Микробиологийн аргаар үлийн цагаан оготнотой тэмцэх ажлыг Баянбулаг сум 3000, Жаргалант сум 4000, нийт 7000 га талбайд хийж гүйцэтгэсэн. Аймгийн 20 сумын хэмжээнд татвараас орох орлогоос 16.0 сая төгрөгийг бэлчээрийн хортон мэрэгчтэй тэмцэх арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөсөн байна. “Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэн”-ээр “Бэлчээрийн хөнөөлт үлийн цагаан оготны тархалт, нягтрал, хөнөөлийг тодотгох” судалгааг хийлгэхэд 11 сумын 65,0 мянган га-д тархсан гэсэн дүгнэлт гарсан. | |
| 126 | 3.6.4. Аймаг, сумдын аюулгүй нөөцийн өвс тэжээлийг зохих түвшинд бэлтгэнэ. | 1. Аюулгүйн нөөцийн өвс, тэжээлийг зохих түвшинд бэлтгэх | 2021 - 2024 | | 200 , 50 | Монгол Улсын Засгийн газрын 2022 оны 277 дугаар тогтоолоор 20 сумын хэмжээнд 1200 тн өвс, 700 тн тэжээл бэлтгэхээс 1063 тн өвс, 401,9 тн тэжээл бэлтгэн 73%-тай хангасан бол аймгийн аюулгүйн нөөцөд 200 тн өвс, 100 тн тэжээл бэлтгэхээс 175 тн өвс, 54 тн хорголжин, улаан хивэг бэлтгэн 70,7 хувиар хангасан байна. Аймгийн аюулгүйн нөөцийг бүрэн хангах зорилгоор орон нутгийн хөгжлийн сангийн 100,0 сая төгрөгийн хөрөнгөөр 6000 боодол ногоон тэжээл, 1667 уут улаан хивэг (25 кг савлагаатай) авч нөөцийг нэмэгдүүлсэн. | |
| 127 | 3.6.5. Техник, тоног төхөөрөмжийг нэмэгдүүлэн | 1. Стандартын шаардлага хангасан 1000тн-ы төмс, хүнсний | 2021 - 2023 | | 100 | Аймгийн хэмжээнд газар тариаланд ашиглагдаж буй техникийн судалгааг шинэчлэн хийсэн бөгөөд тус судалгааны дүнгээр аймгийн хэмжээгээр зүтгэх хүчний трактор 16, Хөдөө аж ахуйн чиргүүл дүүжин машин 38 байгаагаас 85.3 хувь нь 10-аас дээш жилийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлж, хүн амын төмс, хүнсний ногооны хангамжийг өсгөнө. | ногоо, махны зоорьтой болох | | | | насжилттай хуучирч муудсан байна.Хүнс хөдөө аж ахуйн газар, Баянхонгор Политехникийн коллеж, Өлзийт ХААМСҮТ-ийн болон хувийн хэвшлийн техникүүд тариаланчдад түрээсээр үйлчлэхэд зуучлан холбож өгснөөр хаврын тариалалт, хөрс боловсруулалт, хагалгаа, төмс үрслэгээний ажлыг 100%, хүнсний ногооны тариалалтын 40 хувийг механикаар гүйцэтгэсэн байна. Энэ онд шинээр 2 трактор 5 чиргүүл дүүжин машиныг иргэн аж ахуйн нэгж байгууллагууд өөрийн хөрөнгөөр авч ашиглаж байна. Ногоон шим төслийн хүрээнд баригдаж буй зоорины барилгын ажил дууссан ба доторх хөргүүрийн ажил хийгдэж 70 хувьтай байна. | |
| 128 | | 2. Тариалалтад ашиглах техник, тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх, дундын үйлчилгээний нэгж байгуулах | 2022 - 2024 | | 70 | Тариалалтад ашиглах техник тоног төхөөрөмжийн хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор Баянхонгор Политехникийн коллежийн 1, ХХААГ-ын 1, Сум дундын ойн ангийн 2, Өлзийт ХААМСҮТ-ийн 1 нийт 5 трактор тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулах боломжийг хангаж хамтран ажилласнаар 23 иргэн, аж ахуй нэгжийн нийт 130 га талбайд хөрс боловсруулалтын ажлыг хөнгөлөлттэй үнээр хийж дэмжлэг үзүүлсэн байна. Цаашид зээл тусламжаар авсан трактор тоног төхөөрөмжүүдийг нэгтгэн техник дундын үйлчилгээний нэгжийг байгуулах зорилго тавьж байна. Мөн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Ногоон шим" төслийг хариуцан зохион байгуулж буй "Баян-Өсөх-Агро" ОНӨААТҮГ-ын трактор тоног төхөөрөмжийг түрээсээр ашиглуулах Дундын үйлчилгээний нэгж байгуулагдан боломж бүрдэнэ. Төслийн 2022 оны төлөвлөгөө 100 хувь хэрэгжсэн. | |
| 129 | | 3. Хүнсний нарийн ногооны хангамжийг нэмэгдүүлэх зорилгоор өвөл, зуны хүлэмжийн парк аж ахуй бий | 2021 - 2024 | | 25 , 0 | Тариалангийн эргэлтийн талбайн ашиглалтыг сайжруулж, тариалангийн бүс нутгийг тогтоох, усалгаатай тариалангийн талбайг нэмэгдүүлэх, голлох нэр төрлийн хүнсний ногоо, чацаргана, жимс жимсгэнийн нутагших чадвартай үр, сортыг бодлогоор хөгжүүлж дотоодын болон бүсийн хэрэгцээг хангах зорилгоор Баян-Овоо сумын “Даян дуулим” ХХК-тай хамтран ажиллаж 23.0 мянган чацарганын суулгацыг нэмж тариалах ажлыг хэрэгжүүлсэн. Тус ХХК нь ЖДҮ-ийг дэмжих зээлд хамрагдаж үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | болгох | | | | ажиллагаагаа өргөжүүлж байна. Мөн өвөл зуны хүлэмж, зоорь агуулахыг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд Хүлэмж нийлүүлэх үйл ажиллагааг нэгдсэн зохион байгуулалтаар хангаж манай газартай “Алтан сапа” ХХК-тай гэрээ байгуулан аймгийн төвд 2 өдрийн хугацаанд хүлэмжийн худалдааг зохион байгуулснаар 37.5 сая төгрөгийн үнэ бүхий 27 хүлэмжийг иргэд өөрсдийн хөрөнгөөр худалдан авч компанийн зүгээс 3.5 сая төгрөгийн үнэ бүхий 27 ширхэг услалтын системийг үнэ төлбөргүйгээр иргэдэд өгсөн. Мөн ЖДҮХ сангаас Баянхонгор сумд өвлийн хүлэмжийн аж ахуй байгуулах 2 төсөлд, ОНТөсвийн санхүүжилтээр 3 иргэнд хүлэмжийн аж ахуйн төсөл, Хоршоог хөгжүүлэх сангийн 87.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 300 м2-ийн 2 өвлийн хүлэмж байгуулах төслийг тус тус олгож дэмжлэг үзүүлсэн. Аймгийн хэмжээнд тайлант онд 612 м2 талбай бүхий 3 өвлийн хүлэмж, 9536.2 м2 талбай бүхий нийлэг хальсан 152 хүлэмж үйл ажиллагаа явуулж 78.1 тн ургац хураан авсан байна. | |
| 130 | 3.7.1. Гадаад, дотоодын аялал жуулчлалыг хөгжүүлнэ. | 1. Эвент арга хэмжээнүүдийг зохион байгуулах | 2021 - 2024 | | 5 , 6000 | Дотоодын аялал жуулчлалын "Улаанбаатар Трэвел Экспо" үзэсгэлэнд 2022 оны 05 дугаар сарын 27-29-ний өдрүүдэд, аялал жуулчлалын Олон Улсын арга хэмжээ болох "Ай Ти Эм-2022" үзэсгэлэнд 2022 оны 10 дугаар сарын 28-30-ны өдрүүдэд тус тус оролцож аймаг, орон нутгаа жуулчдад сурталчилж ажилласан. Аялал жуулчлалын эвент арга хэмжээнд оролцсон. Мөн Дэлхийн аялал жуулчлалын өдрийг угтан Монголчуудын дунд түгээн дэлгэрсэн соёлын биет бус өв соёл болох “Дэмбээ наадгай-2022” арга хэмжээг “Дэмбээ мэдэх үү хө” амралтын газарт зохион байгуулсан. Тус арга хэмжээний үеэр аймгийн дэмбээний аварга шалгаруулах тэмцээнийг зохион байгуулж 30 гаруй дэмбээчид оролцсон. Энэ онд аймагт 46228 дотоодын аялагч, 1271 гадаадын аялагч хүрэлцэн ирсэн нь өмнө оноос 3 дахин өссөн дүнтэй байна | |
| 131 | | 2. Аялал жуулчлалын видео контент нэвтрүүлэг | 2021 - 2023 | | 15 , 150000 | “Үзэсгэлэнт Баянхонгор-2 төслийн хүрээнд аймгийн түүх соёлын дурсгал, байгалийн үзэсгэлэнт газар, ахуй амьдрал, нийгэм эдийн засаг, спорт, боловсрол, урлаг соёл, ан амьтдыг илэрхийлсэн 24 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бэлтгэх | | | | видео контент бэлтгэн олон нийтэд хүргэсэн. Мөн аялал жуулчлалын нөөц газрын гэрэл зургийн мэдээллийн сан үүсгэн Баянхонгор аймгийн түүхт 80 жилийн ойн хүрээнд цаг тооны бичиг, Бөмбөгөр сумын цаг тооны бичиг, ширээний календарь тус бүр 500 ш хийж, нийт 1500 ширхгийг иргэдэд тарааж сурталчилгааны ажлыг зохион байгуулсан. | |
| 132 | | 3. Төрийн болон орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын тохижилтийг үе шаттайгаар хийж гүйцэтгэх | 2021 - 2024 | | 1 | Тус аймгийн аялал жуулчлалын нөөц газар болох Цагаан агуй, Бичигт хад, Өргөөтийн рашааны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Их Богдын Байгалийн цогцолборт газрын Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрхныг түшиглэн аялал жуулчлалын отоглох цэг байгуулсан. Нийт 4 газрын тохижилт хийгдснээр дотоод, гадаадын жуулчдын амрах, аялах тав тухтай орчныг бүрдүүлсэн төдийгүй байгаль орчныг хамгаалж, бүс нутгийн эдийн засаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн. | |
| 133 | 3.8.1. Аймгийн төв доторх шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам, явган зам, унадаг дугуйн зам барих, нөхөх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол, тэмдэг тэмдэглэгээ хийж автозамын аюулгүй байдлыг хангана. | 1. Шаардлагатай газруудад хатуу хучилттай авто зам шинээр барих, нөхөөс хийх, нийтийн эзэмшлийн зам талбайд зогсоол хийх | 2021 - 2023 | | 0.2, 1000м, 2 | 2021 онд Аймгийн замын сангийн 46,0 сая төгрөгийн хөрөнгөөр 880 м2 хатуу хучилттай автозамын нөхөөс хийх тендерт “Их богд зам“ ХХК шалгарч, ажлыг гүйцэтгэн ашиглалтад бүрэн оруулсан. Эрдэнэцогт- Баянхонгор чиглэлийн 1,7км хатуу хучилттай авто замын барилгын ажлыг “Дээд мөнх булаг зам” ХХК гүйцэтгэсэн. Замын сангийн 514,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Есөн эрдэнэ” захын баруун талаас Хонгор хотхоны ар тал хүртэлх 1.2 км замын барилгын ажлыг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “ Их богд зам” ХХК шалгарч ажлаа бүрэн дуусган ашиглалтад оруулсан. Шинэ суурьшлын бүсийн 10 км хатуу хучилттай автозамын барилгын ажлын зураг төсвийг хийх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерт “Ихэр мөнх” ХХК шалгарч холбогдох зураг төсвийг хийж хүлээлгэн өгсөн. Аймгийн төвийн асфальтан хучилттай автозамын хэвтээ тэмдэглэгээний ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 3 удаа зарлагдсан боловч оролцогч санал ирүүлээгүй тул 2022 оны хөгжлийн төлөвлөгөөний төсөлд тусгасан. Мөн 2022 онд 2.0 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тухайн онд 1.5 тэрбум төгрөгөөр санхүүжих 15 төсөл арга хэмжээг бүрэн хийж гүйцэтгэсэн. Тухайлбал 1,2км зам дагуу явган хүний зам, аймгийн төв доторх 1800м2 талбайд нөхөөс хийх, аймгийн төв доторх 1,65км авто зам, 55 машины авто зогсоол, сургууль орчмын бүсийг стандарт шаардлагад нийцүүлэн тохижуулах, аймгийн төв доторх уулзвар гарцуудыг засварлах, аймгийн төв доторх асфальтан хучилттай 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлт хийх ажлуудыг хийж гүйцэтгэсэн | |
| 134 | | 2. Аймгийн төв доторх хатуу хучилттай зам дагуу явган зам, унадаг дугуйн зам барих, шинэчлэх | 2021 - 2023 | | 1.2 ,0.0 | 2021 онд зам дагуух явган замын ажлыг “Баянхонгор - тохижилт үйлчилгээ” ОНӨААТҮГ өөрсдийн үйлдвэрлэсэн эко хавтангаар хийж гүйцэтгэсэн. Оготнотой булгийн зам дагуу 600м талбайд унадаг дугуйн зам барих ажлыг Их Богд зам ХХК бүрэн хийж гүйцэтгэсэн. 2022 онд Эрүүл мэндийн газрын хойд гэрлэн дохионы уулзвараас аймгийн Засаг даргын Тамгын газар хүртэл 697,8 м2 явган зам, Угалз багийн нийтийн орон сууцны 200 дугаар байрны хойд тал, замын зүүн талаар 139,5 м2 явган зам, 200 дугаар байрнаас Оготнотой булаг хүртэлх замын урд талаар 633,15м2 дугуйн болон явган зам барих ажлуудыг “Их богд зам” ХХК гүйцэтгэсэн. 2022 онд ХААГазрын замын 2 талаар 2100м2 явган замыг шинээр барьж ашиглалтад оруулсан. “Цэлмэг өглөө” захаас 4 дүгээр цэцэрлэг хүртэл- 900, “Чандмань –Баянхонгор” ХК-с Шөнийн зах хүртэл- 600, “Их богд” авто засвараас “МХгазар” хүртэл-700, “Мал эмнэлэг”-ээс Модерингийн уулзвар хүртэл- 1500, Баянхонгор их дэлгүүрээс хүүхдийн Тэмүүжин театр хүртэл- 500 нийт 4200м2 талбайд явган зам барьж ашиглалтад оруулсан байна. Тоосжилт бууруулах чиглэлээр орон сууцны болон төв зам дагуух шороон хөрсийг эко хавтангаар хучилт хийх ажлыг эхлүүлж “Хаш шоо” -1070, “Голомт банк”-1000, “Эрдэнэт хивс”-530, “Жаргалант парк” баруун тал-3500 нийт 6370м2 талбайд тус тус эко хавтан бүхий талбайг бий болгон тоосжилтыг бууруулсан. | |
| 135 | | 3. Замын хөдөлгөөн зохион байгуулах | 2021 - | | 16, | 2021 онд Замын сангийн 21,0 сая төгрөгийн хөрөнгөөр “Хурд сааруулагч” хийх тендерт “Их богд зам” ХХК шалгарч нийт 16 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хурд саарулагч, замын тэмдэг, тэмдэглэл, гэрлэн дохио хийх | 2023 | | 2000 , 4 | ширхэг хурд саарулагч хийж ашиглалтад оруулсан. Авто замын хэвтээ тэмдэглэгээний ажилд “Их Богд зам” ХХК шалгаран 50сая төгрөгөөр 25000 у/м замд авто замын хэвтээ тэмдэглэгээний засвар, шинэчлэлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. Аймгийн төв доторх эвдэрсэн талбайд замын нөхөөс хийх ажлын гүйцэтгэгчээр ”Их Богд зам” ХХК сонгогдон Замын сангийн 90 сая төгрөгөөр 1800м2 эвдэрсэн замд нөхөөс хийх ажлыг хийж гүйцэтгэсэн. Арван мянгатын 1,2км авто зам дагуух явган хүний зам барих босоо бордюр хийх ажлын гүйцэтгэгчээр “Тэнгэрийн уул” ХХК шалгаран Замын сангийн 163 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн, Есөн-Эрдэнэ захаас Хонгор хотхон хүртэлх 1,2км хатуу хучилттай зам дээр хучилт хийх ажлын гүйцэтгэгчээр “Их Богд зам” ХХК шалгаран Замын сангийн 515,2 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Нэгдсэн эмнэлгийн баруун хойд уулзвараас аюулгүйн тойрог хүртэлх 900м хатуу хучилттай авто замыг шинэчлэх ажлын гүйцэтгэгчээр “Их Богд зам” ХХК шалгаран Замын сангийн 499,7 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн, Онцгой байдлын газрын уулзвараас ХХААГ-ын уулзвар хүртэлх 750м хатуу хучилттай авто зам барих ажилд “Их Богд зам” ХХК шалгаран 451 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн. Оготнотой булаг орчмын тоглоомын талбайн 55 машины зогсоолын газар шорооны ажлыг “Их Богд зам” ХХК шалгарч 40 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн, Эрдэнэмандал сургуулийн сургууль орчмын бүсийг стандартын шаардлагад нийцүүлэн тохижуулах ажилд “Итгэлт тайж” ХХК шалгаран 30,0 сая төгрөгөөр хийж гүйцэтгэсэн | |
| 136 | 3.8.2. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах зорилгоор томоохон голуудад төмөр бетонон гүүр барина. | 1. Томоохон голуудад төмөр бетонон гүүр барих | 2021 - 2024 | | 3 | 2021 онд Галуут сумын Мандалын голын 62 у/м төмөр бетон гүүрийн ажлыг “ Эвт уул” ХХК , Галуут сумын Өлзийт голын төмөр бетон гүүрийн ажлыг “Их богд зам “ ХХК тус тус гүйцэтгэн байнгын ашиглалтад оруулсан. Загийн голын 90.9у/м төмөр бетон гүүр болон Богд сумын Түйн гол дээгүүр төмөр бетонон гүүр барих ажлын зураг төсвийг шинэчлэн боловсруулж 2021, 2022 оны улсын төсөвт тусгах санал явуулсан болно. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 137 | 3.8.4. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэнэ. | 1. Аймгийн Нисэх буудлын хүчин чадлыг нэмэгдүүлж, нислэгийн тоог нэмэгдүүлэх, нисэх буудлын үйл ажиллагааг олон улсын стандартад хүргэх | 2021 - 2024 | | 2 | "Aeromongolia" ХХК нь 2021 оны байдлаар долоо хоногт 1 удаа нислэг үйлддэг байсан ба Улаанбаатар-Баянхонгор, Баянхонгор-Улаанбаатар чиглэлд 24 нислэг үйлдсэн ба нисэх буудлын хэмжээнд 54 нислэг хийгдсэн. Коронавирусын цар тахал болон нисэх буудлын барилгын засвартай холбоотойгоор 2021 оны 6-р сард нислэгийн үйл ажиллагааг зогсоосон. 2022 онд шатахууны нэмэгдэлтэй холбоотойгоор нислэг хийгээгүй ба нислэгийн хуваарийн тов гараагүй байна. | |
| 138 | 3.9.1. Төвлөрсөн хот сум, суурин газарт дулааны эх үүсвэр шинээр барих, өргөтгөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлж дулаан хангамжийн чанар хүртээмж, ард иргэдийн ая тухтай амьдрах нөхцлийг сайжруулна. | 1. Баянхонгор аймагт 35МВт хүчин чадалтай дулааны станц барьж, ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 50 | Монгол Улсын Засгийн газраас “Алсын хараа 2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд хүрээлэн буй орчны тогтвортой байдлыг хадгалах, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, хот суурин газрын дулаан хангамжийн хүртээмжийг сайжруулах зорилгоор БНСУ-ын Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн хөрөнгөөр 10 аймгийн төвд дулааны станц, шугам сүлжээ барих төслийг 148,0 сая ам долларын зээлээр хэрэгжүүлэх болсон. ТЭЗҮ боловсруулалтын ажил хийгдэж дууссан. Төслийн ерөнхий гүйцэтгэгчээр БНСУ-ын “Бьюксан Инженеринг” ХХК, туслан гүйцэтгэгчээр “МЭЗ” ХХК гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 2022 онд Дулааны станцын барилгын суурийн ажил дууссан ба хөрс нягтруулалт, шороо булалтын ажил хийгдсэн. Графикийн дагуу 2022 онд хийгдэх ажлын явц 100%-тай байна. | |
| 139 | | 3. Шинэ суурьшлын бүсийн инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх | 2021 - 2023 | | 100 | Цэвэр хот төслийн хүрээнд 2021 онд Шинэ суурьшлын бүсийн цэвэр усан хангамжийн 4,5 км шугам, 500 м.куб хүчин чадалтай усан сан, 128м3 цэвэрлэх байгууламж болон бохир усны шугамын ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулаад байна. Энэ онд Улсын төсвийн 7 тэрбум төгрөг батлагдсан бөгөөд 2022 оны 1-р сарын 28-ны өдөр тендер сонгон шалгаруулалт зарлагдаж “Гал хонгор” ХХК шалгарсан ба 2022 онд санхүүжих дүн 480,0 сая төгрөг батлагдсан. Шинэ суурьшлын бүсэд 2022 онд шинээр баригдсан Ингэний | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сүүний үйлдвэр, мах ногооны зоорийн барилгад дулаан хангамж болон цэвэр усны 230м шугам хоолойн угсралтын ажил хийгдэж хүлээлгэн өгсөн. Тус ажил нь 2023 оны 3 дугаар улиралд ашиглалтад орно. | |
| 140 | | 4. Залуус хороололд инженерийн шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэх | 2022 - 2024 | | 30 | Залуус амины орон сууцны хорооллын гадна инженерийн шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний (2, 3, 4, 5, 6, 7, 9-р баг)-ийн ажлын зургийг иж бүрнээр нь “ДНТ” ХХК гүйцэтгэн 2022 онд хүлээлгэн өгсөн. Уг зургийн дагуу инженерийн шугам сүлжээний ажлыг гүйцэтгэх тендер сонгон шалгаруулалтаар “Б Софт” ХХК шалгарсан. Залуус хорооллын инженерийн шугам сүлжээний ажлыг 2023 онд хийгдэхээр төлөвлөгөөнд тусгагдсан. | |
| 141 | 3.9.2. Зарим сумдад "Сумын хөгжил" арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 1. "Сумын төвийн шинэчлэл" төслийг хэрэгжүүлэх | 2021 - 2023 | | 2 | Эрдэнэцогт сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Бридж бюлдинг” ХХК гэрээ байгуулж ажлыг эхлүүлсэн. Тус ажлын хүрээнд 2,5 км автозам, 64 м3 хүчин чадалтай “Эколос”-ын бага оврын цэвэрлэх байгууламж, төрийн 5 байгууллагад шинээр стандартын ариун цэврийн өрөө хийх, Гадна тохижилтын ажил, Тоглоомын талбай, Спорт талбай, Цэцэрлэгт хүрээлэн, ногоон байгууламж, 800м урттай дугуйн зам, 2.5 км урттай бохирын шугам, Усан хангамжийн эх үүсвэрийн 25м3 багтаамжтай нөөцийн сав /Хуучин эх үүсвэр ашиглах/, Цэвэрлэх байгууламж ажиллуулах цахилгааны дэд станц, камержуулалтын ажлууд хийгдэх бөгөөд авто зам, шугам сүлжээний угсралтын ажлууд хийгдэж байна. Галуут сумын төвийн шинэчлэлийн ажлын гүйцэтгэгчээр “Алегротовер констракшн” ХХК гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 2 км авто зам /гэрэлтүүлэг, камер, ногоон байгууламжтай/ 2 км дугуйн зам, 2 км явган зам, Бохирын шугам 2 км, 60м3 багтаамжтай цэвэрлэх байгууламж, Цэвэр усны эх үүсвэрийн гүний худаг, 60м3 багтаамжтай нөөцийн сав, 2км урттай цэвэр болон дулааны шугам, 100м*70м, 90м*60м талбайтай 2 цэцэрлэгт хүрээлэн, Албан байгууллагуудын ариун цэврийн өрөө шинээр хийх /6 байгууллагын барилгад 12 нойлын өрөө/ ажлууд хийгдэхээр төлөвлөгдснөөс дулаан, цэвэр усны шугам сүлжээ, авто зам, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугуйн зам, явган хүний замын ажлууд тус тус хийгдэж байна. Баацагаан сумын СУМЫН ТӨВИЙН ШИНЭЧЛЭЛ ТӨСӨЛ-ийн сонгон шалгаруулалтыг түлхүүр гардуулах нөхцөлтэйгөөр зохион байгуулж, “Рино инженеринг” ХХК шалгаран 5 тэрбум төгрөгөөр гэрээ байгуулсан. Зураг төслийн гүйцэтгэгчээр "Аркон" ХХК болон “Төгс орхон” ХХК Ерөнхий төлөвлөгөө суурь судалгааны ажил хийгдэж байна | |
| 142 | | 2. Сумын төвүүдийг цэвэрлэх байгууламжтай болох асуудлыг үе шаттайгаар шийдвэрлэх | 2021 - 2024 | | 1 | Эрдэнэцогт сумын “Сумын төвийн шинэчлэл”-ийн ажлын гүйцэтгэгчээр “Бридж бюлдинг” ХХК, Галуут сумын “Сумын төвийн шинэчлэл” ажлын гүйцэтгэгчээр "Алегротовер констракшн" ХХК тус тус гэрээ байгуулан ажиллаж байна. Тус сумдад хоногт 64м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламжийн ажлууд хийгдэж байна. Тус ажлууд нь 2023 оны 3 дугаар улиралд ашиглалтад орно. | |
| 143 | 3.9.3. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 1. Ус хангамж, ариутгах татуургын шугам сүлжээний хүчин чадлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 30 | Ус хангамжийн эх үүсвэрт шинээр гүний худаг гаргах ажлыг Засаг даргын нөөц хөрөнгө болон НҮБ-ын хүүхдийн сангийн хөрөнгөөр "Баянзаг Дриллинг" ХХК гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсийн 9000 метр HDPE маркийн хоолойн угсралтын ажил, 500м3 усан сангийн байгуулалтын барилгын болон шугам сүлжээ, тоноглолын угсралт зэрэг ажлуудыг хийж гүйцэтгэсэн. Шинэ суурьшлын бүсийн шугам хоолой тоног төхөөрөмжийг "Базардарь" ХХК нийлүүлж, шугам хоолойн угсралтын ажлыг "Чандмань-Баянхонгор" ХК гүйцэтгэн тус тус ашиглалтад оруулсан. Мөн Шинэ суурьшлын бүсэд 128м3 хүчин чадалтай цэвэрлэх байгууламж барьж ашиглалтад оруулж 640 хүүхдийн сургуулийн 100 айлын 2 нийтийн орон сууцны барилга байгууламжийг тус тус холбосон. | |
| 144 | 3.9.4. Үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам | 1. Баянхонгор сумын үерийн далан суваг, борооны болон хөрсний зайлуулах | 2021 - 2024 | | 30 | Баянхонгор хотын үерийн далан суваг, борооны болон хөрсний ус зайлуулах шугам сүлжээний ажлын зураг төслийг Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийж гүйцэтгүүлэн хүлээн авсан. Улсын төсвийн 2023 оны төсвийн төсөлд тус ажлын саналыг хүргүүлсэн. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | сүлжээний ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. | хоолой хийх | | | | | |
| 145 | 3.9.5. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөж, оршин суугчдын ая тухтай амьдрах нөхцлийг бүрдүүлнэ. | 1. Ашиглалтын шаардлага хангахгүй барилгуудыг буулгаж, шинээр төлөвлөх | 2021 - 2024 | | 1 | Ашиглалтын  шаардлага хангахгүй болсон хуучин байрыг дахин төлөвлөлтөд оруулах ажлыг 2017 оноос эрчимтэй хэрэгжүүлж 2021 онд Орон нутгийн хөгжлийн сангийн 1тэрбум 120 сая төгрөгийн санхүүжилтээр Баянхонгор сумын Номгон 1-р багийн 10-р байрыг дахин төлөвлөлтөд оруулсан. Мөн 2022 онд Баянхонгор сумын Рашаант 10-р багийн 2,7,9 дүгээр байрны дахин төлөвлөлтийн ажлыг эхлүүлж, 1-р ээлжийн 2 блок 80 айлын орон сууцны барилгыг 2023 оны 2 дугаар улиралд ашиглалтад оруулахаар ажиллаж байна. Нийтийн орон сууцыг дахин төлөвлөлтөд оруулснаар иргэдийн ая тухай амьдрах орчин нөхцөлийг бүрдүүлээд байна. | |
| 146 | | 2. Хуучин байрнуудын өнгө үзэмжийг сайжруулах, гадна тохижилтын ажлыг хийх, инженерийн шугам сүлжээг шинэчлэх | 2021 - 2022 | | | Баянхонгор сумын Номгон 1 дүгээр багийн 514 дүгээр байрны засварын ажлыг Алегротовер ХХК гүйцэтгэж байна. Уг их засварын ажлыг хүрээнд Бохирын шугам сүлжээ солих, гадна фасад, дээвэр, орцны дотор заслын ажлууд хийсэн. 2022 оны 07 сард улсын комисс ажиллаж, байнгын ашиглалтад оруулсан. Шинэ төгөл амины орон сууцны хорооллын 1,2 дугаар гудамжны 200 м дулааны шугам сүлжээний шинэчлэлийн ажлыг Тахилгат дулаан цагаан хайрхан ХХК гүйцэтгэсэн. | |
| 147 | 3.9.6. Аймаг, сумдын ерөнхий төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу аймгийн хэмжээнд 1000-аас доошгүй айл өрхийг орон сууцаар хангана. | 1. Шинэ суурьшлын бүсэд нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах | 2021 - 2022 | | 2 | Шинэ суурьшлын бүсэд 106 айлын 2 блок орон сууцны барилгын угсралтын ажлыг "Хаш гоёо" ХХК, Баянхонгор эко дулаан ХХК 2021 онд эхлүүлсэн бөгөөд 2022 оны 10 сард улсын комисс хүлээн авч бүрэн ашиглалтад оруулсан. | |
| 148 | | 2. Хонгор-1000 орон сууцны хороолол | 2022 - 2024 | | 3 | Хонгор-1000 орон сууцны хорооллолд 17 байршил дээр нийтийн орон сууцны зориулалтаар газар олголт хийгдсэн. Мөн Баянхонгор хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилтийг хангах зорилгоор Хонгор-1000 орон сууцны хорооллын талбайг | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах | | | | өргөжүүлэн Ерөнхий төлөвлөгөөний бүсчлэлд өөрчлөлт оруулах тухай аймгийн ИТХурлын 2022 _8/12 Тоот тогтоолоор нийтийн орон сууцны газруудыг Газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгаж Баянхонгор сумын Засаг даргын тамгын газарт эзэмшүүлсэн бөгөөд Хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөө, зураг төсөл боловсруулалтын ажил хийгдэж байна. Тус хорооллын барилга угсралтын ажлыг 2023 оны 2 дугаар улиралд эхлүүлэхээр ажиллаж байна. | |
| 149 | | 3. Хувийн хөрөнгө оруулалтаар аймаг болон сумдад нийтийн орон сууцны барилга барьж ашиглалтад оруулах | 2021 - 2024 | | 250 | Хувийн хөрөнгө оруулалтаар 2021 онд 267 айлын 9 орон сууцны барилга байнгын ашиглалтад орсон бөгөөд 2022 онд 1124 айлын 24 орон сууцны барилгын угсралтын ажлыг эхлүүлж тухайн онд 262 айлын 8 орон сууцны барилгад улсын комисс ажиллаж ашиглалтад оруулаад байна. | |
| 150 | 3.9.7. Аймаг, сумын төвүүдийн 380/04кВ-ын шугамын өргөтгөлийг нэмэгдүүлж, аймгийн төвд 35/10кВ-ын дэд станцыг шинэчилнэ. | 1. Баянхонгор аймгийн төвд 110/35/6кВ-ын дэд станцын өргөтгөл, шинэчлэлтийн ажил хийх | 2022 - 2024 | | 60 | Баянхонгор аймгийн 110/35/6 кВ-ын 12 МВА суурилагдсан чадалтай дэд станцын өргөтгөлийн ажлыг 11/35/10 кВ-ын 36 МВА суурилагдсан чадалтайгаар өргөтгөл хийх ажлын гүйцэтгэгчээр "ДМТМ Трейд" ХХК шалгаран гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн. тус ажлын хүрээнд 5МВАр-ын 2 ш SVG хүчдэл өсгөгч суурилуулах хийж гүйцэтгэж байна. | |
| 151 | 3.9.8. Үүрэн телефонуудын сүлжээний хамрах хүрээг өргөтгөнө. | 1. Шаардлагатай сум, багийн үүрэн холбооны 2G, 3G, 4G, 5G сүлжээний хамрах хүрээг | 2022 - 2023 | | 8 | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2022 онд 1,5 тэрбум төгрөгийн төсөвт өртөг бүхий Үүрэн холбооны сүлжээний ажил хийгдэхээр тендер зарласан байсан боловч 2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн Монгол Улсын 2022 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар хасагдаж 2023 оны улсын төсөвт дахин | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх | | | | батлуулсан. Тус ажил нь 2023 оны 2 дугаар улиралд эхэлнэ. | |
| 152 | 3.9.9. Аймгийн суурьшлын бүсүүдийг хамарсан утасгүй сүлжээний дэд бүтэц байгуулна. | 1. Утасгүй сүлжээний орчинг бий болгож, төрийн цахим үйлчилгээг авах нөхцлийг бүрдүүлэх | 2022 - 2024 | | 4 , 4 | Утасгүй сүлжээний орчин бүрдүүлэх боломжийг судалж, 2023 оны жилийн хөгжлийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэхээр хөрөнгө тусгасан | |
| 4. ДӨРӨВ. ЗАСАГЛАЛЫН БОДЛОГО | | | | | | | |
| 153 | 4.1.1. "Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 1. Дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2022 - 2024 | | 44 | “Төрийн мэргэшсэн албан хаагч" 2022-2026 онд дэд хөтөлбөрийг боловсруулах зорилгоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн 2022 оны 05 дугаар тогтоолоор аймгийн хэмжээний хүний нөөцийн нэгдсэн суурь судалгааг гаргах ажлын хэсгийг томилж, аймгийн хэмжээний 181 төрийн байгууллагын 5079 төрийн албан хаагч судалгаанд хамруулаад байна. Төрийн албаны сонгон шалгаруулалт, ажлын байрны сул орон тооны судалгаа, мэдээлэлд үндэслэн 2023-2026 онд хэрэгжүүлэх "Төрийн мэргэшсэн албан хаагч" хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөний хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталж, ажилтан албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр баталсан 153 байгууллага байна. Төрийн захиргааны албан хаагчдыг мэргэшүүлэх багц сургалтад үе шаттайгаар хамруулах чиг үүргийг хэрэгжүүлэх, мөн төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнд үндэслэн чадавхжуулах, ажлын байранд нь мэргэшүүлэх төлөвлөлтийг байгууллагын төсөвтэй уялдуулан хийж, хэрэгжилтийг ханган ажиллах үүргийн хүрээнд аймгийн 181 төрийн байгууллагын 82 нь буюу 45,3 хувь нь байгууллагын албан хаагчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг батлан хэрэгжилтийг ханган ажиллаж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 154 | 4.2.1. Төрийн албан хаагчийн ёс зүй, сахилга хариуцлагыг сайжруулна. | 1. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагаанд хяналт тавьж, сахилга хариуцлагыг чангатгах | 2021 - 2024 | | 120 | Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал, санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах, тэдний урам зоригийг сэргээх, хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлөөс 3 сарын хугацаанд "Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба" аяныг өрнүүлсэн. Аяныг зохион байгуулснаар дараах үр дүнд хүрсэн. Аймгийн хэмжээнд төрийн албаны нэр хүнд дээшилж, Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөлийн үйл ажиллагааны талаарх иргэдийн ойлголт, мэдлэг нэмэгдсэн.Аяны хүрээнд Төрийн албаны тухай хууль, тогтоомжийг сурталчлах, таниулах зэрэг ажлыг эрчимжүүлсэн нь Төрийн албаны шинэтгэлийн бодлогыг хэрэгжүүлэхэд томоохон түлхэц болж байна. Салбар зөвлөлд төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчилтэй холбох өргөдөл, гомдлын тоо 33 хувиар буурсан үзүүлэлтэй байна. Төрийн байгууллагуудын ёс зүйн зөвлөлийн үйл ажиллагааны хүрээнд Засгийн газрын 2019 оны 33 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэм”-ийн хэрэгжилтийг эрчимжүүлж, дүрэмд заасны дагуу 25-аас дээш албан хаагчтай байгууллагуудад “Ёс зүйн зөвлөл”-ийг шинэчлэн байгуулж үйл ажиллагааг эрчимжүүлэн аймгийн 181 төрийн байгууллагын 97 нь буюу 53.6 хувь нь ёс зүйн зөвлөлийг байгуулж, нийтдээ 98 удаагийн сургалт, зөвлөгөө, мэдээллийг байгууллагынхаа 1420 төрийн албан хаагчдад өгч, гарч болох ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг зохион байгуулж ажилласан | |
| 155 | 4.3.1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох. | 1. Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн хэрэгцээг тодорхойлох суурь судалгаа авах | 2021 - 2024 | | 90 | Төрийн байгууллагуудын мэдээллийн технологийн тоног төхөөрөмжийн хангалт, мэдээллийн технологи хариуцсан албан хаагчдын мэргэшүүлэх судалгаанд 40 агентлаг, байгууллагын 265 албан хаагчийн хамруулан хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон. Энэхүү судалгаанаас харахад төрийн байгууллагад ажиллах мэргэжлийн боловсон хүчин дутмаг, тэр тусмаа сумд ажиллах мэдээллийн технологийн мэргэжилтэн хомс, тухайн чиглэлийн үйл | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагаа сумдад доголдолтой байна. | |
| 156 | | 2. Мэдээллийн технологийн мэргэжилтнүүдийг нэгдсэн бодлого, зохион байгуулалтаар хангах | 2022 - 2024 | | 50 | Төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан 40 ажилтан мэргэжилтнүүдэд "Супер Админ" нэртэй Active director, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал сэдвийн хүрээнд 16 цагийн чадавхжуулах (24.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий) сургалтыг үнэ төлбөргүй зохион байгуулсан.“Дижитал Баянхонгор” арга хэмжээний хүрээнд “Inspire 2022”, Цахим хөгжил, харилцаа холбооны яам, “И-Монгол” академийн хамтарсан багийн 5 хоногийн сургалтад сумдын операторууд хамрагдаж, тоон гарын үсгийн сунгалтын хүсэлтийг “TRIDUMKEY” тоон гарын үсэг олголтын компанид хүргүүлэн, сунгалтыг хийлгэж, баталгаажуулан тоон гарын үсгийг нь сум тус бүрийн операторуудад албан ёсоор хүлээлгэн өгсөн. | |
| 157 | 4.3.2. E-Mongolia хөтөлбөрийн хүрээнд “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”–ийн үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, чанар хүртээмжийг сайжруулна. | 1. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулж, цахим платформын ашиглалтыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 124 2000 | Цахим үйлчилгээний нэгдсэн портал E-Mongolia системд иргэн, аж ахуйн нэгж, гадаадын иргэнтэй холбоотой 1588 төрлийн үйлчилгээ нэвтэрч, 6800 иргэнд бүртгэл үүсгэж, 18 иргэний гадаад паспортын сунгалт, 27 иргэний жолооны үнэмлэхний хугацааг сунгаж шинээр захиалсан, 24 иргэнд цахим үнэмлэх захиалсан, операторын ажлын хүрээнд иргэдэд хүргэж буй 244 төрлийн үйлчилгээнээс 2022 оны байдлаар нийт 4367 иргэнд лавлагаа мэдээлэл гаргаж, цахим үйлчилгээг 11167 иргэнд хүргэсэн. M-SIGN байгууллагын цахим тоон гарын үсгийг 28 аж ахуйн нэгж байгууллагад олгож эхэлсэн. Үйлчилгээний нэгдсэн төвд 5 байгууллагын 8 мэргэжилтэн 198 төрлийн төрийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй үзүүлж, хөдөлмөр халамжийн үйлчилгээг 11476 иргэнд, Улсын бүртгэлийн үйлчилгээг 2596 иргэнд, газрын үйлчилгээг 6287 иргэнд, Хууль зүйн туслалцааны төв нь өмгөөлөл хүлээн авсан хэрэг 46, хэргийн холбогдогч 49. зөвлөгөө 213, эрүүгийн чиглэлээр 112, иргэний чиглэлээр 82, захиргааны чиглэлээр 8, нийт 510 иргэнд, Нотариатын үйлчилгээ Гэрээ- 2712, Итгэмжлэл-1036, Гарын үсгийн баталгаа-288, Өвлөх эрхийн гэрчилгээ-126, Хуулбар үнэн-1610 нийт 4162 хүнд үйлчилгээ үзүүлсэн. Аймгийн хэмжээнд Төрийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний нэгдсэн 1 төв, 20 сумын үйлчилгээний төвөөс жилийн эцсийн байдлаар төрийн үйлчилгээг нийт 51787 иргэн, аж ахуйн нэгж байгууллагад түргэн шуурхай, нээлттэй үйлчилгээ үзүүлэн ажилласан. | |
| 158 | 4.3.3. Төрийн байгууллагын мэдээллийн аюулгүй байдлын тогтолцоог бэхжүүлэх, бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, ур чадварыг дээшлүүлнэ. | 1. Бүх нийтийн харилцаа холбоо, мэдээллийн технологийн суурь мэдлэг, тоон бичиг үсгийн ур чадварыг дээшлүүлэх олон талт арга хэмжээг зохион байгуулах | 2022 - 2024 | | 40 | Аймгийн Засаг даргын 2022 оны 04 дугаар сарын 21-ны өдрийн А/272 дугаар захирамжийн дагуу "Дижитал Баянхонгор" арга хэмжээ зохион байгууллаа. "Цахим шилжилтийг хүн бүрд" уриатай "Inspire 2022" арга хэмжээгээр 400 гаруй иргэд төрийн албан хаагч, 800 гаруй ЕБС-ын ахлах ангийн сурагчдыг хамарсан мэдээллийн технологийн чиглэлээр сургалт, нөлөөллийн үйл ажиллагаа зохион байгуулсан бол төрийн байгууллагуудын мэдээллийн технологи хариуцсан 40 ажилтан мэргэжилтнүүдэд "Сүпер Админ" нэртэй Active director, байгууллагын дотоод сүлжээ, мэдээллийн аюулгүй байдал сэвдийн хүрээнд 16 цагийн чадавхжуулах (24.0 сая төгрөгийн үнэлгээ бүхий) сургалтыг үнэ төлбөргүй зохион байгууллаа.Мөн УИХ-ын тамгын газар, цахим хөгжил харилцаа холбооны яам, И-Монгол академи, ХХЗХ, зэрэг яам агентлагуудтай хамран төрийн үйлчилгээг цахимжуулах, иргэдэд мэдээлэл өгөх, төрийн албан хаагчдыг чадавхжуулах, шинээр хэрэгжиж байгаа цахим хөгжлийн багц хуулиудыг танилцуулах, төрийн цахим үйлчилгээний нээлттэй хаалганы өдөрлөг зэрэг үйл ажиллагаануудыг зохион байгуулж нийт 5000-гаруй иргэд төрийн албан хаагчдыг хамруулан ажиллалаа.Аймгийн хэмжээнд нийт 59134 иргэн тоон гарын үсэг авахаас 2022 оны хагас жилээр 5360 буюу 9,6 хувь байсан бол жилийн эцсийн байдлаар 20222 буюу 34,1 хувь болж хагас жилээс 24,5 хувиа өссөн дүнтэй байгаа нь иргэдийн цахим ур чадвар нэмэгдэж төрийн үйлчилгээг шуурхай авах боломж бүрдсэн | |
| 159 | | 2. Бүх төрлийн өргөдөл гомдлын шийдвэрлэлт, тусгай зөвшөөрөл | 2022 - 2024 | | 90 50 | Тус онд орон нутгийн онцлог бүхий 1 шатлалт, олон шатлалт 31 үйлчилгээг e-mongolia.mn системд холбосон бөгөөд тус системээр дамжуулан Эрүүл мэндийн салбарын “Эрүүл мэндийн чиглэлээр мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл сунгах” | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | олголтыг цахимжуулах | | | | үйлчилгээнд 16 хүсэлт ирснийг шийдвэрлэсэн 10, татгалзсан 2, Онцгой байдлын газрын “Ажлын байрны галын аюулгүй байдлын дүгнэлт гаргах” үйлчилгээнд 14 хүсэлт ирснээс шийдвэрлэсэн-14, Цагдаагийн газар “Хяналтын камерын тодорхойлолт гаргах” үйлчилгээнд 25 хүсэлт ирснээс шийдвэрлэгдсэн-20, татгалзсан 5 үйлчилгээ нийтдээ аймгийн хэмжээнд 55 үйлчилгээг цахимаар авсан. Иргэдээс ирсэн өргөдөл гомдлын шийдвэрлэлтийн системийг 2023 оны төсөвт тусган хэрэгжүүлэхээр хөгжүүлэлтийн ажлын даалгаврыг боловсруулан ажиллаж байна. | |
| 160 | | 3. "Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем"-ийн нэмэлт хөгжүүлэлтийг хийх | 2022 - 2024 | | 70 | Баянхонгор аймгийн цахим мэдээллийн нэгдсэн систем нь 8 модул системтэй бөгөөд 2022 оны байдлаар 3 модул бүрэн ашиглагдаж байгаа бөгөөд шинээр "Иргэдийн санал гомдол илгээх систем"-ийн хөгжүүлэлтийн ажлыг "Анар системс" ХХК-тай 2022 оны 10 дугаар сарын 28-ны өдрийн 2022/158 дугаартай гэрээ байгуулан гүйцэтгүүлж 2022 оны 11 дүгээр сарын 28-ны өдөр бүрэн хүлээн авсан. Аймгийн Статистикийн хэлтэстэй хамтран хэрэгжүүлж байгаа ДАШБОАРД буюу "Аймгийн тоон мэдээллийн нэгдсэн систем"-ийг батлагдсан төсөв нь тус програм хангамжийн хөгжүүлэлтэд хүрэлцэхгүй байна. Систем хөгжүүлэх ажлын даалгаврыг боловсруулж дууссан. | |
| 161 | 4.3.4. Бүс нутгийн аялал жуулчлал, бизнесийг дэмжих технологийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Виртуал аялал хийх боломжтой "VR-Bayankhongor" төвийг байгуулж, контентийг нэмэгдүүлэх | 2022 - 2024 | | 600 | Виртуал Баянхонгор төвийг орон нутгийн төсвөөр 250.0 сая төгрөгөөр байгуулсан бөгөөд үйл ажиллагааг эхлүүлж хувийн хэвшилд шилжүүлэн өгөхөөр Орон нутгийн өмчийн газраас дуудлага худалдааг 2 удаа зарлаж Айети Юнипикэшн ХХК 8 жилийн хугацаатай эргэн төлөх нөхцөлтэйгөөр хувьчлан авсан. | |
| 162 | | 2. 20 сумын төвийн нутаг дэвсгэр, байгууллага, үйлчилгээний газар, зам, | 2021 - 2023 | | 100 | Тус арга хэмжээнд зарцуулахаар баталсан төсөвт өртөг ажлын даалгаврын дагуу систем хөгжүүлэлтэд хүрэлцэхгүй болсон тул тус ажил хэрэгжих боломжгүй болсон. Ажлын даалгавар болон техникийн нөхцөл бүрэн боловсруулж дууссан төсвийг дахин боловсруулж дараа жилийн төсөвт суулган хэрэгжүүлэх | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хорооллыг заасан 360, VR, зураг, дүрсний танилцуулгыг хөгжүүлж Google street-д байршуулах | | | | шаардлагатай. | |
| 163 | 4.3.5. Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд бүх нийтийн хандлагыг төлөвшүүлнэ. | 1. Авлигын гэмт хэргийн гаралтын тоог бууруулж, шударга байдлын төвшинг нэмэгдүүлэн, цахим хуудасны ил тод байдлын төвшинг ахиулах | 2021 - 2024 | | 2 72 48 | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулан 10.900. 000 төгрөг төсөвлөж, 18 зорилт, 79 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан. Авлигын эсрэг хууль болон бусад хууль тогтоомжийг хэрэгжүүлэн ажиллах, ашиг сонирхол, албан тушаалын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, түүнтэй тэмцэх зорилгоор цахимаар болон танхимын 161 сургалтыг давхардсан тоогоор 3000 гаруй албан хаагчдад зохион байгуулсан. Урьдчилан сэргийлэх зөвлөгөөг MGL радиогоор 370 удаа, лед дэлгэцээр 1200 удаа, фейсбүүк хуудсаар 205 удаагийн давтамжтай давхардсан тоогоор нийт 181.800 иргэнд мэдээлэл хүргэж ажилласан. Авлигын гэмт хэргийн гаралтын тоо 2021 оны 4 нэгжээр буурсан 2022 онд 1 нэгжээр өссөн байна. Шударга байдлын үнэлгээгээр 2021 онд 68.8-тай, 2022 үнэлгээгээр 68.5%-тай үнэлэгдсэн Цахим хуудасны ил тод байдлын түвшин өмнөх онтой харьцуулахад 57.8 хувиар өссөн эерэг үзүүлэлттэй байна | |
| 164 | 4.4.1. Тодорхой төрлийн гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоох замаар түүнээс урьдчилан сэргийлэх, гаралтыг | 1. Согтуугаар үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 124 , 1721 | Гэмт хэрэг, зөрчлийн шинжтэй 5263 дуудлага, мэдээлэл хүлээн авч хуульд заасан журмын дагуу шалгаж шийдвэрлэсэн өмнөх оны мөн үеийнхээс 747 буюу 16.5 хувиар өссөн байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 122 буюу өмнөх онтой харьцуулбал 49 нэгжээр буурсан байна Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэрэг 27 буюу өмнөх онтой харьцуулбал 8 нэгжээр өссөн байна. Малын хулгайн гэмт хэрэг 33 буюу өмнөх онтой харьцуулбал 12 нэгжээр өссөн байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг 41 буюу өмнөх онтой харьцуулбал 5 нэгжээр буурсан байна. Гэмт хэргийн илрүүлэлт 1.5 пунтээр өссөн байна.“Зөв | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | бууруулна. | | | | | амьдрал” дэд хөтөлбөрийг 2021, 2022 онуудад хэрэгжүүлэн нийт 520,000,000 төгрөгийн төсөв зарцуулан “Жаргалтай амьдрал төв”-ийг байгуулан жилд дунджаар 120 иргэнийг эмчлэх зорилт тавьж ажилласан. Тухайн жилүүдэд нийт архинд донтох өвчтэй 424 иргэн хэвтэн эмчлүүлснээс 277 иргэн буюу 65% нь эдгэрэлтэй байна. Согтуугаар үйлдэгдсэн гэмт хэрэг 122 бүртгэгдэж 49 нэгжээр буурсан. | |
| 165 | | 2. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг, зөрчлийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 41 , 153 | Гэр бүлийн хүчирхийллийн гэмт хэрэг, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх төлөвлөгөөг батлуулан 7.500. 000 төгрөг төсөвлөж арга хэмжээ хэрэгжүүлэн ажиллалсан. Энэ төрлийн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, хүчирхийлэл үйлдэгчид хариуцлага хүлээлгэх, дахин гэмт хэрэг, зөрчил үйлдүүлэхгүй байх, газар дээр нь нөхцөл байдлын үнэлгээ хийх зорилгоор 4.5 сая төгрөгийн өртөг бүхий 4 ширхэг таблетыг Цагдаагийн газрын алба хаагчдад хүлээлгэн өгч, үйл ажиллагаандаа ашиглаж байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг 41 бүртгэгдэж өмнөх оноос 5 нэгжээр буурсан эерэг үзүүлэлтэй байна. | |
| 166 | | 3. Хөдөлгөөний аюулгүй байдлын эсрэг гэмт хэргийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 21 | Хөдөлгөөний аюулгүй байдлыг эсрэг гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулах, урьдчилан сэргийлэх ажилд орон нутгийн төсвөөс 220.000.000 сая/төг-ийг шийдвэрлэж, нэгдсэн арга хэмжээ 12, хэсэгчилсэн арга хэмжээ 15 удаа зохион байгуулсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор Онцгой байдлын 4 замын уулзварт гэрлэн дохио хийх ажилд 80.0 сая/төгрөгийг зарцуулж ашиглалтад оруулж илрүүлэлт 2,5 хувиар нэмэгдсэн эерэг үзүүлэлтэй байгаа боловч гэмт хэргийн тоо 27 бүртгэгдэж 8 нэгжээр өссөн байна. | |
| 167 | | 4. Мал хулгайлах гэмт хэргийн тоог бууруулах | 2021 - 2024 | | 63 | Мал хулгайлах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх зорилгоор сумдын малчдын бүлгийн дунд “Шилдэг малчдын бүлэг” шалгаруулах болзолт уралдааныг 2 дахь жилдээ зарлан үр дүнг тооцон ажилласан. Баянхонгор аймгийн хэмжээнд мал хулгайлах | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гэмт хэрэг  33 бүртгэгдсэн нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 12 нэгжээр буюу 57,1 хувиар өссөн, гэмт хэргийн илрүүлэлт 44.4% байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8.7 пунктээр өссөн үзүүлэлтэй байна. | |
| 168 | | 5. Цагдаагийн газрын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх | 2021 - 2024 | | 58 | 2021 онд Аймгийн Цагдаагийн газрын үйл ажиллагаанд орон нутгийн төсвөөс 477.0 сая/төг-ийн тоног төхөөрөмж, машин техник хэрэслийн дэмжлэг үзүүлсэн.  Мөн аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлөөс 72.0 сая/төг-ийг, Орон нутгийн төсвөөс 46.0 сая/төг-ийг тус тус шийдвэрлэн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд дэмжлэг үзүүлэн ажилласан. Богд, Жаргалант сум дахь сум дундын цагдаагийн тасгийн барилгын ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг ЦЕГ-аас зарлаж, “Хоролбагана констракшн” ХХК шалгарч, 598,897,508 /таван зуун ерэн найман сая найман зуун ерэн долоон мянга таван зуун найман/ төгрөгөөр гэрээ байгуулан, барилгын ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна. Орон нутгийн зүгээс дэмжлэг үзүүлснээр гэмт хэргийн илрүүлэлт сайжирсан. | |
| 169 | | 6. 1,4,5,6,10-р багийн нутаг дэвсгэрт Гамшгийн үеийн зарлан мэдээлэх, утасгүй сүлжээний орчинг бий болгох | 2022 | | | Энэ жилийн 03 дугаар сарын 24-ний өдрийн гамшгийн аюулын тухай зарлан мэдээлэх, дуут дохиогоор ажиллах дадлага сургуулиар утасгүй сүлжээний технологийг ашиглан иргэдэд зарлан мэдээлэл хүргэж ажилласан. Аймгийн эдийн засаг нийгмийг хөгжүүлэх “Ухаалаг Баянхонгор“ дэд хөтөлбөрийн инновацын үйл ажиллагааны тэргүүлэх чиглэлийн хүрээнд Баянхонгор сумын 2, 7, 9 дүгээр багийн нутаг дэвсгэрт оршин суудаг иргэдэд төрийн үйлчилгээг үнэ төлбөргүй, шуурхай хүргэх, утасгүй интернэтийн үйлчилгээг хүргэх ажлын хүрээнд "Бат-Од ХХК" шалгарч “WI-FI” төхөөрөмжийг Эрдэнэмандал хайрхан, жижиг хөх толгой, герман толгой, Дуурсах 3 дугаар багийн 13 дугаар гудамжны үзүүр зэрэг 4 цэгт суурилуулах , программ хангамжийн ажил хийгдсэн. Үлдэгдэл ажлуудаа хийж дуусгаагүй тухайн компанийг шүүхэд өгсөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 170 | | 7. Дэвшилтэт технологи бүхий камержуулалтын нэгдсэн системийг нэвтрүүлэх | 2021 - 2024 | | 50 | 2021 онд Баянхонгор аймгийн томоохон төсөл хөтөлбөрүүдийг танилцуулсан "Аймгийн хөгжлийн зөвлөгөөн"-д Баянхонгор сумын Хяналтын камерын ухаалаг системийн төслийн дагуу 2022 онд Баянхонгор сумд 190.0 сая төгрөгийн хяналтын камерын системийн ажил хийгдэж байна. Тус ажлаар Баянхонгор сумын төвийн нутаг дэвсгэрт 45 ширхэг өдөр шөнө өнгөтөөр харах камер,8 ширхэг хөдөлгөөнт камер, 4 ширхэг дугаар илрүүлэгчтэй камер суурилуулагдана. | |
| 171 | 4.5.1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж, иргэдэд эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлнэ. | 1. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг тасралтгүй дээшлүүлж, иргэдийн эрх зүйн харилцаанд оролцох чадварыг нэмэгдүүлэх | 2021 - 2024 | | 1600 | Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг батлуулж 11.000.000 төгрөг төсөвлөж, 6 зорилт, 31 арга хэмжээ хэрэгжүүлж ажилласан. Шинээр болон шинэчлэн батлагдсан хууль тогтоомжоор 20 сум, 80 байгууллагын 9500 гаруй иргэд, төрийн албан хаагчдад төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, захиалгат танхимын сургалтыг зохион байгуулж анхан шатны зөвлөгөө мэдээллийг 8000 гаруй иргэнд өгч ажилласан. Хууль зүйн үндэсний хүрээлэнтэй хамтран аймгийн хэмжээний 214 эрх зүйн хөтчийг бэлтгэсэн. Иргэдийн эрэлт хэрэгцээг хангахуйц эрх зүйн мэдээ, мэдлэгийг цахимаар болон танхимаар нээлттэй, хүртээмжтэй, энгийн хялбарчилсан хэлбэрээр хүргэн ажилласан. | |
| 172 | 4.6.1. Албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг төгөлдөржүүлэн, мэргэжилтэй боловсон хүчнээр хангаж, архивын баримтын хадгалалт хамгаалалт | 1. Төрийн архивын лавлагаа мэдээллийн үйлчилгээнд тоон гарын үсгийг бүрэн нэвтрүүлж, үйлчилгээний хүртээмжийг сайжруулах. | 2021 - 2024 | | 60 | www.e-mongolia.mn системээр Төрийн архивын лавлагаа мэдээлэл болон албан хэвлэмэл хуудасны хэвлэлтийн захилга, олголтын үйлчилгээг хийж, тоон гарын үсгээр эхэлснээр онлайнаар 10 лавлагаа олгоод байна. 2. Архивын ерөнхий газрын лавлагаа мэдээллийг www.e-archives.gov.mn системээс онлайнаар бусад аймаг, хотын 270 иргэнээс лавлагаа мэдээлэл үзүүлэх хүсэлт захиалга хүлээн авч, сан хөмрөгөөс хайлт хийн шийдвэрлэж, тоон гарын үсгээр олгох, үйл ажиллагааг зохион байгуулж ажиллалаа. Мөн бусад аймаг, Үндэсний төв архиваас шийдвэрлэж ирсэн нийт 579 лавлагаанаас 336 хүсэлтийг иргэдэд нь олгоод байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 173 | аюулгүй байдлыг сайжруулна. | 2. Төрийн болон байгууллагын архивын хадгалалт хамгаалалтыг сайжруулах. | 2021 - 2023 | | 70 , 0 | Төрийн архивын хадгалалт хамгаалалт 1.1.Төрийн архивын сан хөмрөгийн камерын нэгдсэн систем өргөтгөх ажилд Айети юнипикэшн ХХК-тай гэрээ байгуулан 18,3 сая төгрөгөөр өргөтгөн, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж эхлээд ажлын гүйцэтгэл 90% явагдаж байна. 1.2.Төрийн архивын серверийн өрөөнд хөргүүрийн систем өргөтгөх ажилд компанитай гэрээ байгуулан, 7.5 сая төгрөгөөр өргөтгөн, нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж ажиллалаа. 2.Байгууллагуудын архивын хадгалалт хамгаалалт 2.1.Бууцагаан сумын Эрүүл мэндийн төв-6, Өлзийт сумын Эрүүл мэндийн төв-2, Өлзийт сумын ИТХ-1, Баянхонгор сумын ЗДТГ-2, нийт 11 нягтаршуулсан тавиур шүүгээг авсан. | |
| 174 | | 3 . Төрийн болон байгууллагын архивын баримтын цахим санд шилжилтийг эрчимжүүлэх. | 2021 - 2024 | | 86 | Төрийн архивын цахимжуулалт “Цахим архив-Баянхонгор” дэд хөтөлбөрийн хүрээнд 2022 оны эхний хагас жилд Төрийн архивын сан хөмрөгт хадгалагдаж байгаа 63 хөмрөгийн 1821 хадгаламжийн нэгжийн 187331 хуудас баримтыг цахим системд бүрэн шилжүүлж, баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлсөн. Байгууллагуудын архивын цахимжуулалт Аймгийн төрийн болон орон нутгийн өмчийн 151 байгууллагын 10153 хадгаламжийн нэгжийн 176453 хуудас баримтыг цахим системд бүрэн шилжүүлж, баримтыг ашиглалтаас бүрэн чөлөөлсөн. | |
| 175 | | 4. Төрийн болон байгууллагын архивын баримтыг сэлбэн засах. | 2021 - 2024 | | 0,22 | Төрийн архивын тасгийн сан хөмрөгт хадгалагдаж байгаа нэн үнэт 21 баримтад анхан шатны сэлбэн засалт хийж цахим санд шилжүүлсэн. | |
| 5. ТАВ. НОГООН ХӨГЖЛИЙН БОДЛОГО | | | | | | | |
| 176 | 5.1.1. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлнэ. | 1. Цөлжилтөөс сэргийлэх, элсний нүүлтээс хамгаалах зорилгоор 50га хамгаалалтын | 2021 - 2022 | | | Баянхонгор сумын Шинэ суурьшлын бүсийн хойд хэсэгт 50 га газарт цөлжилтийг бууруулж, элсний нүүлтээс хамгаалах хамгаалалтын ойн зурвасыг байгуулсан. Тус ойн зурваст Байгаль орчин, аялал жуулчлалын яамны 100,0 сая төгрөг, аймгийн байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 91,1 сая | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зурвас байгуулах | | | | төгрөгийн санхүүжилтээр нь хашаа хамгаалалт, усалгааны систем, ногоон байгууламжид шаардлагатай 1 худгийг гаргаж, нийт 5 төрлийн нийт 11163 ш мод тарьж усалгаа арчилгааг хийсэн. Нийт тарьсан модны амьдралтын хувь нь 70.54 хувь байна. | |
| 177 | | 2. "Тэрбум мод" үндэсний хөдөлгөөний хүрээнд 20 сая мод тарих | 2021 - 2024 | | 50000,50 | Аймгийн хэмжээнд 1429 айл өрх 18247 ширхэг мод, Бичил цэцэрлэг хүрээлэн, сааданд 30903 ширхэг мод, 60,8 га талбайд нэрэмжит ой төгөл шинээр байгуулан 12268 ширхэг мод, 37,45 га талбайд шинээр 9 бичил цэцэрлэг байгуулан 11695 ширхэг мод, 72,7 га талбайг зүлэгжүүлэн, 22 га талбайд 10 ширхэг цэцгийн мандал, Төв суурин газарт 34,7 га талбайд 71784 ширхэг мод, Хамгаалалтын зурваст 106,6 га талбайд 36924 ширхэг мод, Ойжуулалтад 121,7 га талбайд 39064 ширхэг модыг тус тус тарьж усалгаа арчилгааг хийсэн. Нийт 6414 иргэн, 537 аж ахуйн нэгж байгууллага оролцон 260940 ширхэг мод тарьж, амьдралтын хувь 70,54%- тай байна. Мөн Сум дундын ойн ангийн Мод үржүүлгийн газарт 250,000 ширхэг суулгац, Шинэ суурьшлын бүсийн Мод үржүүлгийн газарт 50,000 ширхэг суулгац, Эрдэнэцогт суманд 10,000 ширхэг суулгац нийт 310,000 ширхэг суулгацыг бэлтгэж талбайд тариалалт хийсэн. | |
| 178 | | 3. Аймгийн ойн менежментийн төлөвлөгөөг боловсруулж, хэрэгжилтийг хангах | 2021 - 2024 | | 20 | Аймгийн аялал жуулчлалын нөөц газар болох Цагаан агуй, Бичигт хад, Өргөөтийн рашааны тохижилтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн Их Богдын Байгалийн цогцолборт газрын Төрийн тахилгат Их Богд уулын Цонж хайрхныг түшиглэн аялал жуулчлалын отоглох цэг байгуулсан. Нийт 4 газрын тохижилт хийгдснээр Их Богд уулын Цонж орчмыг тохижуулж отоглох цэг байгуулснаар дотоод, гадаадын жуулчдын амрах, аялах тав тухтай орчныг бүрдүүлсэн төдийгүй байгаль орчныг хамгаалж, бүс нутгийн эдийн засаг болон тусгай хамгаалалттай газар нутгийн үнэ цэнийг нэмэгдүүлсэн. | |
| 179 | | 4. Цаг агаарт зориудаар нөлөөлж хур тунадасны хэмжээг | 2021 - 2024 | | 30 | Цаг агаарт зориудаар нөлөөлөх үйл ажиллагааг Баян-Бороо -1,2 экспедиц 8 удаа, Баянцагаан газрын генератор 2 удаа явуулсан. Үр дүнд нь 5 дугаар сард аймгийн нийт нутгийн 35-50 хувийг хамруулан хур тунадсыг нэмэгдүүлсэн. Харин 07 дугаар сард | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлэх | | | | Хориулт, Хуучин жинст сумын нутгаар олон жилийн дунджаас 6.0-12.0 миллиметрээр их, 08 дугаар сард Галуут, Баянцагаан сумын нутгаар олон жилийн дунджаас 3.0-9.0 миллиметрээр их хур тунадас тус тус орсон. Бусад нутгаар олон жилийн дунджийн орчим буюу бага хур тунадас орсон | |
| 180 | 5.2.1. Булгийн эхийг хамгаалах, ундаргыг сэргээх, хөв байгуулах ажлыг зохион байгуулж, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх. | 1. Булгийн эхийг хамгаалж, ундаргыг сэргээх, хөв байгуулах | 2021 - 2024 | | 3 | Хүрээмарал сумын Хөх бүрдийн 1-р баг "Ацын гол"-ын эхийг багийн иргэдийн хандиваар хашиж хамгаалсан. Усны газрын санхүүжилтээр Эрдэнэцогт сумын Жанжины 4-р баг Хүрэмтийн гол дагуух “Сонгинотын харз”-ийг хамгаалах ажлыг тус сумын "Марал-Баян-Өргөө" ХХК хийж гүйцэтгэсэн. “Монголын унаган байгалийн хүлцэл, тогтворжилтыг хангах нь” төслийн хүрээнд Баянцагаан сумын 1-р багийн Хужрын булаг, 4-р багийн Бага амны булаг, Баян-Өндөр сумын 1-р багийн Цагаан толгойн булаг, Шинэжинст сумын Задгайн булаг Баацагаан суманд 1 булгийн эх хашиж хамгаалах ажил тус тус хийгдэж усны урсац, ундрага сэргэсэн байна. | |
| 181 | | 2. Малчид, нөхөрлөлүүдтэй хамтран байгаль орчноо хамгаалах нөлөөллийн олон талт ажлыг зохион байгуулах | 2021 - 2024 | | 150 | Байгаль орчин, аялал жуулчлалын яам, Уур амьсгалын өөрчлөлтийн судалгаа, хамтын ажиллагааны төвөөс хамтран хэрэгжүүлж буй “Уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох стратеги төлөвлөлтийг боловсронгуй болгох, орон нутгийн иргэдийн байгаль орчин болон байгалийн нөөцийн салбарт дасан зохицох чадавхыг бэхжүүлэх” төслийн 2 удаагийн сургалтад байгалийн нөөцийн хамтын менежментийн 10 нөхөрлөлийн төлөөлөл оролцсон. Мөн “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 1000 сургагч багш бэлтгэх хөтөлбөрт 17 нөхөрлөлийн гишүүн хамрагдсан. Бөмбөгөр сумын Арцат дэл хайрхан, Ямбат цагаан сайр, Өлзийт сумын Баян Бийр, Баян Хангайн хишиг, Жинст сумын Хавцгайтын Эх-Элбэг зэрэг нийт 5 нөхөрлөлтэй хамтран ан амьтдыг ажиглах, тандан судлах ажлыг хийж, биотехникийн арга хэмжээ авч хамтран ажилласан байна. Мөн байгалийн нөөцийн хамтын менежментийн 5 нөхөрлөлийн гишүүд болон багийн иргэд нийт 200 хүнд мэргэжил арга зүйн сургалтыг хийж ажилласан | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байна. | |
| 182 | 5.2.2. Зэрлэг амьтдыг хамгаалах өвс тэжээлийн хомсдолоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулна. | 1. Зэрлэг амьтдад биотехникийн арга хэмжээ авах | 2021 - 2024 | | 3 | Аймгийн хэмжээнд нийт давхардсан тоогоор 308 удаагийн явалтаар зэрлэг амьтдын байршил бүхий газарт 4862 боодол өвс, 71 шуудай хорголжин тэжээл, 20 ш ашигт долооц, 38,05 тн хужир, 65 кг жамц давс байршуулж биотехникийн арга хэмжээ авсан байна. | |
| 183 | 5.2.3. Хүн амыг эрүүл ахуйн шаардлага хангасан ундны усаар хангана. | 1. Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 70 | Сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний хүрээнд энэ онд нийт 30 арга хэмжээг тусган хэрэгжүүлж, төлөвлөгөөний нийт хэрэгжилтийн хувийг 88 хувьд хүргэсэн. | |
| 184 | | 2. Зарим сумдад цэвэршүүлэх усан сан барих | 2021 - 2022 | | | Аймгийн хэмжээнд гадаргын уснаас ундны усаа хангадаг 3 сум нь Заг, Баянбулаг, Гурванбулаг юм. Энэ онд Баянбулаг сумын төвд унд, ахуйн усны зориулалтаар инженерийн хийцтэй гүн өрмийн 1 худгийг гаргаж, зун, намар, хаврын улиралд ашиглах боломжтой болсон. | |
| 185 | 5.3.1. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ. | 1. Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 - 2024 | | 50 | Аймгийн ИТХ-ын 2021 оны 131 дүгээр тогтоолоор "Хог хаягдлын менежментийг сайжруулах аймгийн хөтөлбөр" баталсан. Энэ хүрээнд:Баянхонгор, Хүрээмарал, Заг сумдын ОНХС-ын нийт 298,3 сая/төг, Баянцагаан сум байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаас 20,0 сая төгрөг, Галуут, Гурванбулаг сумдад уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн хандиваар шинэ хогийн цэгийг байгуулж, хашиж хамгаалсан. Гурванбулаг сум ОНХС-ын 12,0 сая төгрөгийн санхүүжилтээр сумын хогийн цэгээ иж бүрэн камержуулсан. Аймгийн хэмжээнд аюултай хог хаягдлын тооллогыг зохион байгуулсан. Уул уурхайн аж ахуйн нэгж, эмнэлгийн байгууллага, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ерөнхий боловсролын сургуулиудад хадгалагдаж байсан 206,7 кг хуурай, 436,6 л шингэн химийн хорт бодисыг "Түмэн эгшиг" ХХК Улаанбаатар хот руу тээвэрлэн мэргэжлийн байгууллагад хүргүүлсэн. Хог хаягдлын талаарх хууль тогтоомжийг сурталчлах сургалт, нөлөөллийн арга хэмжээг 87 удаа зохион байгуулж нийт 258 төрийн албан хаагчид, 812 иргэд, ерөнхий боловсролын сургуулийн 2064 сурагчид сургалтад хамрагдаж, Баянбулаг,Заг сум 400 ширхэг гарын авлага бэлтгэн иргэдэд тараан мэргэжил арга зүйгээр ханган ажилласан.Насан туршийн боловсролын төв, Байгаль орчин, аялал жуулчлалын газар, "Баянхонгор тохижилт үйлчилгээ", "Цэвэр хот" ОНӨААТҮГ хамтран “Тэрбум мод” үндэсний төслийн хүрээнд ногоон хөгжил, хог хаягдлыг бууруулах чиглэлээр 35 төрийн байгууллага, 5 аж ахуй нэгжийн 80 албан хаагчдад орчны үнэлгээ хийж, төлөвлөгөө боловсруулах арга зүйн сургалт, "Эко Баянхонгор" төсөл хамтран “Тогтвортой хөгжил ба хог хаягдлын менежмент” сэдвээр сургалт нөлөөллийн ажлыг 146 төрийн болон төрийн бус байгууллагын ажилтан, 9 багийн Засаг дарга нарт, Насан туршийн боловсролын төвөөс нэгжийн 22 менежер, 6 багшид “Хог хаягдлын менежмент” сэдвээр сургалт зохион байгуулж, чадавхжуулан сургагч багш бэлтгэсэн. Бэлтгэгдсэн 22 нэгжийн менежерүүд харьяа сургуулийн “Эко” клубийн нийт 24 багш, 218 сурагчдад сургалт зохион байгуулж ажилласны үр дүн хөтөлбөрийн хэрэгжилт 78,5 хувьтай байна. | |
| 186 | 5.3.2. Баянхонгор сумын гэр хорооллыг цэвэр усны болон дулааны шугамд шат дараатайгаар холбоно. | 1. Баянхонгор сумын 4, 5 дугаар багийн гэр хорооллын айл өрхүүдийг цэвэр ус, дулааны шугам сүлжээнд холбох | 2022 - 2024 | | 60 | Аймгийн ОНХС-ийн 350,0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 4 дүгээр багийн 6, 7 дугаар гудамжны дундуур дулаан, цэвэр усны 1 км шугам сүлжээний ажлыг хийж гүйцэтгэн ашиглалтад оруулсан. Залуус амины орон сууцны хорооллын гадна шугам сүлжээ болон Баянхонгор аймгийн гэр хорооллын шугам сүлжээний ажлын зургийг иж бүрнээр нь “ДНТ” ХХК-иар 2022 онд гүйцэтгүүлсэн. Тус ажлын хүрээнд улсын төсвийн 27 тэрбум төгрөгөөр гэр хорооллын инженерийн шугам сүлжээний ажлын тендерийг зарлаж "Б софт" ХХК-тай гэрээ байгуулан ажлыг эхлүүлсэн бөгөөд 4, 5 дугаар багт | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2023 онд шугам сүлжээний ажлыг хийхээр төлөвлөгөө батлагдсан. | |